




Save the Children

**ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН
ХОХИРОГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТҮР ХАМГААЛАХ
БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
СТАНДАРТЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**



**ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН
ХОХИРОГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТҮР ХАМГААЛАХ
БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
СТАНДАРТЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Захиалагч: Хүүхдийг Ивээх Сан

Гүйцэтгэгч: Социологийн Боловсролын Төв ТББ

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Баяндалайн Баярмаа
Нямсүрэнгийн Онон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Хорлоогийн Балдандорж

НҮБ-ын Итгэлцлийн сангийн санхүүжилттэй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд боловсруулав.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөрийн газар | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар- 13, Монгол улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org | Судалгааны тайланг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2022 он

АГУУЛГА

ТАЛАРХАЛ.....	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТЫН ХҮРЭЭ	7
НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ	8
1.1. Үнэлгээ хийх үндэслэл, хэрэгцээ	8
1.2. Үнэлгээний зорилго, зорилт	9
1.3. Үр дүнгийн хураангуй	9
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	11
2.1. Үнэлгээний арга зүй, аргачлал	11
2.2. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан аргачлал	12
2.3. Үнэлгээний хамрах хүрээ, түүвэрлэлт, тоо хэмжээ	13
2.4. Мэдээллийн чанарын хяналт, ёс зүйн дүрэм	14
2.5. Мэдээлэл боловсруулсан арга	15
2.6. Судалгааны хязгаарлагдмал тал, бэрхшээл	15
ГУРАВ. ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	16
3.1. Олон улсын болон үндэсний хууль эрх зүйн зохицуулалт	16
3.2. Түр хамгаалан байршуулах, Нэг цэгийн үйлчилгээний төвд холбогдох журам, стандарт ..	21
3.3. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа	23
ДӨРӨВ. ТҮР ХАМГААЛАХ БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, СТАНДАРТЫГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	39
4.1. Баримт бичгийн судалгааны тойм	39
4.2. ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал (Стандарт ажиглалтын үр дүн)	41
4.3. ТХБ, НЦҮТ-ийн стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал (Ярилцлагын үр дүн)	63
ТАВ. ДҮГНЭЛТ	75
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ	78
ДОЛОО. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	82
НАЙМ. ХАВСРАЛТ СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, МАТЕРИАЛУУД	84
1. ГАНЦААРЧИЛСАН СУРВАЛЖИЛГА ХИЙХ УДИРДАМЖ	85
2. МЭРГЭЖИЛТЭН, АЛБА ХААГЧДЫН ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ АСУУМЖ	88
3. ТХБ, НЦҮТ-ИЙН СТАНДАРТАД ОРОЛЦСОН АЖИГЛАЛТААР ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, ҮР ДҮН	93
4. БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА	106
5. ТХБ, НЦҮТ-ийн жагсаалт	107
6. ТХБ ба НЦҮТ-д мөрдөгдөж буй журмууд	111

ТАЛАРХАЛ

Энэхүү тайланг НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүгийн дэмжлэг, Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн менежер Э.Цолмон, төслийн зохицуулагч Э.Жаргал, төслийн ажилтан Б.Баярмаа нарын зөвлөгөө, идэвхтэй хамтын ажиллагаанд тулгуурлан бэлтгэн гаргалаа. Судалгаанд ашигласан асуумж, хэрэглэгдэхүүнийг сайжруулахад Хүүхдийг Ивээх Сангаас онцгойлон хүчин зүтгэл гаргаж ажилласан гэдгийг дурдах нь зүйтэй. Тайлангийн үндсэн зорилго нь Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартад үнэлгээ хийж, цаашдын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гаргахад чиглэж байна.

Энэхүү тайланг Социологийн Боловсрол төвийн зөвлөхүүд бичиж стандартын хэрэгжилтийг үнэлэх тайланг бичсэн болно.

Түүнчлэн болон төслийн оролцогч байгууллага болох ГБХЗХГ-ын албан дэмжлэг, аймаг дүүргийн Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн газрын албан хаагчдын зүгээс энэхүү тайланг бэлтгэн гаргахад үнэтэй санал бодлоо хуваалцаж, хувь нэмэр үзүүлсэн болохыг онцгойлон тэмдэглэж байна.

СУДАЛГААНЫ БАГИЙН АХЛАГЧ:	СОЦИОЛОГИЙН УХААНЫ ДОКТОР, М.БАТБААТАР
БАГИЙН ГИШҮҮД:	ТӨРИЙН УДИРДЛАГЫН ДОКТОР, С.ТУЯА СОЦИОЛОГИЙН УХААНЫ МАГИСТР, Д.ОЮУНЦЭЦЭГ
ОРЧУУЛАГЧ:	ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ МАГИСТР, Б.ЦАГААНБАЯР ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН МАГИСТР, Х.НУРЖАН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
СБТ	Социологийн Боловсрол төв
ТХБ	Түр хамгаалах байр
ҮАСЖ	Үйл ажиллагааны стандарт журам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХИС	Хүүхдийг Ивээх сан
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХХХҮ	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Судалгааг хэрэгжүүлсэн аргачлал, үйл ажиллагааны тойм	11
Зураг 2.2.	Хамрах хүрээ	13
Зураг 3.1.	Хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны төрлүүд.	22
Зураг 4.1.	Стандартад нийцсэн байртай БГД-ийн ТХБ.	50
Зураг 4.2.	Стандартад нийцсэн байртай БГД-ийн ТХБ-ны оффис, ярилцлагын өрөө.	51
Зураг 4.3.	Стандарт дунд зэрэг хангасан байртай ХУД-ийн НЦҮТ.	52
Зураг 4.4.	Стандарт дунд зэрэг хангасан байртай ХУД-ийн НЦҮТ-ийн гал тогоо, оффис	52
Зураг 4.5.	Стандарт хангаагүй байр: СБД, НЦҮТ	53
Зураг 4.6.	ЖСХ-ийн хохирогчтой ажиллах нийгмийн ажилтнуудад тулгамдаж буй асуудал	61

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 4.1.	Судалгаанд оролцогчдын албан тушаал (хувиар)	64
График 4.2.	НЦҮТ-ийн ажилтнуудын орлогын бүлэг (тоогоор).	66
График 4.3	Сарын орлого ба өдөр тутмын хэрэгцээгээ хангах байдал.	66
График 4.4.	Ажилтнуудын ажил албаны чиг үүргийн давхцал	71
График 4.5.	ТХБ, НЦҮТ-ийн ажилтны ёс зүйн байдлын үнэлгээ	71

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 2.1.	Үнэлгээ хийх арга, зорилт, судлах зүйл	12
Хүснэгт 2.2.	Түүврийн тоо хэмжээ	13
Хүснэгт 2.3.	Тоон мэдээлэл цуглуулалтын арга болон чанарын хяналтын төрөл	14
Хүснэгт 3.1.	Үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүд	23
Хүснэгт 4.1.	Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын ерөнхий мэдээлэл	41
Хүснэгт 4.2.	ТХБ ба НЦҮТ-ийн стандартын хэрэгжилт.	42
Хүснэгт 4.3.	Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын ерөнхий мэдээлэл	46
Хүснэгт 4.4.	ТХБ-ны үйл ажиллагааны онцлог	47
Хүснэгт 4.5.	НЦҮТ-ийн үйл ажиллагааны онцлог.	47
Хүснэгт 4.6.	НЦҮТ болон ТХБ ажиллаж байгаа ажилтнууд, бэлгийн хүчирхийллийн хохирогчийн талаарх мэдээлэл	54
Хүснэгт 4.7.	НЦҮТ, ТХБ-ны үйлчилгээг 1-5 оноогоор үнэлсэн байдал.	56
Хүснэгт 4.8.	2020, 2021 онуудын ор хоногийн урсгал зардал.	58
Хүснэгт 4.9.	Нэг хүнд ноогдох хувьсах зардал, төгрөгөөр	58
Хүснэгт 4.10.	2020, 2021 онд үйлчилгээ авсан хүний тоо (харьяаллаар).	60
Хүснэгт 4.11.	Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын харьяалал(аймаг, нийслэл).	63
Хүснэгт 4.12.	Албан хаагчдын нас, хүйсийн байдал	64
Хүснэгт 4.13.	Албан хаагчдын боловсролын байдал.	65
Хүснэгт 4.14.	Судалгаанд оролцогчдын ажлын байранд ажиллах болсон шалтгаан	65
Хүснэгт 4.15.	Сарын дундаж цалин орлого	66
Хүснэгт 4.16.	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудад тавигдах нийтлэг шалгуур, чиг үүрэг	67
Хүснэгт 4.17.	ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдэд тулгамдаж буй бэрхшээл, санал бодол.	68
Хүснэгт 4.18.	ТХБ, НЦҮТ-өөс үзүүлж байгаа мэргэжлийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ	69
Хүснэгт 4.19.	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын үйл ажиллагааны үнэлгээ.	69
Хүснэгт 4.20.	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг	70
Хүснэгт 4.21.	Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг болон ур чадварын үнэлгээ	72
Хүснэгт 4.22.	Хөдөлмөрийн нөхцөл	73

НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТЫН ХҮРЭЭ

Тухайн үнэлгээний судалгааг хийхдээ Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын болон үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдтэй уялдуулан дараах нэр томьёо, ойлголтын хүрээнд гүйцэтгэв.

Жендэр - Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг; (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УИХ, 2011).

Жендэрийн эрх тэгш байдал - Эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг; (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УИХ, 2011).

Жендэрт суурилсан хүчирхийлэл - Жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг; (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УИХ, 2021 оны шинэчилсэн найруулга)

Бэлгийн дарамт - Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг; (Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УИХ, 2011)

Нийгмийн ажилтан - Баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг; (Хүүхэд хамгааллын тухай хууль, УИХ, 2016)

Түр хамгаалах байр - гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг; (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, УИХ, 2016)

Нэг цэгийн үйлчилгээ - Хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг; (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, УИХ, 2016)

1.1 Үнэлгээ хийх үндэслэл, хэрэгцээ

Монгол Улсад охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд тодорхой ахиц, өөрчлөлтүүд гарч байгаа боловч Ковид-19 цар тахлаас үүдэлтэй ажилгүйдэл, ядуурал ихсэж, олон гэр бүлд хүнд хэцүү нөхцөл байдал үүссэн нь охид эмэгтэйчүүдэд жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлжээ. Хүүхдийн тусламжийн утасны дуудлага, гэр бүл хүүхэд залуучуудын газар болон цагдаагийн байгууллагын статистик дүн мэдээ үүнийг батлан харуулж байна. Ийм нөхцөлд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог бэхжүүлэх, хүүхдийн оролцоог дэмжих, хүчирхийллийн мэдээллийг цуглуулах чиглэлд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Төслийн хяналт, үнэлгээний ажлын хүрээнд суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ, мэдлэг, хандлага, дадлын үнэлгээг хийн, хүүхэд хамгаалал, түүний тоон мэдээлэл цуглуулах бүтэц тогтолцоонд учирч буй асуудал бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаар зөвлөмж, удирдамж боловсруулан шийдвэр гаргагчдад хүргүүлэхээр ажиллаж байгаа болно.

Монгол Улсад 2017 онд ЖСХ-ийн хохирогчид чиглэсэн Түр хамгаалан байршуулах үйлчилгээ үзүүлэх журмыг баталсан боловч тухайн үйлчилгээ төрийн ба төрийн бус байгууллагын харьяалал, байгууллагын байршил, онцлогоос хамааран стандарт харилцан адилгүй байгаа юм. Ялангуяа энэхүү үйлчилгээг хүргэх түр хамгаалан байршуулах болон нэг цэгийн үйлчилгээний төвүүд нийслэлийн хэмжээнд хомсдолтой, зарим дүүргүүдэд байдаггүй. Мөн зарим дүүрэг, орон нутагт тухайн үйлчилгээг нэр төдий үзүүлэх явдал ч мэр сэр байдаг (Х.Энхжаргал, Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, 2017) [1] ажээ.

Иймд дээрх хэрэгцээ шаардлагад тулгуурлан Социологийн Боловсрол төв судалгаа, сургалт явуулдаг туршлага, мэргэшсэн хүний нөөцийн давуу талд тулгуурлан НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр, Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний стандартад үнэлгээ хийсэн болно. Тухайн асуудлаар тоон ба чанарын мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлыг үнэлэх, тодорхойлох судалгаа хийж, хууль эрх зүй бодлогын шинжилгээ хийсэн юм.

1.2 Үнэлгээний зорилго, зорилт

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь дараах багц үйл ажиллагаанаас бүрдэж байгаа болно. Үүнд:

- ЖСХ-ийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байр (ТХБ), Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж асуудлыг илрүүлж, дүгнэлт, зөвлөмж гаргах
- Баримт бичгийн дүн шинжилгээ хийх, тоон ба чанарын мэдээлэл цуглуулах
- ТХБ болон НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээнд (хүрэлцээ, хүртээмж, уян хатан байдал, тохиромжтой байдал, аюулгүй байдлыг хангаж байгаа байдал, зөвшөөрөл авах, нууцлал хадгалах, мэдээлэл цуглуулах, мэдээллийн удирдлага, бусад байгууллагад холбон зуучлах ба зохицуулах гм.) үнэлгээ өгөх
- ТХБ болон НЦҮТ-ийн хүний нөөцийн чадавхыг үнэлж, шийдэх асуудлыг тодорхойлох, зөвлөмж өгөх
- Үнэлж буй асуудлын чиглэлээр хэрэгжиж байсан болон хэрэгжиж байгаа төрийн болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн уялдааны зураглал хийх, зөвлөмж гаргах

1.3 Үр дүнгийн хураангуй

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх Сан “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд ТХБ, НЦҮТ-ийн ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартад үнэлгээ хийх гүйцэтгэгчээр Социологийн Боловсрол төв 2022 оны 2 сараас эхлэн ажилласан. Тус судалгааг ажлын даалгаварт тусгасан зорилго болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу хийж гүйцэтгэлээ.

Төслийн ажлын хүрээнд тулгуурлан стандарт ажиглалтын судалгаанд хамрагдсан 12 ТХБ, НЦҮТ-ийг хамруулсан бол, стандартыг үнэлэх асуумж судалгаанд нийслэл, аймгийн нийт 40 мэргэжилтэн, албан хаагч, чанарын судалгаа болох ганцаарчилсан ярилцлагад нийт 13 мэргэжилтэн, төлөөлөл хамрагдсан.

Хууль эрх зүйн шинжилгээнээс үзэхэд ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний талаар хууль эрх зүйн орчин бүрдэж, тухайн үйлчилгээний хувьд журам, стандарт батлан гаргасан зэрэг үр дүнгээс үзэхэд Монгол Улсад хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд эрх зүйн орчин сайжирсан гэдэг нь харагдаж байна. Гэвч жендэрт суурилсан хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид ТХБ, НЦҮТ-өөр үзүүлэх үйлчилгээний эрх зүйн зохицуулалтын хувьд ямар нэг байдлаар зохицуулагдаагүй, эргэлзээтэй зохицуулалтууд байсаар байгаа нь цаашид дээрх ойлголтыг нэг мөр болгох, үйлчилгээг ЖСХ-ийн хохирогчийн хэрэгцээнд нийцүүлэн шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт зохицуулалтууд оруулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай холбоотой 2017 болон 2019 онуудад 2 үнэлгээ хийгдсэн байна. Эхнийх нь “Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ” удаах нь “Нэг цэгийн үйлчилгээний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ” юм. Харин 2020 онд түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийгдсэн нь “Нэг

цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа” байв. Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны үйл ажиллагаатай холбоотой нийт гурван үнэлгээний судалгаа хийгдсэн бөгөөд ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлсэн судалгаа огт хийгдээгүй байна.

ТХБ, НЦҮТ-ийн өнөөгийн байдал, стандартын хэрэгжилтийг үнэлэхдээ стандарт ажиглалт, ганцаарчилсан ярилцлага болон асуумж судалгааны аргуудыг ашигласан болно.

ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтэд хийсэн үнэлгээ (Судалгаанд нийт 12 ТХБ, НЦҮТ хамрагдсан)-нээс үзэхэд ихэнх ТХБ, НЦҮТ-ийн хувьд шаардлагатай хүний нөөц байхгүй, төсөв хомсдолтой, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл хангалттай биш байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ харилцан адилгүй, хууль эрх зүйн зохицуулалт сул, стандартын хэрэгжилт шаардлага хангахгүй байна.

Ганцаарчилсан ярилцлагын судалгаанд нийт 12 ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтэн, албан хаагч хамрагдсан. Тус судалгааны үр дүнгээс үзэхэд Түр хамгаалах байранд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүдийн ирэх тохиолдол цөөн бөгөөд ирсэн үйлчлүүлэгчид нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны хүүхдүүд (7.9%) байна. ТХБ нь үйлчилгээ үзүүлэхдээ тэдний аюулгүй байдлыг хангах, анхан шатны хэрэгцээг хангах үйлчилгээг түлхүү үзүүлдэг. Харин НЦҮТ-өөр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх хувийг бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд (92.1%) эзэлж байна. НЦҮТ-ийн зүгээс тухайн эмэгтэйчүүдэд баримт нотолгоо бүрдүүлэх, эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээг голчлон гүйцэтгэж байна.

Асуумж судалгаанд нийт 40 мэргэжилтэн, албан хаагч хамрагдсан. Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээг сайжруулахын тулд авч үзэх зайлшгүй шаардлагатай асуудал бол тухайн байгууллагад ажиллаж байгаа мэргэжилтэн ажилтнуудыг урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хууль эрх зүйн заалтаар бий болгож өгөх, мөн одоо ажиллаж буй мэргэжилтэн албан хаагчдын үр чадварыг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнд тогтмол хамруулдаг байх хэрэгтэй гэж албан хаагчид үзэж байна. Байгууллагын зүгээс нийгмийн ажилтнуудыг өөрт байгаа бүхий л нөөц бололцоогоо ашиглан үйлчилгээгээ хүргэдэг байхыг шаарддаг ч ажилтнаа дэмжсэн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх таатай орчин нөхцөлийг нь бүрдүүлдэггүй болох нь судалгааны үр дүнгээр нотлогдсон юм. Түр хамгаалах байрны мэргэжилтнүүдийн дийлэнх хувь нь шинэ залуу ажлын туршлага бага боловсон хүчин, мэргэжлийн бус албан хаагчид байгаа нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байгаад анхаарч, мэргэжлийн хүний нөөцийг бий болгох явдал чухал байна. Цалин орлого, ажлын таатай орчин зэрэг нь ажлын үр бүтээмжид нөлөөлж байдаг учраас энэ тал дээр нийгмийн ажилтан, албан хаагч, мэргэжилтнүүдийг дэмжсэн бодлого, шийдвэр хэрэгтэй байгаа тухай саналыг дэвшүүлж байлаа.

ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Үнэлгээний арга зүй, аргачлал

ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний стандартыг үнэлэх арга зүйг боловсруулахдаа ЖСХ-ийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон суурь судалгааны тайлан, төслийн баримт бичигт тулгуурлана. Өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо тоон ба чанарын судалгааны арга зүйг хослуулан хийсэн. Энэхүү судалгааг тоон (цахим асуумж) ба чанарын (ганцаарчилсан ба бүлгийн сурвалжилга, баримт бичгийн шинжилгээ) мэдээлэл цуглуулах аргад тулгуурлан хийсэн болно.

Зураг 2.1. Судалгааг хэрэгжүүлсэн аргачлал, үйл ажиллагааны тойм



Үнэлгээний мэдээлэл цуглуулахад баримт бичиг судлах, ажиглалт хийх чанарын аргуудыг үндсэн арга болгохын зэрэгцээ төслийн гол оролцогч талуудаас асуулга, экспертийн болон ганцаарчилсан сурвалжилгын аргыг ашиглан мэдээлэл цуглууллаа. Анкет-асуумжийн аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-25.0”-ыг хэрэглэн боловсруулсан. Цуглуулсан мэдээлэлд анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг тооцохын зэрэгцээ, шинээр хувьсагч үүсгэх, логик ангилал гаргах, харьцуулалт болон уялдаа холбооны зураглал хийх зэрэг аргачлалыг ашиглаж нэгтгэн дүгнэсэн болно.

2.2 Үнэлгээний мэдээлэл цуглуулсан аргачлал

Социологийн Боловсрол төвийн баг тус үнэлгээг хийхдээ баримт бичгийн шинжилгээ, санал асуулга, ганцаарчилсан ба бүлгийн ярилцлагын аргуудыг хэрэглэхээр төлөвлөсөн ба холбогдох удирдамж, хэрэглэгдэхүүнийг боловсруулсан.

Хүснэгт 2.1. Үнэлгээ хийх арга, зорилт, судлах зүйл

	Судалгааны арга	Зорилт	Сонгох баримт, судлах зүйл
1	Ганцаарчилсан сурвалжилга	Мэргэжилтэн алба хаагчидтай хийх ганцаарчилсан сурвалжилга	ТХБ болон НЦҮТ-дийн үзүүлж буй үйлчилгээнд (хүрэлцээ, хүртээмж, уян хатан байдал, тохиромжтой байдал, аюулгүй байдлыг хангаж байгаа байдал, зөвшөөрөл авах, нууцлал хадгалах, мэдээлэл цуглуулах, мэдээллийн удирдлага, бусад салбар байгууллагуудад холбон зуучлах ба зохицуулах гм) үнэлгээ өгөх
2	Асуумж судалгаа	ТХБ ба НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн чадавхыг үнэлэх асуумж	ТХБ болон НЦҮТ-ийн хүний нөөцийн чадавхыг үнэлж, шийдэх асуудлуудыг тодорхойлж, зөвлөмж өгөх
3	Стандарт ажиглалт	Оролцсон ажиглалтаар хийх стандарт үнэлгээний маягт	ТХБ, НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээний одоогийн стандартад үнэлгээ өгөх
4	Баримт бичгийн судалгаа	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн шинжилгээ хийх	ЖСХ-ийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх ТХБ, НЦҮТ дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх

- Хууль эрх зүй, бодлогын баримт бичигт хийх дүн шинжилгээ (Content analyse)
ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний стандарттай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон судалгааны тайлан, ЖСХ-ийн хохирогч төвтэй хянан шийдвэрлэх ажиллагаа, төслийн материал зэрэг хоёрдогч баримт бичиг, ажлын тайлан, үйл ажиллагаа, тухайн салбарт холбогдох мэргэжилтнүүдийн санал бодол, нотлох баримт бичигт дүн шинжилгээ хийсэн.
- Оролцсон ажиглалтын арга (Participatory observation)
Үйлчилгээний стандартыг үнэлэхдээ судалгааны зорилго, зорилттой уялдуулан ТХБ, НЦҮТ-өөс оролцоонд суурилсан ажиглалтын стандарт маягт ашиглан мэдээлэл цуглуулсан.
- Экспертийн буюу ганцаарчилсан сурвалжилга (Key Informant Interview)
Нийслэл, дүүргийн болон үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй ТХБ, НЦҮТ-өөс судалж буй асуудлын талаар гүнзгийрүүлж, нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор ярилцлага хийсэн.
- Анкет-асуумжийн арга (Survey)
ТХБ болон НЦҮТ-ийн хүний нөөцийн чадавхыг үнэлж, шийдэх асуудлыг тодорхойлж, зөвлөмж өгөхөд энэхүү аргыг ашиглах ба захиалагчтай тохиролцсоны үндсэн дээр батлагдсан асуумжийн маягт ашиглан мэдээлэл цуглуулсан болно. Түүврийн тоо хэмжээ, судалгааны талбарыг одоогийн НЦҮТ болон ТХБ-ны үйл ажиллагаанд тулгуурлан гаргасан.

2.3 Үнэлгээний хамрах хүрээ, түүвэрлэлт, тоо хэмжээ

Судалгааны түүврийн тооцоолол, тоо хэмжээнд нийцүүлэн дараах ТХБ, НЦҮТ, оролцогчдоос түүвэрлэлтийг мужилсан хэлбэрээр хийлээ. Судалгаанд баримт бичгийн судалгаа, ажиглалт, санал асуулга, ганцаарчилсан ярилцлагын аргыг тус тус ашигласан болно.

Зураг 2.2. Хамрах хүрээ

Үндэсний түвшинд	Хууль эрх зүй, бодлогын баримт бичигт үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан.
Орон нутгийн түвшинд	Аймаг (5), дүүргийн (7) ТХБ, НЦҮТ-ийн стандартад ажиглалт хийж, мэргэжилтэнтэй ярилцлага хийсэн.
Нэгж, үйлчилгээний түвшинд	ТХБ, НЦҮТ-д мөрдөгдөж буй стандарт, хэрэгжилтийн байдал, хүний нөөц, мэргэжилтний чадавхыг үнэлсэн.

Судалгаанд хамрагдаж буй аймаг болон дүүргээс, мөн үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулж буй нийт 7 дүүрэг, 5 аймгийн 12 ТХБ, НЦҮТ-д ажиглалт хийж, 40 мэргэжилтэн төлөөллөөс асуумж судалгаа авч, 13 эксперттэй ганцаарчилсан ярилцлага хийсэн болно.

ТХБ, НЦҮТ-д ажиллаж буй мэргэжилтэн, албан хаагчдын хувьд нийслэлд харьцангуй олон 4-10 хүртэл байгаа бол орон нутагт 1-3 хүртэл орон тооны албан хаагчид ажиллаж байгаа нь анхаарал татаж байна. Албан хаагчдын чадавхыг үнэлэх асуумж судалгаанд нийслэл хотоос 29(72.5%) албан хаагч оролцсон бол аймаг, орон нутгаас 11(27.5%) албан хаагч оролцжээ.

Хүснэгт 2.2. Түүврийн тоо хэмжээ

Байршил	ТХБ, НЦҮТ-ийн байршлууд	Асуумж судалгаа	Ганцаарчилсан ярилцлага	Стандарт ажиглалт
Нийслэл	УБ хот, 7 дүүрэг	29	7	7
Аймаг	Архангай аймаг	3	1	1
	Дорнод аймаг	1	1	1
	Орхон аймаг	1	1	1
	Завхан аймаг	3	1	1
	Сэлэнгэ аймаг	3	1	1
Нийт	12 талбар	40	13	12

Харин ганцаарчилсан ярилцлагад нийт судалгаанд хамрагдсан ТХБ болон НЦҮТ-ээс тухайн байгууллагын зохицуулагч, нийгмийн ажилтан, ахлах мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулсан болно. Стандарт ажиглалтыг Хохирогчийг түр хамгаалан байрлуулах нийтлэг шаардлага MNS 6040:2019-д тусгагдсан үзүүлэлтийг ашиглан ТХБ, НЦҮТ дээр судалгааны багийн гишүүд зочилж хийсэн болно.

2.4 Мэдээллийн чанарын хяналт, ёс зүйн дүрэм

Социологийн Боловсрол төвийн чанарын хяналтын баг нь 2015 онд байгуулагдсан бөгөөд судалгааны мэдээллийг цуглуулах, оруулах, боловсруулах үе шатуудад хяналт тавьж ажилласан юм. Тухайн баг мэдээлэлд гарч болох асуудлыг илрүүлж, бүртгэл хөтлөх улмаар тухайн алдааг засаж, залруулах байдлаар судалгааны үндсэн багт тогтмол дэмжлэг үзүүлж ажиллав. Батлагдсан арга зүйн дагуу тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, талбарын мэдээлэл цуглуулах үйл явцтай зэрэгцүүлэн чанарын хяналтыг өдөр тутам гүйцэтгэхэд анхаарсан болно.

Мэдээллийн чанарын шаардлагыг хангахын тулд Социологийн Боловсрол төвийн баг төслийн турш дотоод хяналтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Дотоод хяналтын үйл ажиллагааг бие даасан Чанарын хяналтын баг, судалгааны багийн ахлагч, ахлах судлаачид болон зохицуулагчийн удирдлага доор гүйцэтгэсэн болно.

Чанарын хяналтын баг нь дата менежер болон зохицуулагч нартай нягт хамтран ажилласан. Чанарын хяналтын баг нь дараах арга хэмжээнүүдийг нийт төслийн туршид гүйцэтгэж ирлээ. Мэдээлэл цуглуулалтын хяналт: Талбараас ирсэн мэдээллүүдэд өдөр тутам агуулгын хяналтыг хийсэн.

Хүснэгт 2.3. Тоон мэдээлэл цуглуулалтын арга болон чанарын хяналтын төрөл

Мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтын төрөл	Агуулгын хяналт	Аудио бичлэг, цахим мэдээлэлд тулгах хяналт хийх
Мэдээлэл цуглуулах арга	Чанарын хяналтын ажилтан нь цуглуулсан өгөгдлийг байнга хянаж, асуулгын логик бүтэц, уялдаа холбоог шалгаж, талбайн судлаачдад шаардлагатай зааврыг өгч байсан.	Энэхүү хяналтыг цугларсан нийт мэдээлэл оруулалтын 30%-д хийсэн ба нийт цугларсан асуумжаас сонгож хийнэ. Анкет тус бүрийн мэдээллийн санд оруулсан өгөгдлийн алдаагүй байдал 95-аас доошгүй хувьтай байв.

Мэдээллийн сангийн чанарын хяналт: Урьдчилсан мэдээллийн санг программын тусламжтайгаар хянаж, цэвэрлэсэн. Мэдээллийн санг бүхэлд нь судалгаа авах явцад хийгдсэн аудио бичлэгтэй тулгаж шалгах ажлыг чанарын хяналтын баг хийж гүйцэтгэсэн.

Зөвлөх баг нь судалгааг зохион байгуулахдаа Олон улсын социологийн холбооны “Ёс зүйн дүрэм”-ийг баримталсан. Мөн судалгаанд оролцогчидтой ярилцлага хийхдээ жендэр болон хүний эрхийн төвийг сахисан хандлага, жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан аргачлалыг ашигласан. Мөн шаардлагатай тохиолдолд төрийн байгууллагуудад нууцлалын баталгаа гаргаж, ёс зүйн зарчмын хүрээнд ажилласан юм.

- Судалгаанд оролцогчийн нууцлал-Оролцогчийн хувийн мэдээлэл, нууцлалтай холбоотой зааварчилгааг талбарт ажиллах судлаачдын гарын авлагад тусгайлан оруулж өгсөн.
- Судалгаанд оролцогчоос зөвшөөрөл авах - Судалгаанд хамрагдах шалгуурт нийцсэн оролцогчийг сонгосны дараагаар судалгааны зорилго, ач холбогдлыг бүрэн тайлбарлаж, тухайн оролцогчоос судалгаанд хамрагдах боломжтой эсэхийг нь тодруулсан ба ингэснээр зөвхөн судалгаанд оролцохыг зөвшөөрсөн болон сайн дурын үндсэн дээр судалгаанд хамруулж аудио рекордероор баталгаажуулсан.
- Оролцоонд суурилсан арга-Судлаачид маань хөдөө орон нутаг, хот суурин газрын онцлог нөхцөл байдалд уялдуулж ажиллах ур чадвартай бөгөөд судалгаанд оролцогчийн нас

хүйс, боловсрол, бусад үр чадварын ялгаатай байдлаас нь үл хамааран бүх бүлгийн төлөөллийг зохистой түвшинд хамруулж оролцогч тус бүрийн хэрэгцээг илрүүлэхийг зорьж ажилласан.

- Хууль эрх зүйн болон судалгааны ёс зүйн хүрээ-тус төвийн судлаачид Олон улсын социологийн холбооны “Ёс зүйн дүрэм”, журмыг үйл ажиллагаандаа нягт баримталдаг. Мөн захиалагч тал/ХИС/-ын “Хүүхдийн аюулгүй байдлын бодлого”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажилласан. Түүнчлэн, манай байгууллага нь Монгол Улсын Статистикийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг чанд дагаж мөрддөг бөгөөд хувийн шинжтэй аливаа мэдээллийг гадагш задруулахыг хориглодог.

2.5 Мэдээлэл боловсруулсан арга

Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн аргачлал: Асуумжийн мэдээллийн нээлттэй асуултыг кодолж, хяналт хийж цэвэрлэсэн тоон өгөгдлийг мэдээллийн шинжилгээний SPSS-25 программд оруулж дан тоололт болон харьцуулсан шинжилгээг хийж гүйцэтгэн, үр дүнд шинжилгээ хийсэн. Харьцуулсан шинжилгээг нийгэм, хүн ам зүйн мэдээлэлд үндэслэн хийсэн. ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтэн, албан хаагчдын санал бодол, хандлагыг үнэлсэн үзүүлэлтүүдийн үр дүнд тулгуурлан статистик шинжилгээ хийлээ.

Чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн аргачлал: Ганцаарчилсан ярилцлагын мэдээлэл, ТХБ, НЦҮТ-ийн стандарт ажиглалтын мэдээллийг кодолж, зохих боловсруулалт хийсэн ба мэдээллийн давтагдаж буй өгөгдлүүдээс бүлэглэн суурь судалгааны үндсэн зорилго, зорилтууд болон тоон судалгааны үр дүнтэй харьцуулж үр дүнг тайлбарласан.

2.6 Судалгааны хязгаарлагдмал тал, бэрхшээл

Тус судалгааг хийхэд төрийн байгууллагын хүнд суртал, мэргэжилтэн, албан хаагчдын идэвх оролцоо тааруу байв. Мөн судалгааг сайн дурын оролцоонд тулгуурлан хийхтэй холбоотойгоор судалгаанд оролцох идэвх сул, мэдээлэл өгөхгүй байх явдал нийтлэг байсан нь судалгааны мэдээлэл цуглуулах үйл явц сунжрах, хугацаа алдах зэргээр судалгааны үйл явцад сөрөг нөлөө үзүүлсэн. Түр хамгаалах байр нь нууцлалын зэрэглэлтэй ажилладаг байгууллага тул судалгаа авах явцад тухайн байгууллага судалгаанд оролцохоос татгалзсан байр суурьтай байсан нь томоохон тулгамдсан асуудал болж байлаа. Тухайн асуудлыг Нийслэлийн ГБХЗХГ, ГБХЗХГ-аас судалгааг авах ажлыг дэмжин ажиллах зөвшөөрлийн албан бичгийг захиалагч байгууллагын хамтын зүтгэлийн дүнд гаргуулж авснаар тухайн тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж судалгааны мэдээлэл цуглуулахад түлхэц болов. Мөн судалгааны явцад тулгамдаж байсан бас нэгэн бэрхшээл бол судалгаанд оролцогч мэргэжилтнүүд ТХБ, НЦҮТ-ийн стандартын талаарх мэдлэг хомс байсан явдал юм. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагыг сонгон үнэлгээнд хамруулахыг зорьсон боловч байгууллагын нууцлалтай холбоотой гэсэн шалтгаанаар судалгаа өгөхөөс татгалзав. Тус судалгаанд оролцогч байгууллагуудад нууцлалын баталгаа гаргаж судалгааны ёс зүйн дүрмийн хүрээнд судалгааг авсан болно.

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

3.1 Олон улсын болон үндэсний хууль эрх зүйн зохицуулалт

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд чиглэгдсэн олон улсын эрх зүйн баримт бичгийг тоймлон үзэхэд, 10 гаруй Олон улсын гэрээ конвенц байдаг. Үүнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ-1948), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1976), ИБУТЭОУП-ын Ерөнхий дүгнэлт 28 (2000), Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт (1976), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1981), ЭАБХУТК-ийн Ерөнхий Зөвлөмж 12 “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” (1989), ЭАБХУТХ Ерөнхий Зөвлөмж 19, Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990), Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (2002), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (1987) зэрэг багтана.

НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооноос эрхлэн гаргасан 19 дүгээр зөвлөмжид Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцд тусгасан ялгаварлан гадуурхах бүх хэлбэр бол жендэрт суурилсан хүчирхийлэл мөн гэж үзжээ. Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь тухайн хүнд хүйсээр нь чиглэсэн хор хөнөөлтэй үйлдлийг хэлнэ. Энэ нь хүйсийн тэгш бус байдал, эрх мэдлээ урвуулан ашиглах, хор хөнөөлтэй хэм хэмжээнээс үүдэлтэй. Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хүний эрхийг ноцтойгоор зөрчиж, амь насанд заналхийлж буй хүний аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын томоохон асуудал юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан уг протоколд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самууныг сурталчлах зорилгоор олон улсын хэмжээнд хууль бусаар хил давуулан тээвэрлэх явдал мэдэгдэхүйц нэмэгдсэн, хүүхдэд аюултай секс аялал өргөжин, ялангуяа энэ нь хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлахад шууд нөлөө үзүүлж байгааг анхааруулахын сацуу бэлгийн хүчирхийлэлд өртөгсдийн харьцангуй дийлэнх хувийг бага насны охид эзэлж байгаа, интернэт болон бусад дэвшилтэт технологийн хүчээр хүүхдийг садар самуунд сурталчлах явдал нэмэгдэж байгаа зэргийг тус протоколын гол үндэслэл болгосон байдаг.

Харин үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол Улсад дараах хууль тогтоомж хэрэгжиж байна. Үүнд Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль зэрэг хэрэгждэг (ХНХЯ, 2019). Эдгээр хуулиудад ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний асуудлууд хэрхэн туссаныг энд нарийвчлан авч үзье.

Эрүүгийн хууль: Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргүүдийг Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан байдаг. Ингэхдээ гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг зөвхөн тодорхой гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 11.7-р зүйлд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэж тодорхойлсон Үүнд:

1. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон
2. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнтэй харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан,
3. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр хуульчилжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд уг гэмт хэргийг

1. Хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн,
2. Асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн,
3. Таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдлаар ял оноохоор хуульчилсан байна.

Дээр дурдсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс гадна Эрүүгийн хуулийн 10.1-р зүйл (Хүнийг алах), 10.4-р зүйл (Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх), 11.1-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.5-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах), 11.6-р зүйл (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах), 12.1-р зүйл (Хүчиндэх) гэх мэтээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой, гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй гэмт хэргүүдийн хүндрүүлэх нөхцөл байдлыг хуульчилж өгсөн байна. Тухайлбал хүнийг алахдаа бага насны хүүхэд аль эсвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүчиндэх гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж аль эсвэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж үйлдсэн бол оногдуулах ялыг хүндрүүлэхээр хуульчилсан.

Зөрчлийн тухай хууль: Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд тусгай зүйл заалтад (5.4-р зүйл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих) заасан бол хүнд гэмт хэргийг Эрүүгийн хуулиар зохицуулдаг. Зөрчлийн тухай хуульд 5.4.4.1-т Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, 5.4.4.2-т Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 5.4.4.3-т Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг бусадтай харилцахыг хязгаарласан, 5.4.4.4-т Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд нь халдсан гэсэн дөрвөн төрлийн үйлдлийг хуульчилж өгсөн байна. Үүнээс гадна Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх үүргээ биелүүлээгүй, түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн болон түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, өөр зориулалтаар ашигласан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль: 2004 онд Монгол Улсын УИХ-аас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг анх баталсан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чухал алхам болсон. Улмаар хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 онд баталж, одоо хэрэгжиж байна. Уг хуулийн зорилго нь “Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох” юм. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4.-т бэлгийн хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийллийн нэг хэлбэр болгон хуульчилж, хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг “...бэлгийн

халдашгүй байдлаараа хохирсон хүнийг” гэж тодорхойлж өгснөөр бэлгийн хүчирхийлэлд өртөгчийн эрхийг материаллаг хуулиар нарийвчлан хамгаалж өгсөн байна. Хэдийгээр бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг материаллаг хуулиар (Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль) хориглосон ч процессын хуулиар хохирогчийн зөрчигдсөн эрхийг хэрхэн нөхөн сэргээх, эрүүл мэнд, аюулгүй байдлын үйлчилгээ хэрхэн авч байгаагаар уг хуулийн хэрэгжилтийг үнэлэх шаардлагатай.

Энэ хүрээнд судалгааны багийн зүгээс гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, үүн дотор бэлгийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг хэрхэн хамгаалж, түүнд үйлчилгээ үзүүлж байгаа талаар үнэлгээ хийж, нөхцөл байдлыг судлахыг зорьсон болно. Улмаар хуулийн хэрэгжилтийг хангаж буй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/116 тоот тушаалаар батлагдсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам болон Хууль зүйн дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/132 хамтарсан тушаалаар батлагдсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журамд хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэнэ. ГБХТТ хуультай зайлшгүй холбоотой бас нэг зүйл бол хүүхдийг хүчирхийллээс хамгаалах юм. Үүнд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй. Мөн түүнчлэн хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архи дан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглох тухай заасан байдаг. Тус хуулийн 35-р зүйлд Түр хамгаалан байрлуулах үйлчилгээг мөн энэхүү хуулиар зохицуулсан байдаг. Энэ нь бүх төрлийн хүчирхийллийн хэлбэрт өртсөн, өртөж болзошгүй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, иргэдийг аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, нөхөн сэргээх нийгмийн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээ юм. Уг үйлчилгээний эцсийн зорилго бол хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах явдал бөгөөд 35.1-д Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ, 35.2-т Түр хамгаалах байрыг төрийн, төрийн бус байгууллагын харьяанд, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн харьяаллаар байгуулан ажиллуулж болно, 35.10-д Түр хамгаалах байрны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална гэж тус тус заажээ. (УИХ, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, 2016)

Зөрчлийн тухай хууль: Тухайн хуулийг 2017 онд баталсан ба хууль түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Тус хуулийн 5.4-т Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих буюу Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэмцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заажээ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. Уг хууль 2011 онд батлагдсан ба хуулийн зорилт нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хуулийн 4.1.8-д «жендэрт суурилсан хүчирхийлэл» гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж заажээ.

Хүүхдийн эрхийн тухай хууль: Энэ хууль нь анхлан 2016 онд батлагдсан ба 2021-04-08, 2021-12-17-ны өдрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан нийт дөрвөн бүлэг хорин хоёр зүйл бүхий хууль юм. Энэхүү хууль нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэ хуульд хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, уг хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэх бөгөөд хүүхдийн эрхийн зарчим, нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуульд тусгагдаагүй бол олон улсын гэрээний заалтыг хэрэглэж болно хэмээн заасан байдаг. Уг хуулийн үйлчлэх хүрээнд хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ хэмээн тусгажээ. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарах юм. Мөн Хуулийн 5.2-т хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй, 5.4-т хүүхэд төрөөс эмнэлгийн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй, 12.1.6-д хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа болон хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж батлуулах; 12.1.7-д онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах, шаардлагатай арга хэмжээ тухай бүр авах; 15.1.3-д эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангаж, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах; 17.1.6-д эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг түр байршуулах, асрамжлах, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх бүх шатны засаг дарга нарын үүрэг оролцоо зэргийг заасан байдаг. (УИХ, Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016)

Хүүхэд хамгааллын тухай хууль: Энэ хууль нь анхлан 2016 онд батлагдсан ба зургаан бүлэг хорин таван зүйл бүхий хууль юм. Тухайн хууль нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Уг хуульд хүүхэд хамгааллын зарчим, тогтолцоог Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно хэмээн заасан байдаг. Тэдгээрийг авч үзвэл хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Мөн хүүхэд хамгаалал гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй байхыг тодорхойлсон. Хүүхэд хамгааллын тогтолцоог хэрэгжүүлэхэд хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар оролцогч талуудаас авч хэрэгжүүлэх бодлого, хамтын ажиллагаа, цогц үйлчилгээ, статистик мэдээлэл, санхүү төсөв, мэргэшсэн хүний нөөц зэргийг зайлшгүй бүрдүүлсэн байхыг шаарддаг билээ. Хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх, хамгаалах талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно. Тус хуулийн 10.2-т Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ(УИХ, Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016) хэмээн заажээ.

Хуулийн 10-р зүйлд тусгаснаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг дараах онцлогтой үзүүлнэ. Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас

суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлэхээр тусгасан. Үүнд:

- Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах;
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх;
- Аюулгүй байдлыг хангах;
- Дэмжих, холбон зуучлах;
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх;
- Гэр бүлд нь эргэн нэгтгэх.

Нийгмийн халамжийн тухай хууль: Энэ хууль нь 2012 оны 1 дүгээр сарын 19 өдрөөс хэрэгжиж эхэлсэн ба нийт найман бүлэг гучин хоёр зүйл бүхий хууль юм. Тус хуульд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоох, нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг зарцуулах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө хэмээн баталсан. Тус хуулийн 18-р зүйл болох Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх тухай 18.1.4-д түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах талаар тусгажээ. Хуульд тусгаснаар халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт нь амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, шинэ төрлийн үйлчилгээ турших болон хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас нийгмийн халамжаас хасагдсан иргэнд үзүүлэх үйлчилгээний зардалд ашиглана. Үүнээс гадна амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал, нийгмийн ажилтны чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх сургалт, бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, шинэчлэхтэй холбогдсон зардал, нийгмийн халамжийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх судалгаа, шинжилгээ, үнэлгээний зардал, холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрсөн бусад үйлчилгээний зардалд ашиглагдана(УИХ, Нийгмийн халамжийн тухай хууль, 2012) хэмээн тусгасан. Иймд халамжийн сан дээр дурдсан зориулалтаар зарцуулагдах учир ТХБ, НЦҮТ-ийн нөхцөлийг сайжруулах, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах ажлуудад санхүүжилтийг зориулах боломжтой байна.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль: Энэ хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход чиглэсэн хууль юм. Хуулийн зохицуулалтад хамаарах хүрээнд гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагч хамаарна. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны зарчим нь гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна хүний хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцлалыг хамгаалах, шуурхай байх, хамтран ажиллах зэрэг багтана. Мэдээллийн нууцлалыг хангахад хамгаалалтад байгаа гэрч, хохирогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газар, өмчлөлд нь байгаа үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар зэрэг мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэлийн талаарх мэдээлэлд өөрчлөлт оруулах, зохиомол нэр хэрэглэх, харилцах утасны дугаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөрчлөх зэрэг арга хэмжээг эрх бүхий албан тушаалтан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ. (УИХ, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, 2013)

Эрүүл мэндийн тухай хууль. Энэ хууль нь 2011 оны 5 сарын 5-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн нийт есөн бүлэг дөчин долоон зүйл бүхий хууль юм. ЭМТ хууль нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах үүрэг бүхий хууль юм. Уг хуулийн хэрэгжилтийн хүрээнд ТХБ, НЦҮТ-үүд эрүүл мэндийн төвтэй хамтран хүчирхийллийн хохирогч үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх (УИХ, Эрүүл мэндийн тухай хууль, 2011) тухай дурджээ.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, түр хамгаалах байрны үйл ажиллагаа, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд дээр дурдсан хуулиуд нь хамааралтай. Эдгээр хуулиудад дурдсан байгууллага, үйлчилгээнүүдийн чиг баримжаа, зохицуулалт, бүрэн эрх, хэм хэмжээ, шалгуур зэргийг бий болгож буй хууль эрх зүйн үндсэн орчин юм.

3.2 Түр хамгаалан байршуулах, Нэг цэгийн үйлчилгээний төвд холбогдох журам, стандарт

“Түр байршуулан хамгаалах үйлчилгээ үзүүлэх журам” Энэхүү журам нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар 2017 оны 06 дугаар сарын 23 өдөр батлагдсан журам юм. Тус журам нь Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, өртөж болзошгүй эрсдэлт нөхцөлд байгаа иргэдийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй 24 цагийн түрш үнэ төлбөргүй үзүүлэх харилцааг зохицуулахаар баталсан билээ. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагаанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, зэрэг хуулиас гадна энэхүү журмыг баримтална гэж тусгасан байдаг. Уг журмаар удирдлага, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, НЦҮТ-ийн ажилтнуудын эрх, үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, санхүүжилт, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ зэргийг тусгаж өгсөн байдаг (ХНХЯ, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам, 2017).

“НЦҮТ-ийн аюулгүй байдалд хяналт тавих журам” Энэ журам нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид эмнэлэгт түшиглэн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үеийн аюулгүй байдалд хяналт тавих харилцааг зохицуулсан. Энэ нь үйлчлэгч болон ажилтнуудын аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавьж байгааг илэрхийлж байгаа юм. Мөн уг журамд нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг MNS:6040;2019 стандартыг хангасан байх шаардлагыг тавьжээ. Энэхүү журам нь хүүхэд, эрэгтэй эмэгтэй байхаас үл хамааран эрсдэлт нөхцөлд байгаа бүх хүнд нэг цэгийн үйлчилгээний төвөөр дамжуулан аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэтгэлзүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах зэрэг 7 төрлийн үйлчилгээг хүргэхийг зохицуулж өгсөн юм. Тус журамд аюулын зэргийг гурван түвшний хүрээнд авч үзсэн. Үүнд: аюулын зэргийг өндөр, дунд, бага гэж ангилсан байна. Эрх зүйн туслалцаа зөвлөгөөг утсаар болон цахимаар хүргэж үйлчилгээ үзүүлсэн талаарх бүртгэл, судалгааг нийгмийн ажилтан хөтлөхөөр тусган баталжээ. Мөн үйлчлүүлэгчийг өмгөөлөгчтэй холбон зуучлах үйлчилгээг нийгмийн ажилтан үзүүлэхийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн тавдугаар бүлэгт заасныг урьдал болгон баталжээ. НЦҮТ-ийн аюулгүй байдлыг хангахын тулд тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хөдөлгөөнт болон явган эргүүлийн чиглэлд байгуулж дотор болон гадна орчныг 24 цагаар камержуулахаар шийджээ. Мөн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага харьяаллын дагуу үйлчилж зайлшгүй тохиолдолд хойшлуулшгүй ажиллагаа явуулах ба хохирогч, хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах тохиолдолд аюулгүй байдлыг хангахаар заасан. НЦҮТ шашин болон улс төрийн үзэл номлолыг сурталчлах, ашгийн үйл ажиллагаа явуулахыг хориглохоор шийдвэрлэжээ. (ХЗДХЯ, 2017)

“Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ноогдох хувьсах зардал бодох тухай журам” Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнийг Түр хамгаалах байранд байрлуулж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах нэг хүнд ногдох хувьсах зардлыг тооцоход энэхүү журмыг баримтлах юм. Уг журамд заасан хувьсах зардлын бүрэлдэхүүн, зардал чиглүүлэгч болон зардлын дундаж нормативыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасны дагуу ТХБ-ны нэгэн адил үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төвийн хувьсах зардлыг тооцоход ашиглана. Мөн түр хамгаалах байранд байрлах хохирогчид төрийн бус байгууллагаас үзүүлсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төлбөрийг хувьсах зардлаас санхүүжүүлэхээр тусгасан. Энэхүү журмаар хувьсах зардлын бүрэлдэхүүн, зардал тооцох, хувьсах зардлын нийт хэмжээг тооцох зэргийг баталсан (ХНХЯ, Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ноогдох хувьсах зардал тооцох тухай, 2020).

Журмын дагуу, түр хамгаалан байршуулах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн зэрэгт тавих, түр хамгаалах байрны байршлыг нууцлах, хохирогчийн нэр төр, үнэ цэнэ, өөртөө итгэх итгэл үнэлэмж, хувийн нууцтай байх эрхийг хүндэтгэх, хохирогчийн зөвшөөрөл, оролцоог хангаж, хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх бүх үйл явцад хохирогчийн сонголт хийх, шийдвэр гаргах эрхийг хүлээн зөвшөөрөх, хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хохирогчдыг нас, хүйс, яс үндэс, нийгмийн гарал, боловсрол шашин шүтлэг, итгэл үнэмшил, үзэл бодол, гэрлэлтийн байдал, эдийн засгийн боломж, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байна. Түр хамгаалан байршуулах үйлчилгээ нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байршуулах үйлчилгээ үзүүлэх явдал юм. Уг үйлчилгээ түр хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хүргэнэ. Түр хамгаалан байршуулах үйлчилгээг нэг цэг болон түр хамгаалах байранд аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ гэсэн үндсэн долоон хэлбэрээр тухайн үйлчлүүлэгчийн онцлог нөхцөлд тохируулан үзүүлдэг байна. Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5-д заасан тодорхойлолтоор «түр хамгаалах байр» гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан тус хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ гэжээ. Олон улсын жишигтэй үүнийг харьцуулж үзэхэд дараах онцлог харагдаж байна.

Зураг 3.1. Хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байрны төрлүүд



Монгол Улсын хувьд Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлэх хугацааг авч үзвэл богино болон урт хугацааны гэж хоёр ангилж болох юм. Үүнд богино хугацаа гэдэгт 1-7 хоногийн хугацаанд үйлчилгээ үзүүлэх явдал юм. Харин урт хугацаанд 3 өдрөөс 3 сар хүртэлх хугацаанд үйлчилгээ хүргэхийг хэлнэ.

Түр байрлуулан хамгаалах үйлчилгээний онцлог нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн үйлчилгээний тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтлан хүүхэд хамгаалал, хүчирхийлэлд өртсөн иргэн, хүүхдэд тусламж үзүүлэх, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн болон хөгжлийн, асрах, холбон зуучлах үйлчилгээг үзүүлдгээрээ онцлогтой юм. Өнөөдрийн байдлаар ТХБ, НЦҮТ-ийн төвийн Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэн авч үзэхэд дараах байдал харагдаж байна.

Хүснэгт 3.1. Үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүд

Гол эрх зүйн баримт бичгүүд: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль Зөрчлийн тухай хууль Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль Эрүүгийн хууль Хүүхдийн эрхийн тухай хууль Хүүхэд хамгааллын тухай хууль	Бусад эрх зүйн баримт бичгүүд: Хөдөлмөрийн тухай хууль Төсвийн тухай хууль Эрүүл мэндийн тухай хууль Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
ТХБ үйлчилгээний журам, 2017 ТХБ нэг хүнд ноогдох хувьсах зардал НЦҮТ байгуулах тухай, 2009 НЦҮ үзүүлэх, санхүүжүүлэх журам, 2017 Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ журам	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах стандарт. MNS 6040, 2019 Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага. MNS6949:2021 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт, 2017

Хууль эрх зүйн шинжилгээнээс үзэхэд ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний талаар хууль эрх зүйн орчин бүрдэж, тухайн үйлчилгээний хувьд журам, стандарт батлан гаргасан зэрэг үр дүнгээс үзэхэд Монгол Улсад хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд эрх зүйн орчин сайжирсан болох нь харагдаж байна.

3.3 Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа

Хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Судалгаа нь Төлөвлөх, Хэрэгжүүлэх, Үнэлэх гэсэн гурван үндсэн үе шаттай.

1.1. Төлөвлөх үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

1.1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх Сан “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, стандартад үнэлгээ хийх зорилготойгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэв.

1.1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Энэхүү хэрэгжилтийн үр нөлөөний үнэлгээний судалгаагаар жендэрт суурилсан хүчирхийллийн

хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”¹ болон “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам”²-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ. Үнэлгээний хүрээг тогтоохдоо хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтад үнэлгээ хийнэ. Үүнд:

- а. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмаас дараах зүйл заалтыг сонгон авч, үнэлгээ хийнэ.

Заалт	Зохицуулалтын агуулга
2.2.	Түр хамгаалах байрыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна.
2.5	Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно.
2.7.	Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллага нь түр хамгаалах байрыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, <i>шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн</i> хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээг бүрэн үзүүлнэ.
5.1.	Түр хамгаалах байр нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

- б. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмаас дараах зүйл заалтыг сонгон авч, үнэлгээ хийнэ.

Заалт	Зохицуулалтын агуулга
1.1.	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
6.5.	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасны дагуу тооцож, санхүүжүүлнэ.

1.1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

ТХБ болон НЦҮТ-ийн журмаас үнэлгээ хийхээр сонгож авсан дээрх заалтуудыг “Зорилгод хүрсэн түвшин” болон “Практикт нийцэж байгаа байдал” гэсэн хоёр шалгуур үзүүлэлтээр шалгаж үзнэ. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр дээрх хоёр журам нь хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг шалгаж үзэх бол Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр дээрх хоёр журмын зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа талаар, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд үүсэж буй хүндрэлийг судална.

1.1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомж батлагдахаас өмнө болон хууль тогтоомж батлагдсанаас хойших нөхцөл байдлыг харьцуулж үзнэ. Тухайлбал 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнөх нөхцөл байдал болон хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа 2017 онд ТХБ болон НЦҮТ-ийн журмууд батлагдсанаар гарсан өөрчлөлтийг харьцуулах байдлаар судална.

1.1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

- а. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмаас дараах зүйл заалтыг сонгон авч, үнэлгээ хийнэ.

1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/116 дугаар тушаал

2 Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/132 дугаар хамтарсан тушаал

Заалт	Зохицуулалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал
2.2.	Түр хамгаалах байрыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна.	ТХБ-ыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр байгуулж байгаа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1-д заасан зорилгод хүрч байна уу?
2.5	Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно.	ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах зорилгодоо хүрч, төрөлжүүлэн байгуулсан эсэх? ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах нь практикт нийцэх үү?
2.7.	Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллага нь түр хамгаалах байрыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээг бүрэн үзүүлнэ.	ТХБ-ны үйлчилгээ бүрэн үйлчилгээ байж чадаж байна уу?
5.1.	Түр хамгаалах байр нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.	Цогц үйлчилгээг үзүүлэх зорилгодоо хүрч чадсан эсэх? ТХБ-ны үйлчилгээг үзүүлж буй практикт тулгарч буй бэрхшээлүүд юу вэ?

- b. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмаас дараах зүйл заалтыг сонгон авч, үнэлгээ хийнэ.

Заалт	Зохицуулалтын агуулга	Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал
1.1.	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээ ямар ялгаатай эсэх? НЦҮТ-ийн үйл ажиллагааны практикт үүсэж буй асуудал?
6.5.	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасны дагуу тооцож, санхүүжүүлнэ.	НЦҮТ-ийн санхүүжилт бодит байдал, практикт ямар байгаа талаар авч үзэх?

1.1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Мэдээллийг цуглуулахдаа тоон болон чанарын мэдээлэл ашиглалаа. Мэдээлэл цуглуулахдаа хууль болон журмыг хэрэгжүүлэн ажиллаж буй ТХБ болон НЦҮТ-ийн ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлага хийх, ТХБ болон НЦҮТ-ийн стандартад ажиглалт хийх, ажилтнуудаас асуумж авах, холбогдох хууль болон дүрэм журамд шинжилгээ хийх замаар мэдээллийг цуглуулсан болно.

Судалгааг хэрэгжүүлэх үе шат

“Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартыг үнэлэхдээ төслийн үр шимийг хүртэгч, зорилтот бүлгийн мэргэжилтэн, алба хаагч, холбогдох хүмүүсээс ганцаарчилсан сурвалжилга, чадавхыг үнэлэх асуумж, стандарт ажиглалт болон

баримт бичгийн шинжилгээний аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж ажиллалаа. Үүнд хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх ТХБ-5, НЦҮТ-7 төвийн үйл ажиллагааг судалсан болно.

Үнэлэх үе шат

Сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэх

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.2.	Түр хамгаалах байрыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулна.
--	---

ТХБ-ыг иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр байгуулж байгаа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1-д заасан зорилгод хүрч байна уу?

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “Улсын төсвийн хөрөнгөөр түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх” бүрэн эрхийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн чиг үүрэгт хамааруулан хуульчилж өгсөн байна. Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-д “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх” эрхийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хуулиар олгосон байна. Аймаг сум, нийслэл дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ч мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.3-т зааснаар “хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг үндэслэн ТХБ, НЦҮТ байгуулах” бүрэн эрхтэй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх, үүний төлөө хариуцлага хүлээх” гэж заасан, мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд нутгийн захиргааны байгууллагын үүргийг хуульчилж өгсөн байх ба хуулийн 28.1.2 болон 28.1.2-т гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан шийдвэрлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж, санхүүжүүлж байхаар хуульчилсан байна.

Иймд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТХБ-ыг байгуулах нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх зорилгод нийцсэн гэж үзэж байна.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.5	Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно.
---	--

ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах зорилгодоо хүрч, төрөлжүүлэн байгуулсан эсэх?

Судалгаанд хамрагдсан ТХБ-ны үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудаас төрийн бус байгууллагын эрхэлж (Талита Ази) буй нэг байгууллага бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод түлхүү үйлчилгээ үзүүлж, харьцангуй төрөлжсөн шинжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Судалгаанд хамрагдсан бусад ТХБ-ны хувьд төрөлжсөн үйл ажиллагаа явуулаагүй байх бөгөөд Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар ТХБ-дыг төрөлжүүлэн байгуулах зорилгод хараахан хүрээгүй байна гэж дүгнэлээ.

ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах нь практикт нийцэх үү?

ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага практикт тулгарч байна. Нэн ялангуяа, жендэрт суурилсан бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах хэрэгцээ шаардлага их байна. Үүнд дараах хэрэгцээ шаардлага, шалтгаан байдаг байна.

- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч болон бусад төрлийн хүчирхийллийн хохирогчийн (бие махбодын, үл хайхрах зэрэг) авч буй гэмтэл нь өөр байдаг байна. Өөрөөр хэлбэл бэлгийн хүчирхийллийн хохирогч илүү хүнд гэмтэл авсан байдагтай холбоотой.
- Бэлгийн хүчирхийллийн, бэлгийн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэргийн зарим хохирогч нар сөрөг зан үйлтэй болж бусад төрлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг уруу татах, хөтлөх, нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байдаг байна.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүнд гэмтэл авсан байдаг тул урт хугацааны үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагатай байдаг.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч нь зарим тохиолдолд халдварт өвчин тараах эрсдэлийг үүсгэж байдаг. (хоорондоо бэлгийн хавьталд орох, ахуйн болон бусад замаар халдвар тараах эрсдэлтэй байдаг)
- Гадагш мэдээлэл өгөх. Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь хэрэв зохион байгуулалттай гэмт бүлгийн сүлжээнд орсон бол тухайн сүлжээндээ бусад хохирогчдын талаар мэдээлэл өгөх эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг.

Дээрх шаардлагаар ТХБ-ыг төрөлжүүлэн байгуулах бол нэн түрүүнд бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн ТХБ-ыг байгуулах хэрэгцээ шаардлага байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогчийн онцлогийг хэрхэн харгалзаж, үйлчилгээ үзүүлж байгаа талаар ганцаарчилсан ярилцлагаар тодруулахад:

“Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүмүүст төвлөрч чадахгүй байгаа, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод тусламж дэмжлэг үзүүлж байна. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлэх тусдаа өрөө тасалгаа байхгүй. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг ирэхэд бусад байгууллагад мэдэгдэж, тусламж авдаг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдтэй ажиллах арга зүй, мэдлэг үр чадвар дутмаг байна.”

“Манайд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүн ирлээ гэхэд шүүд тийм тийм арга барилаар ажиллана гэсэн нэгдсэн стандарт байхгүй. Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллахад арга зүйн сургалт муу байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах, сэтгэл заслын сургалт гээд янз бүрийн сургалтуудад хамрагддаг. Харин яг бэлгийн хүчирхийллийн хохирогчтой яаж ажиллах вэ гэсэн сургалт байдаггүй.”

“Бэлгийн хохирогч хүүхдүүдийн тоо хөл хорионы үед тодорхой хэмжээнд өссөн байна. Өөрөөр хэлбэл 2020, 2021 онд болсон зүйл одоо илэрч мэдэгдэж байна. Яагаад гэхлээр гэр бүлийн хүмүүс болон хамаарал бүхий хүмүүс нь сүүлд мэдээд мэргэжлийн холбогдох байгууллагуудад мэдэгдэж байна. Жилдээ 5-7 хүүхэд байсан бол энэ жил 10-15 хүүхэд болоод байна. Нөхөн сэргээгдэх хугацаа цаг их ордог учраас мэргэжлийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх шаардлага их байна.”

“Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх стандарт, бүхий л журмуудыг барин ажиллаж байгаа, гэхдээ бэлгийн хүчирхийллийн хохирогчид арай өөр эрх зүйн үйлчилгээ, сэтгэл засал, нийгмийн ажлын үйлчилгээ шаардагддаг түүнийг үзүүлэн ажиллаж байгаа.”

“Урт хугацаанд хохирогч хүүхдүүд цаашдаа сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдах хэрэгцээ шаардлага байсаар байгаа боловч дутмаг үйлчилгээг үзүүлж байгаа. Мөн бэлгийн хүчирхийллийн хохирогчийн хувьд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг шаарддаг бол НЦҮТ зөвхөн анхан шатны гал унтраах байдлаар үйлчилгээг үзүүлж, цогц хэлбэрээр үйлчилгээг үзүүлж чадахгүй байна.”

“Хуульд бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлнэ гэсэн хэдэн зүйл заасан байдаг ч яг бэлгийн хүчирхийллийн хохирогч охидтой, хөвгүүдтэй ингэж ажиллана гэсэн заавар байдаггүй. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчтой ажиллах нь илүү хүнд байдаг.”

Практикт ажиллаж буй мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзвэл бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах тусгайлсан стандарт, дүрэм журам байхгүйн дээр, ТХБ-ны стандарт нь шаардлага хангахгүй байгаа, энэ төрлийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх чадвар дутмаг, түүнчлэн энэ төрлийн хохирогч илүү хүнд гэмтэл авдаг тул илүү урт хугацааны үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагатай болдог талаар дурдаж байна. Улмаар ТХБ-ны үйлчилгээ үзүүлэх журмын 2.6-д “Төрөлжсөн түр хамгаалах байр байхгүй тохиолдолд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг харгалзан үйлчилгээг үзүүлнэ” гэсэн заалт ч практикт бодитой хэрэгжихгүй байна. Иймд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид зориулсан төрөлжсөн ТХБ байгуулах нь практикт илүү нийцтэй байх бөгөөд хууль болон журамд бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ-ны төрлийг нэмж журамлаж өгөх шаардлагатай байна.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.7.	Түр хамгаалах байрыг ажиллуулж буй төрийн, төрийн бус байгууллага нь түр хамгаалах байрыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээг бүрэн үзүүлнэ.
--	--

ТХБ-ны үйлчилгээ бүрэн үйлчилгээ байж чадаж байна уу?

ТХБ-нд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн ажиллахаар 2.7-дугаар зүйлд журамлаж өгсөн байна. Гэхдээ шаардлагатай хүний нөөц гэдэгт ямар ямар мэргэжилтэн, орон тоогоор ажиллах талаар тодорхой зохицуулж өгсөн журам байхгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон ТХБ-ны үйлчилгээ үзүүлэх журмаар хамгааллын үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхээр хуульчилж, журамлаж өгсөн. Үүнээс үзвэл нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрх зүйч зэрэг хүний нөөц шаардлагатай байна. Гэтэл судалгаанд хамрагдсан ТХБ-дад шаардлагатай хүний нөөц дутмаг байгаа нь харагдсан. Тухайлбал, СХД дэх ТХБ-нд 1 зохицуулагч, 3 нийгмийн ажилтан, 1 тогооч, 1 үйлчлэгч, 1 хамгаалагч ажиллаж байна гэжээ. Мөн Орхон болон Сэлэнгэ аймаг дахь ТХБ-нд 1 зохицуулагч, 1 мэргэжилтэн нийт 2 орон тоотойгоор тус тус үйл ажиллагаа явуулж байгаа бол Архангай аймаг дахь ТХБ-нд зохицуулагч 1, нийгмийн ажилтан 3 орон тоотойгоор ажиллаж байна гэжээ. Үүнээс үзвэл энд эмч, сэтгэл зүйч, эрх зүйч гэсэн хүний нөөц дутуу болох нь харагдаж байна.

Шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн хүрэлцээтэй байгаа эсэх талаар асуухад:

- Хүн хүч дутмаг ч гэсэн дор дороо бүгд ажлуудаа гүйцэтгээд явчихдаг.
- Үйлчилгээний хүртээмж тааруу. Учир нь би мэргэжлийн нийгмийн ажилтан биш үндсэн эрх зүйч мэргэжилтэй. Эрх зүйч мэргэжлээрээ ажиллаж байх явцдаа олж авсан хууль эрх зүйн мэдлэг дээрээ тулгуурлан ажиллаж байна.

- Мэргэжлийн болон мэргэжлийн бус хүмүүс 50%, 50% хувь байгаа тул бас бүрэн гүйцэд гэж хэлэхэд хэцүү. Дээр нь цалингийн хувьд ТҮ-4,5-аар цалинжуулж байгаа тул мэргэжилтнүүдэд тохирсон шаардлага тавихад хүндрэлтэй.

Хамгаалах байр, хүн хүч, мэргэжилтэн хүрэлцээгүйн улмаас хохирогч хямралд өртсөн үедээ зайлшгүй шаардагдах бусад нийгмийн үйлчилгээ, дэмжлэгт хамрагдаж чаддаггүй, нөгөө талаас эдгээр үйлчилгээнд зориулсан санхүүжилт байдаггүй. Ачаалал ихтэйн улмаас гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж олгогддоггүй талаар судалгаанд оролцогч нар ярилцлагадаа дурдаж байсан. Үүнээс үзвэл шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилгодоо хүрч чадахгүй байгаа нь харагдаж байна.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 5.1.	Түр хамгаалах байр нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.
--	--

Цогц үйлчилгээг үзүүлэх зорилгодоо хүрч чадсан эсэх?

Аливаа үйлчилгээг үзүүлэхэд хамгийн чухал асуудал бол түүний санхүүжилтийн хүрэлцээтэй байдал байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж хуульчилсан. Гэтэл өнөөдрийг хүртэл ТХБ-ны зардлыг нэг хүнд ноогдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох журмыг баталж мөрдүүлээгүй байна. Үүний улмаас улсын болон орон нутгийн төсвөөс тогтмол зардал өгөх, улмаар тухайн зардал нь хүрэлцэхгүй байх, ажилчид өөрсдөөсөө эм тариа, хоолны мөнгө гаргах зэргээр санхүүжилтийн асуудал нэн тулгамдсан асуудал болж байна. Санхүүжилтийн талаар тулгарч буй бэрхшээлийн талаар асуухад:

“Хоол хүнс, эрүүл ахуйн тал дээр санхүүгийн асуудал гардаг. Сардаа тэдэн төгрөг өгнө гэж бариад байдаг. Сүүлийн үед хүнсний үнэ их өссөн болохоор сарын зардал нь өөр өөр гардаг. Мөн энд байрлаж байгаа хүүхдүүд эм тариа их хэрэглэдэг. Тэр нь төсөвтөө баригдаад ажилчид өөрөөсөө гаргах тохиолдол байдаг. Төсвөө бэлэн мөнгөөр авахгүй нэхэмжлэл бичүүлээд авдаг. Дараа нь төлбөрийн зардал нь илүү гарч ирээд байдаг нь хүндрэлтэй.”

“Нэг хүнд ноогдох хувьсах зардал нь ерөөсөө хөрсөн дээр буугаагүй мөнгөн дүнтэй байдаг.”

“Нэг хүнд ноогдох үрсгал зардлыг мэддэггүй.”

“Норматив зардал гэж батлагдсан зардал байгаа гэвч яг тэр маань бодит байдал дээр хэцүү байна. Жилд баталж өгсөн төсөв хүүхдүүдийн зардал хэрэгцээнд хүрдэггүй.”

Судалгаанд хамрагдсан ТХБ-ны ажилтнуудаас өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулах үүсэж буй хүндрэл бэрхшээл юу вэ? гэсэн асуултад:

“Тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд бэрхшээл тулгардаг. Хүүхдүүдэд хэрэгцээ шаардлагатай хичээлийн хэрэгсэл, зурагт зэрэг эд материал хомсдолтой.”

“Хүйтэнд гал түлэх, галлаад дулаацахгүй, бид нарын аюулгүй байдал хангагддаггүй олны хөлийн газар байрладаг.”

“Хохирогчдод холбон зуучлах, сэтгэл зүйн үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрх зүйн үйлчилгээ гэсэн дөрөвхөн төрлийн үйлчилгээ үзүүлж байна. Манай байгууллага дээр бэлгийн хүчирхийллийн хохирогч ирсэн тохиолдолд хамгийн түрүүнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг. Мөн ганцаараа ажиллаж байгаа тул өөрийнхөө хүргэж буй үйлчилгээг үр дүнтэй байгаа эсэхийг үнэлж чадахгүй байна.”

“Орон тоо дутмаг, нэг хүнд оногдох ачаалал их зэргийг дурджээ.”

Дээрхээс дүгнэж үзвэл ТХБ-ны санхүүжилтийн асуудал зүй ёсоор анхаарал татах бөгөөд үүнээс үүдээд орон тоо дутуу ажиллах, нэг хүнд оногдох ачаалал их байх, ажилчдын цалин хангамж бага тул хүний нөөцийн тогтворгүй байдал үүсэх, эд материал, хоол хүнс, эм зэрэг үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай наад захын хэрэгцээгээ хангахад төсөв мөнгө, санхүүжилт хүрэлцдэггүй байна. Үүний улмаас ТХБ нь үйлчлүүлэгчдээ цогц үйлчилгээг үзүүлж чадахгүй байна гэж дүгнэлээ.

Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмаас дараах зүйл заалтыг сонгон авч, үнэлгээ хийнэ.

Заалт	Зохицуулалтын агуулга
Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 1.1	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээ ямар ялгаатай эсэх?

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д “Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж нь эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад ажиллана” гэж хуульд тодорхойлж өгсөн бол Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны хамтарсан тушаалаар батлагдсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх журмын 1.1-т “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлэх...” гэж журамлаж өгсөн байна.

Дээрхээс үзвэл НЦҮТ болон ТХБ-ны үзүүлэх үйлчилгээ хууль журамд зааснаар төдийлөн ялгаа харагдахгүй байх ба бодит байдал дээр ТХБ ч мөн НЦҮТ-тэй адил хохирогчийн аюулгүй байдлыг хангах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах үйлчилгээг мөн үзүүлж байна. Түүнчлэн НЦҮТ нь хууль болон журамд заасан үйлчилгээг 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлнэ гэж байгаа нь хоногийн 24 цагийн аль ч цагт ирсэн үйлчилгээ үзүүлнэ гэсэн агуулга уу? Аль эсвэл 24 цаг хүртэл үйлчилгээ үзүүлээд холбон зуучлаад дараагийн байгууллагад шилжүүлэх агуулга эсэхийг тодорхойгүй тусгаж өгчээ. Магадгүй хууль тогтоогчийн зүгээс НЦҮТ-ийг хохирогчид 24 цаг хүртэл үйлчилгээ үзүүлээд дараагийн шатны байгууллагад холбон зуучлах агуулгаар хуульчилсан байж болох юм.

Гэтэл бодит байдал дээр НЦҮТ болон ТХБ нь ирсэн хохирогчийг ялгаагүй урт хугацаагаар байрлуулж үйлчилгээгээ үзүүлж байна. Тухайлбал:



Шигтгээ

Манай байгууллагад иргэн дээд тал нь 50 хоног байрласан. Доод тал нь 2 хоносон. НЦҮТ 24 цагийн хугацаанд байрлуулах журамтай ч амьдрал дээр тэгж хэрэгжихгүй байгаа. Ийм журамтай атал 50 хоночлоод байгаа.

БЗД дэх НЦҮТ-ийн ажилтан

НЦҮТ нь хуульдаа 24-72 цаг байрлуулна гэж заасан байгаа. Манайх хямралын үеийн дамжин өнгөрөөх үйлчилгээ гэж явдаг учраас эндээ эрүүл мэндийн бүх үйлчилгээгээ аваад дараагийн шатны түр хамгаалах байр уруу шилждэг. Үйлчлүүлэгчийн бие хүнд байгаа тохиолдолд 72 цагаас дээш удаан хугацаагаар байрлуулахаас өөр арга байхгүй. Цус алдаад байгаа, унадаг, татдаг, өдөр болгон боолт хийх шаардлагатай байгаа хүмүүсийг 72 цагаас дээш хугацаанд байлгана. 7 хоног ч байлгаж болно. Харин эрүүл мэндийн шалтгаангүй байхад ар гэрээс нь хүн ирэхгүй арга хэмжээ авахгүй байгаа тохиолдолд дүүрэг рүү нь мэдэгддэг.

ГССҮТ-ийн дэргэдэх НЦҮТ-ийн ажилтан

Хохирогч нарт хувилбарт буюу өдрийн үйлчилгээ санал болгож байна. Сэтгэл зүйн зөвлөгөө аваад, амраад, өдрийн хоолонд ороод явж болно. Эсвэл асуудал шийдвэрлэгдтэл буюу 3-7 хоногийн хугацаанд иргэдийг байрлуулж байна. Хохирогч хамгаалах байранд дээд тал нь 3 сар хүртэл хугацаанд байрлуулах боломжтой байдаг. ГБХЗХГ, Цагдаа, Эрүүл мэндийн газрын дарга нарын хамтарсан журам гарч дээд тал нь 3 сар хүртэл хугацаанд байлгах журам баталсан байдаг.

Дорнод аймаг дахь НЦҮТ-ийн ажилтан

Өмнө нь манайх хамгийн дээд тал нь 90 хоног байрлуулж байсан, сая журам гараад арай өөр болсон. ГБХЗХГ-ын зүгээс санхүү олгохдоо нэг хүнийг 5-с дээш хоног байрлуулахгүй гээд үлдсэн хоногийг хасаж санхүү өгдөг байсан бол энэ жилээс тухайн хүнийг аюулгүй болтол байлгах ёстой гэсэн чиглэлтэй байна.

Завхан аймаг дахь НЦҮТ-ийн ажилтан

Журмаараа 72 цаг гэсэн байгаа. Гэхдээ яг 72 цаг байрладаггүй. Жишээ нь өөр хамгаалах байр луу шилжүүлбэ гэхэд тэр газар нь ор гараагүй байвал манайх эндээ байлгаж л байдаг.

СБД-ийн НЦҮТ-ийн ажилтантай хийсэн ярилцлагаас

Дээрх ярилцлагуудаас үзвэл НЦҮТ-ийн хохирогчийг байрлуулж, үйлчилгээ үзүүлж буй хугацаа практикт 24 цагаас илүү, урт хугацаатайгаар байрлуулан үйлчилгээ үзүүлж байгаа болох нь харагдаж байна. Тэгвэл НЦҮТ болон ТХБ-ны үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтыг харьцуулан авч үзье.

Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байрны үйлчилгээ, бүтэц зохион байгуулалтын харьцуулалт

		НЦҮТ	ТХБ
1	Үзүүлэх үйлчилгээ	33.1.1. Аюулгүй байдлын хамгаалалт; 33.1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ; 33.1.3. Сэтгэл зүйн үйлчилгээ; 33.1.4. Нийгмийн халамжийн үйлчилгээ; 33.1.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээ; 33.1.6. Эрх зүйн туслалцаа; 33.1.7. Холбон зуучлах үйлчилгээ. (ГБХТХ)	35.1. Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлнэ. 35.3. Түр хамгаалах байр хохирогчид энэ хуулийн 33.1.2, 33.1.3, 33.1.4, 33.1.5, 33.1.6-д заасан үйлчилгээг холбогдох байгууллагатай хамтран үзүүлнэ. (ГБХТХ)

2	Үйлчилгээ үзүүлэх хугацаа	1.1. 24 цагийн турш харьяалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлэх	1.1. Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор тэдний аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн тусгай байранд түр хамгаалан байрлуулах
3	Бүтэц, зохион байгуулалт	2.1. Нэг цэгийн үйлчилгээний төв нь эмнэлэг, төр, төрийн бус байгууллагын харьяанд ажиллана.	2.3. Түр хамгаалах байрыг төрийн, төрийн бус байгууллагын харьяанд байгуулан ажиллуулж болно.
4	Санхүүжүүлэх эх үүсвэр	6.1. Нэг цэгийн үйлчилгээ нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх ба зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.	9.1. Түр хамгаалах байр нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх ба зардлыг улсын болон орон нутгийн төсөв, Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2-т заасны дагуу халамжийн сангийн хөрөнгөөс, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
5	Санхүүжилтийн хэмжээ	36.2. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг энэ хуулийн 35.4-т заасны дагуу тооцож, улсын төсвөөс санхүүжүүлнэ. (ГБХТТХ)	35.4. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. (ГБХТТХ)
6	Удирдлагаар хангах	Эмнэлэг, Цагдаагийн байгууллага, Орон нутгийн санхүүжилтээр бие даасан ТББ-ийн хэлбэртэй үйл ажиллагаа явуулж буй.	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх, ТББ-ийн хэлбэртэй магадлан итгэмжлэгдсэн

Дээрх хүснэгтээс үзвэл НЦҮТ болон ТХБ-ны үзүүлж буй үйлчилгээг хууль болон журамд ижил байдлаар хуульчилж өгсөн байна. ТХБ-ны зорилго нь аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээ үзүүлэх зорилготойн дээр, шаардлагатай тохиолдолд хуулийн 33.1-т заасан үйлчилгээг бусад байгууллагатай хамтран үзүүлэх чиг үүрэгтэй байх тул холбон зуучлах үйлчилгээг ч мөн үзүүлж байна. Иймд НЦҮТ болон ТХБ-ны үзүүлж буй үйлчилгээ адилхан байна.

Нэгэнт үзүүлж буй үйлчилгээний хувьд адилхан хуульчлагдсан учраас хохирогчийг байрлуулах хугацаа, үйлчилгээ үзүүлэх хугацааны хувьд ч төдийлөн ялгаа байхгүй болох нь бодит байдал практикаас харагдаж байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд ч НЦҮТ болон ТХБ нь төрийн болон төрийн бус байгууллагын харьяанд байж болохоор ижил байдлаар хуульчилж, журамлаж өгсөн. Мөн санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд төрийн болон орон нутгийн төсвөөс, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр, түүнчлэн санхүүжилтийн хэмжээ нь ч нэг хүнд ноогдох хувьсах зардлаар тооцохоор ижил байдлаар ГБХТТХ-д тусгаж өгсөн байна.

Бүтэц зохион байгуулалтын хувьд эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад түшиглэсэн НЦҮТ-үүд үйл ажиллагаа явуулж байгаа нь үзүүлж буй үйлчилгээг, бүтэц зохион байгуулалтыг бага зэрэг ялгаатай болгож байна.

Иймд НЦҮТ болон ТХБ-ны үзүүлж буй үйлчилгээ, бүтэц зохион байгуулалт төдийлөн ялгагдах зүйлгүйгээр бодит байдал, практикт хэрэгжиж байна гэж дүгнэлээ.

Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 6.5.	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-д заасны дагуу тооцож, санхүүжүүлнэ.
--	---

НЦҮТ-ийн санхүүжилт бодит байдал, практикт ямар байгаа, хүрэлцээтэй байна уу?

ГБХТТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг энэ хуулийн 35.4-т заасны дагуу тооцож, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж хуульчилж өгсөн. Хуулийн 35.4-т “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцно...” гэж хуульчилж өгсөн. Улмаар 2017 оны гурван сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх санхүүжүүлэх журмын 6.5-д нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг нэг хүнд ноогдох хувьсах зардлаар тооцож, санхүүжүүлэхээр журамд тусгасан.

Судалгаанд хамрагдсан НЦҮТ-ийн ажилтнуудаас санхүүжилттэй холбоотой хүндрэл бэрхшээлийн талаар асуухад:

 Шигтгээ

Манайд санхүүжилт байхгүй. Одоо байгаа энэ бүх компьютер тоног төхөөрөмжийг төслөөр анх байгуулагдахад авч байсан.

ГССҮТ-ийн дэргэдэх НЦҮТ-ийн ажилтан

Санхүүгийн асуудлыг тухай тухай бүрд нь ГБХЗХГ-аас шийдвэрлээд явдаг. Хүний нөөц, барилга байгууламжтай холбоотой хөрөнгийн асуудлыг орон нутаг, донор байгууллагуудын тусламжтайгаар шийдвэрлээд явж байна. Хуулийн хүрээнд санхүүжих ёстой зардлууд горимын дагуу хийгдээд явж байна.

Дорнод аймаг дахь НЦҮТ-ийн ажилтан

Бид хохирогчид үйлчилгээг үзүүлээд гүйцэтгэлээрээ санхүүгээ ГБХЗХГ-аас хүсдэг. Гүйцэтгэлээр санхүүжилт өгөх ёстой боловч мэргэжилтнүүдийн үзүүлсэн үйлчилгээнд санхүүгийн баримт олгохгүй буюу заавал е-баримт нэхдэг тул сэтгэл зүйн болон нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний хөлсөө авч чаддаггүй. Үйлчилгээний зардал олгодоггүй бөгөөд зөвхөн хоол хүнсэнд зардал өгч байгаа нь учир дутагдалтай санагддаг.

Завхан аймаг дахь НЦҮТ-ийн ажилтан

“Улс улстайгаа гэрээлдэггүй” гэдэг учраас манайд санхүүжилт байдаггүй. Урсгал засвар болон ариун цэврийн зүйлс гээд бүгдийг нь эмнэлэг гаргана. Нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцож гаднаас санхүүжилт авдаггүй. Бас хүнсний асуудал их хэцүү. Үйлчлүүлэгч хүүхэд ирлээ гэхэд би талх идмээр байна, өлсөж байна гэдэг. Манайд илүү санхүүжилт байхгүй болохоор өөрөөсөө мөнгө гаргаад л талх боорцог авч өгдөг.

СБД дэх эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ-ийн ажилтан

Санхүүтэй холбоотой асуудал их байна. Гэнэт хүүхдүүд ирдэг, нялх хүүхдүүдэд сүү, памперс байхгүй их сандардаг. Нөөц байдаг ч хүүхэд их ирж ачаалал ихсэхээр хүрэлцдэггүй. Эд материал их дутмаг байдаг.

ЧД дэх НЦҮТ-ийн ажилтан

Дээрхээс үзвэл НЦҮТ-ийн санхүүжилтийг олгохдоо нэг хүнд ноогдох хувьсах зардлаар буюу үзүүлсэн үйлчилгээ, гүйцэтгэлээр нь санхүүжилтийг нь олгохгүй байгаа асуудал нийтлэг байна. Улмаар санхүүжилтийн тодорхой төсөвт багтаан санхүүжүүлж байгаа нь эргээд төсөв хүрэлцэхгүй байх, төсөвгүйн улмаас сэтгэл зүйн үйлчилгээ, эмнэлгийн (эм авах) үйлчилгээ үзүүлэх зэргээр цогц байдлаар үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл бэрхшээлийг үүсгэдэг байна.

Түүнчлэн, эмнэлгийн байгууллагад түшиглэн байгуулагдсан НЦҮТ-дийн санхүүжилтийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна гэж Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 6.4-т тусгаж өгчээ. Гэтэл эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ-ийн

зардлыг тухайн эмнэлэг нь өөрөө дааж байгаа тул тусгайлсан төсөв мөнгө хуваарилдаггүй, хоол хүнс, асрамж халамжийн материалын санхүүжилтгүй байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Харьцуулах хэлбэрээр үнэлгээ хийх

Энэ хэсэгт 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнөх нөхцөл байдал (2004-2016 он хүртэл) болон хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараах нөхцөл байдал (2016-өнөөдрийг хүртэл) буюу ТХБ болон НЦҮТ-ийн журмууд батлагдсанаар гарсан өөрчлөлтийг харьцуулах байдлаар судална.

2004-2016 он хүртэлх нөхцөл байдал

Монгол Улс 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг анхлан баталж 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хууль хэрэгжиж эхэлсэн байна. Тус хуулийн зорилго нь "...Хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлжээ. Түүнчлэн, «Гэр бүлийн хүчирхийлэл» гэж гэр бүлийн хүрээнд гэр бүлийн аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж тодорхойлсон нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдоггүй, захиргааны хариуцлага хүлээлгэх зөрчил гэж үзэж байсан болохыг харуулж байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т «Хамгаалах байр» гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг гэж тодорхойлж өгсөн боловч, хамгаалах байрыг хэрхэн байгуулах, хэн байгуулах, ямар үйлчилгээ үзүүлэх, хамгаалах байрны санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөөгүй байжээ. Үүний үр дүнд, хамгаалах байрны хүрэлцээ муу, үйл ажиллагаа нь доголдолтой байсан талаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хийсэн судалгаанд³ дурдагдсан байдаг.

Монгол Улсад өмнө нь Улаанбаатар хот дахь хамгаалах байрыг оролцуулан 5 хамгаалах байр ажиллаж байсан ч бүгд санхүүжилтгүйн улмаас хаалгаа хаахад хүрсэн. Одоогоор ажиллаж байгаа хамгаалах байр нь гаднын санхүүжүүлэгч байгууллагын төслийн санхүүжилт, Нийгмийн халамж, үйлчилгээний газартай гэрээлсэн ажиллагааны зардал болон ТББ-ын хөрөнгө босгох замаар олсон нөөцийг зарцуулж байна. Бусад хамгаалах байрууд нь санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хаагдсан. Монгол Улсын хэмжээнд зөвхөн нэг хамгаалах байр л бүрэн хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь нийслэл Улаанбаатар хотод байрладаг. 20 ортой ч өвлийн улиралд багтах зайгүй болдог. Хамгаалах байр дүүрсэн үед хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул занал тулгарсан ч авах ямар ч боломжгүй болдог.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д «хохирогчид үзүүлэх үйлчилгээ» гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх ажиллагааг гэж хуульчилснаас өөрөөр тухайн үйлчилгээг хэрхэн үзүүлэх, хэн үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг хэн батлах, түүний санхүүжилтийг хэрхэн шийдэх, үйлчилгээ үзүүлэх боловсон хүчний эрх үүрэг зэрэг хууль хэрэгжих гол хүчин зүйл болох процессын зохицуулалтыг нь орхигдуулж өгсөн байна. Үүний улмаас хохирогчид үзүүлэх үйлчилгээ тэр чигээрээ ТББ-ын нуруун дээр хэвээр үлдсэн⁴ байна.

3 Хүчирхийллийн эсрэг үндэсний төв "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Монгол Улс, Хүний эрхийн тайлан", УБ.2014 он. 67 дахь тал.

4 Мөн тэндээс. 71 дахь тал.

Дээрхээс дүгнэж үзвэл тухайн үед ТХБ-ны хүрэлцээ муу, үзүүлэх үйлчилгээ нь тодорхойгүй, НЦҮТ-ийг байгуулах зохицуулалт огтоос байхгүй, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдэж чадаагүй байжээ. Энэ талаар Хүчирхийллийн эсрэг үндэсний төв “2014 оны 1 сарын байдлаар 2,8 сая гаруй хүн амтай Монгол Улсад 20 ортой нэгхэн хамгаалах байр л үйл ажиллагаагаа явуулж байна. Хүчирхийллээс ангижрах, даван туулахад нь тусалж чадахуйц эдийн засгийн дэмжлэг байхгүй байна. Монгол Улсад хамгаалах байр, бусад үйлчилгээнд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгадаггүйгээс үйлчилгээний хүртээмж багасаж, үүнээс шалтгаалан хохирогчийн аюулгүй байдал хамгаалагдаж чадахгүй байна” гэж дүгнэсэн байдаг.

2016 оноос өнөөдрийг хүртэлх нөхцөл байдал

Монгол Улсын Засгийн газраас 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан боловч бусад холбогдох хуульд өөрчлөлт ороогүйгээс хэрэгжилтэд ахицтай байдал ажиглагдаагүйгээс 2016 оны 12 сард ГБХТТХ-ийг дахин шинэчлэн найруулж гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг гэмт хэрэг гэж авч үзсэн нь дэвшилт болсон⁵. Тус хуулиар, гэр бүлийн хүчирхийллийг Монголын түүхэнд анх удаа гэмт хэрэгт тооцох болсон юм. Мөн НЦҮТ-өөр үйлчилгээ үзүүлэх асуудлыг ГБХТТХ-иар хуульчилж, “Нэг цэгийн үйлчилгээ гэдгийг эмнэлэг, төрийн болон, төрийн бус байгууллагын дэргэд ажиллаж, эрүүл мэндийн болон бусад зайлшгүй шаардлагатай үйлчилгээг богино хугацаанд нэг дороос үзүүлэх үйл ажиллагаа” хэмээн тодорхойлсон байна⁶. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж гарсан Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын баталсан тушаалууд нь 2016 оноос хойш гарсан байх ба 20 гаруй тушаал байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2016 оны шинэчилсэн найруулгыг баталсантай холбоотойгоор НЦҮТ болон ТХБ-нд мөрдөгдөх олон тооны журмууд шинээр батлагдсан байна. Хавсралт-6 үзнэ үү. Үүнээс үзвэл гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг процессжуулж, хэн ямар эрх үүрэгтэйгээр ямар үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг тодорхой болгож өгсөн нь харагдаж байна.

2018 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд ХЗДХЯ, ЭМЯ, ГБХЗХГ, ТББ-ыг түшиглэн нийт 15 “Нэг цэгийн үйлчилгээ” байгуулагдсанаас: Улаанбаатар хотод 5 газар, орон нутагт 10 газар байгуулагдсан байна. Үүнээс эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв, Сүхбаатар Дүүргийн Эрүүл Мэндийн Төвийн дэргэдэх), Хууль зүй, дотоод хэргийн яамыг түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Шүүх Шинжилгээний Үндэсний Төв), Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газрыг түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Хан-Уул, Баянзүрх дүүрэг) байгаа бол Орон нутагт 10 газар: Эмнэлэгт түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг), Хууль зүй, дотоод хэргийн яам түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Завхан, Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар), Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газрыг түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Хөвсгөл аймаг), Төрийн бус байгууллагад түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээ (Баянхонгор аймаг)-г тус тус явуулж байна.

Үүнээс үзвэл НЦҮТ-үүд нь нэгдүгээрт, Эрүүл мэндийн байгууллага буюу эмнэлэгт түшиглэсэн, хоёрдугаарт, Цагдаагийн байгууллага болон Шүүх шинжилгээний Үндэсний төвд түшиглэсэн,

5 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ. УБ. 2019 он.

6 НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. “Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан”, УБ. 2017 он. 20 дахь тал.

гуравдугаарт, Гэр Бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газарт түшиглэсэн, дөрөвдүгээрт, ТББ-д түшиглэсэн гэсэн дөрвөн төрлийн загвар байхаар байна. Аль аль нь ЖСХ-ийн хохирогчдод нэг цэгээс үйлчилгээ үзүүлэхэд өөр өөрийн давуу болон сул талтай талаар ярилцлагын судалгаа болон бусад судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагад түшиглэсэн НЦҮТ-үүд эрүүл мэндийн болон сэтгэлзүйн шаардлагатай бүхий л үйлчилгээг нэг дороос авах боломжийг олгож байна. Гэвч эдгээр төвүүд нь үйлчлүүлэгчээ хууль эрх зүйн болон нийгмийн бусад үйлчилгээ (хоол хүнс, ариун цэврийн хэрэглэл зэрэг) үзүүлэх, бусад байгууллагуудад холбон зуучлах талаар учир дутагдалтай байна. Цагдаагийн байгууллагад түшиглэсэн НЦҮТ-ийн хувьд үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн, цагдаагийн болон сэтгэлзүйн туслалцааг нэг дороос үзүүлэх давуу талтай боловч эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлахад бэрхшээл гарсаар байна⁷. ТББ-ын ажиллуулж буй НЦҮТ нь аюулгүй байдлыг хангах, сэтгэлзүйн болон эрхзүйн туслалцаа гэх мэт нэлээд өргөн хүрээтэй үйлчилгээг нэг дороос үзүүлж байлаа. Харин эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлахад зохих бэрхшээл гардаг ажээ⁸. Иймд хууль болон журамд заасанчлан зайлшгүй шаардлагатай чанартай үйлчилгээг цогцоор нь үзүүлэхийн тулд холбогдох салбаруудын уялдаа, хамтын ажиллагаа ба салбар хоорондын зохицуулалтыг улам сайжруулах шаардлагатай байна.

Дээрхээс дүгнэж үзвэл ГБХТТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдсанаар ТХБ болон НЦҮТ-ийг байгуулах эрх зүйн орчин тодорхой болж, улмаар эдгээр байгууллагын үзүүлэх үйлчилгээг хуульд тусган өгч, үйлчилгээ үзүүлэх процесс ажиллагааг журамлаж өгснөөр гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчлэх, эрхийг нь хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоонд ахиц дэвшил гарсан байна. Энэ талаар НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын 2017 оны 10 дугаар сард хийсэн судалгаандаа ийн дүгнэжээ:

Монгол Улсад анхны НЦҮТ-үүд үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2009 оноос хойших хугацаанд ихээхэн ахиц дэвшил гарсан нь үнэлгээний явцад харагдаж байв. НЦҮТ-үүд сүүлийн 5 жилд 5,000 гаруй хохирогчдод үйлчилсэн байна. Тэднээс 2,000 орчим эмэгтэйчүүд, хүүхэд НЦҮТ-үүд болон хамгаалах байруудад байрлаж, эрүүл мэндийн, сэтгэлзүйн, цагдаагийн, хууль зүйн, хүүхэд хамгааллын зэрэг үйлчилгээг цогцоор нь авчээ. Үйлчлүүлэгчдийн 30-35 хувийг 16 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Түүнчлэн 2016 онд үйлчлүүлсэн хохирогчдын тоо 2012 оныхтой харьцуулахад хамгийн багадаа 3 дахин нэмэгджээ. НЦҮТ-ийг сонгосон аймгийн төвүүдэд шинээр нэмж байгуулсан нь үйлчлүүлэгчдийн тоо ийнхүү өсөхөд гол нөлөө үзүүлжээ. Үүний сацуу Гэмтлийн эмнэлэг дэх НЦҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэн гэж байв. Тус НЦҮТ-өөр хамгийн олон хохирогч үйлчлүүлсэн бөгөөд зөвхөн 2016 онд л гэхэд 900 үйлчлүүлэгчийг хүлээн авчээ.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- а. **Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журамтай холбоотой дүгнэлт, санал зөвлөмж**
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.2 дахь хэсгийн хэрэгжилт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТХБ-ыг байгуулах нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх зорилгод нийцсэн байна. Гэхдээ одоо үйл ажиллагаа явуулж буй ТХБ болон НЦҮТ-үүд эмнэлэг, цагдаагийн байгууллага, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн,

⁷ НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар. "Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан", УБ. 2017 он. 7 дахь тал.

⁸ Мөн тэндээс. 7 дахь тал.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зэрэг Засгийн газрын харьяа байгууллага, агентлагт түшиглэн байгуулагдаж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл эдгээр ТХБ болон НЦҮТ-ийн санхүүжилт нь улсын төсвөөс гарч байгаа юм. Иймд нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр байгуулагдсан ТХБ болон НЦҮТ-ийг түлхүү байгуулах, ийнхүү байгуулах түлхэц, хөшүүргийг бий болгох шаардлагатай байна.

- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.5 дахь хэсгийн хэрэгжилт
Хохирогчийн хэрэгцээ шаардлагыг харгалзан төрөлжсөн түр хамгаалах байр байгуулж болохоор журамд зааж өгсөн ч одоогийн байдлаар төрөлжсөн түр хамгаалах байр байгуулагдаагүй байгаа тул журмын 2.5 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Харин ямар чиглэлийн төрөлжсөн ТХБ байгуулж болох, түүний хэрэгцээ шаардлагын талаар судалж үзэхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ байгуулах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Иймд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид зориулсан төрөлжсөн ТХБ байгуулах нь хэрэгцээ шаардлага нийгэмд байгаа тул, хууль болон журамд бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ-ны төрлийг нэмж хуульчилж, журамлаж өгөх шаардлагатай байна.
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.7 дахь хэсгийн хэрэгжилт
Журамд зааснаар шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж үйлчилгээ үзүүлэхээр журамлаж өгсөн боловч судалгааны үр дүнгээс үзвэл шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилгодоо хүрч чадаагүй байна. Үүний шалтгаан нөхцөл нь ажилчдын цалин бага, мөн боловсон хүчний дутагдалтай байдал, улмаар ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл хангалттай бүрдэж чадаагүй байдал, санхүүжилтийн асуудал, ажлын ачаалал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Иймд ажилчдын цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрийн ажлын ачааллыг судлах, улсын хэмжээнд шаардлагатай байгаа ТХБ болон НЦҮТ-ийн тоог гаргах, үүнд ажиллах шаардлагатай нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрх зүйчийг бэлтгэх, мэргэшүүлэх цогц судалгаа хийх хэрэгцээ байна.

- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 5.1 дэх хэсгийн хэрэгжилт
ТХБ-ны санхүүжилтийг нэг хүнд ноогдох хувьсах зардлаар санхүүжүүлэхээр хууль болон журамд тусгаж өгсөн өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй хэвээр байсаар байна. Үүнээс үүдээд орон тоо дутуу ажиллах, нэг хүнд ноогдох ачаалал их байх, ажилчдын цалин хангамж бага тул хүний нөөцийн тогтворгүй байдал үүсэх, эд материал, хоол хүнс, эм зэрэг үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай наад захын хэрэгцээгээ хангахад төсөв мөнгө, санхүүжилт хүрэлцдэггүй байна. Түүнчлэн сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг хүртээмжтэй үзүүлж чадахгүй байгаа тул ТХБ нь үйлчлүүлэгчдээ цогц үйлчилгээг үзүүлж чадахгүй байна гэж дүгнэлээ. Өөрөөр хэлбэл, цогц үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн ахицтай байгаа ч бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа асуудал байсаар байна.

Иймд ГБХТХ-д заасан ТХБ болон НЦҮТ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ нэг хүнд ноогдох хувьсах зардлаар тооцох буюу үзүүлсэн үйлчилгээнд нь үндэслэн зардлыг олгодог болох зохицуулалтын хэрэгжилтийг хангах, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

b. Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журамтай холбоотой дүгнэлт, санал зөвлөмж

- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 1.1 дэх хэсгийн хэрэгжилт.
Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв нь 2009 оноос анх байгуулагдан үйлчилгээ үзүүлж эхэлсэн ба 2016 оны ГБХТХ-ийн шинэчилсэн найруулгаар анх удаа хуульд тусгагдсанаар эрх зүйн орчин бүрдэж, холбогдох журмууд нь батлагдсан байна. ГБХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Нэг цэгийн үйлчилгээ” гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг гэж хуульчилсан байх боловч бодит байдал, практикаас ТХБ болон НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээ төдийлөн ялгаатай биш байна. Энэ нь ч ТХБ болон НЦҮТ-ийн үзүүлэх үйлчилгээг хуульд ижил байдлаар хуульчилж өгсөнтэй холбоотой байна.

НЦҮТ-ийн нэг онцлог нь эмнэлгийн байгууллага, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, орон нутгийн цагдаагийн хэлтэст түшиглэн байгуулагдсан боловч эдгээр байгууллага, НЦҮТ-д зориулсан төсвийн тусгай зүйл анги байхгүй болохоор, эрүүл мэндийн болон цагдаагийн байгууллагууд өөрийн хязгаарлагдмал нөөцөө зохицуулах байдлаар НЦҮТ-ийн ажилтнуудын цалин, бусад зардлыг хариуцсаар иржээ. Үүнтэй холбоотойгоор, ихэнх НЦҮТ-дийн санхүүжилт хангалтгүй байгаа нь үнэлгээний үр дүнгээс харагдсан.

Иймд бодлогын хувьд НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээний зааг ялгааг илүү тодорхой болгох, аль эсвэл нэгтгэж нэг стандарттай болгох, бодлого, дүрэм журмын хувьд ойлгомжтой хэрэгжүүлж, хяналт тавихад хялбар цөөн тооны дүрэм журамтай болгох зэргээр бодлогын гарц, шийдэл хайх шаардлагатай байна.

- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 6.5 дахь хэсгийн хэрэгжилт.
НЦҮТ-ийг санхүүжүүлэх журам нь ТХБ-ыг санхүүжүүлэх журамтай ижил байдлаар, нэг хүнд ноогдох хувьсах зардлаар санхүүжүүлэхээр хууль болон журамд нь тусгаж өгчээ. Гэтэл өнөөдрийг хүртэл хугацаанд энэ журам хэрэгжээгүй байна. Түүнчлэн эмнэлэг, цагдаа, Шүүх шинжилгээний үндэсний төвд түшиглэсэн НЦҮТ-дийн санхүүжилтийг шийдэхдээ тухайн байгууллагын төсөвт тусгайлан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх төсвийн багцыг баталж, мөрдүүлдэг байхаар хууль болон журамд өөрчлөлт оруулах шаардлагатай.

ТҮР ХАМГААЛАХ БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, СТАНДАРТЫГ ҮНЭЛСЭН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1 Баримт бичгийн судалгааны тойм

Монгол Улсын Жендэрт суурилсан хүчирхийллийн 2017 оны тайлангаар хамтрагчтай байсан болон одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 57.9% нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийлэл, хянах зан үйл зэрэг хүчирхийллийн хэлбэрүүдээс аль нэгд нь юм уу эсвэл хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд амьдралын туршид өртсөн байна⁹. Мөн тэдний 31.2% нь бие махбодын болон эсвэл бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртжээ. Хамтрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын болон/эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж бэртэл, гэмтэл авсан эмэгтэйчүүдийн 71.6 хувь нь хүнд буюу ноцтой бэртэж, таван эмэгтэй тутмын хоёр нь буюу 21.0 хувь нь хөнгөн гэмтэж, 5.0 хувь нь дунд зэрэг гэмтжээ. Гэмтсэн, эмнэлгийн тусламж авсан эмэгтэйчүүдийн 43.2 хувь нь гэмтлийн бодит шалтгаанаа эмнэлгийн ажилтанд мэдээлсэн байна (НҮБ-ын Хүн амын сан, 2017).

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай холбоотой 2017 болон 2019 онуудад хоёр үнэлгээ хийгдсэн байна. Эхнийх нь “Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ”, удаах нь “Нэг цэгийн үйлчилгээний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ” юм. Харин 2020 онд түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой судалгаа хийгдсэн нь “Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа” байв. Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны үйл ажиллагаатай холбоотой нийт 3 үнэлгээ хийгдсэн байгаа бөгөөд ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн стандартыг үнэлсэн судалгаа огт хийгдээгүй байна.

Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-дийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан. НҮБ-ын Хүн амын сангийн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газраас хийсэн 2017 оны судалгаагаар хүчирхийллийн хохирогчдод нэг цэгээс цогц үйлчилгээ үзүүлэх арга барил нь хэрэгцээ шаардлагад ихэд нийцэж байна. Одоогоор ажиллаж буй НЦҮТ-ийн загварууд нь зайлшгүй шаардлагатай чанартай үйлчилгээг цогцоор нь үзүүлсээр байх боломжтой байгаа ч салбар дундын хамтын ажиллагаа, зохицуулалт ба үүрэг хариуцлагыг илүү боловсронгуй болгох шаардлага байсаар байна. Хэдийгээр зарим үйлчилгээний чанар хийгээд хүртээмжийг сайжруулахад зохих бэрхшээлүүд тулгарсаар байгаа ч НЦҮТ-үүд нь өөрт байгаа хязгаарлагдмал нөөцөө үр ашигтай ашиглаж, үр дүнд хүрч байна гэж үзэх үндэстэй байна. Цаашид бүх үйлчилгээг цогцоор нь НҮБ-ын Нэн шаардлагатай

⁹ Үндэсний статистикийн хороо, Тэгш эрхийн төлөө дуу хоолойгоо өргөх нь (Үндэсний статистикийн хороо ба Монгол дахь Нэгдсэн Үндэстний байгууллагын хүн амын сан, 2018 он, Улаанбаатар хот), х.13, 16.

үйлчилгээний багцийн удирдамжид бүрэн нийцсэн байдлаар чанартай үзүүлэхийн тулд НЦҮТ-дийн үйл ажиллагаа, үйлчилгээг илүү боловсронгуй болгох шаардлагатай гэж үзжээ (UNFPA, 2017).

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээний төв”-тэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ. Одоо ажиллаж буй эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ-үүд (СБД-ээс бусад) нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын, халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа боловч сэтгэл зүй болон хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөц хомсдолтой, гэрээгээр авч ажиллуулдаг, зарим газар огт байхгүй байна. Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ-ийн сэтгэл зүйч нарт зориулсан сэтгэл зүйн гэмтэл бэртлийг оношлох оношилгооны нэгдсэн аргачлал, загвар байхгүй байна. Үйлчилгээ үзүүлэх нарийвчилсан процедур нь тодорхойгүйгээс журмын заалтуудыг ойлгох, тайлбарлах, хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэхээр байна гэсэн үр дүн гарчээ (ЭМЯ, 2019).

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь хувийн, ойр дотнын харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, боловсролын орчинд, гудамж талбайд, ер нь нийгмийн бүхий л хүрээнд үйлдэгддэг. Эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа суурь шалтгаан нь учраас ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгддэг. Нийгэмд хэвийн үзэгдэл болтлоо хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хүмүүсийн үзэл хандлагаар дэмжигдэж байдаг аж. Жендэрт суурилсан хүчирхийлэлд олон хүчин зүйл нөлөөлдөг, тэдгээр хүчин зүйлс нь давхацдаг, өөр, өөр нөхцөлд янз бүрээр илэрдэг, олон талт асуудал юм. Энэ нь амьдралын турш тохиолдож болох ба амьдралын аль мөчлөгт тохиолдож болохоос шалтгаалан өөр өөр байдаг ч хоорондоо холбоотой (ХНХЯ, 2019) байдаг ажээ.

Нэг цэгийн үйлчилгээний төв. Хууль зүй, дотоод хэргийн сайд, эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 сарын 06 өдрийн А/80, А/32, А/60 тоот тушаалаар батлагдсан “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам”-д зааснаар нэг цэгийн үйлчилгээний төв нь эмнэлэг, төр, төрийн бус байгууллагын харьяанд ажиллана. “Нэг цэгийн үйлчилгээний төвийн санхүүжилтийн журам”-аар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд өртөх магадлалтай иргэнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй, 24 цагийн турш үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна гэж заасан байдаг.

Түр хамгаалах байр. “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-аар хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг 24 цагийн хуваариар, аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, сэтгэл зүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах зэрэг хуулиар зохицуулагдсан үйлчилгээнүүдийг мэргэжлийн түвшинд үзүүлж, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, чадавхжуулах шаардлагатай гэж заасан. Эдгээр үйлчилгээг үзүүлэхэд түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрх зүйч, дөрөв ээлжийн ажилтан нийт долоон албан хаагч ажиллахыг журамласан байдаг. (Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 2020) “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 5-р зүйлд тусгаснаар түр хамгаалах байр нь эмнэлгийн тусламж, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамж, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, түр хамгаалан байрлуулах үйлчилгээний онцлогт тохирсон бусад үйлчилгээг хүргэнэ хэмээн заажээ.

4.2 ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал (Стандарт ажиглалтын үр дүн)

Энэхүү үнэлгээг Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS:6040-2019 стандартын хүрээнд ТХБ, НЦҮТ-ийн “нийтлэг шаардлага, барилга байгууламж, эрүүл ахуйн шаардлага, санхүүгийн нөхцөл байдал, хүний нөөц, түр хамгаалан байршуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, эмнэлгийн тусламж үйлчилгээ зэргийг үнэлсэн. Уг үнэлгээний түүврийн хүрээг захиалагчийн саналд тулгуурлан сонгон авч стандарт ажиглалтын судалгааны аргачлалыг ашиглан гүйцэтгэсэн болно. ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийн байдлыг судалгаанд хамрагдсан 12 байгууллагын үнэлгээнд тулгуурлан авч үзлээ. Ихэнх ТХБ-ны хувьд аймаг, дүүргийн ГБХЗХХ-ийг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа бол зарим НЦҮТ-ийн хувьд төрийн байгууллагын дэргэд тухайлбал, Завханы НЦҮТ Цагдаагийн байгууллага түшиглэсэн, Баянгол дүүргийн НЦҮТ Гэмтэл согог судлалын төвийн харьяанд, Баянзүрх дүүргийн НЦҮТ Цагдаагийн 3-р хэлтэст түшиглэн тус тус үйлчилгээ үзүүлж байна. Хан-Уул дүүргийн НЦҮТ-ийн хувьд ГБХЗХХ-ийн хэлтсийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг ба ТХБ-тай адилхан үйлчилгээ үзүүлдэг онцлогтой.

Хүснэгт 4.1. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын ерөнхий мэдээлэл

	№	Ажилтны тоо	Орны тоо	Өрөөний тоо	Сард үйлчилгээ авч буй хүний тоо		Сард үйлчилгээ авч буй хүүхдийн тоо	
					эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
ТХБ	Архангай ТХБ	3	8	3	1	6	4	9
	Орхон ТХБ	2	5	3	2	2	2	3
	БГД-ийн ТХБ	4	8	8	0	0	2	2
	Сэлэнгэ ТХБ	2	4	4	0	3	0	1
	ХХХҮ-ний ТХБ	17	25	2	0	0	34	72
НЦҮТ	ГССҮТ-ийн НЦҮТ	10	3	3	0	30	6	8
	БЗД-ийн НЦҮТ	8	4	1	0	12	2	0
	Завхан НЦҮТ	7	8	8	4	4	0	4
	ЧД-ийн НЦҮТ	7	5	5	0	2	0	1
	СБД-ийн НЦҮТ	2	3	3	0	0	1	3
	Дорнод НЦҮТ	2	2	1	1	1	1	1
	БГД-ийн НЦҮТ	11	10	10	0	0	7	8

Эх сурвалж: Стандарт ажиглалтын үр дүн

Эдгээр байгууллагуудын хувьд чухам ямар төрлийн үйлчилгээг хэдэн хүнд, хэрхэн үзүүлж буй талаар судалсан. Ихэнх ТХБ, НЦҮТ-ийн хувьд шаардлагатай хүний нөөц байхгүй, төсөв хомсдолтой, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл хангалттай биш байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ харилцан адилгүй, ихэвчлэн стандарт шаардлага хангахгүй байгаа юм.

Хүснэгтээс харахад үйлчлүүлэгч хүлээн авах байдлын хувьд НЦҮТ-ийн орны хүрэлцээ маш бага буюу 2-8 хүртэл хүн түр хугацаанд хүлээн авах бөгөөд нэгэн зэрэг олон хүн хүлээн авах боломж

хомс байдаг ажээ. Мөн тухайн үйлчлүүлэгчийг нас, хүйс, кейсийн онцлогоос нь хамаарч тусдаа байрлуулах боломж байдаггүй. Харин ТХБ-ны хувьд 4-25 хүртэл хүн хүлээн авах боломжтой буюу үйлчлүүлэгчийн кейс, нас, хүйсийг харгалзан тусад нь, өөр өрөөнд байрлуулах боломжтой байна.

ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийг үнэлэхдээ Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартын агуулгыг баримталсан болно. Ингэхдээ хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандартыг бүрэн хангасан(зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлсэн, хэрэгжсэн, үр дүн гарсан бол), хэсэгчлэн хангасан(шалгуур, шаардлагыг тодорхой хэмжээнд гэхдээ бүрэн хангаагүй, хэрэгжилт, үр дүн дутуу бол), хангаагүй(шалгуур, шаардлагыг огт хангаагүй, хэрэгжилт, үр дүн байхгүй бол) гэсэн үндсэн гурван үзүүлэлтээр үнэлсэн болно.

ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлсэн болно.

Хүснэгт 4.2. ТХБ ба НЦҮТ-ийн стандартын хэрэгжилт

№	Стандарт хэрэгжилтийн үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
			3	2	1
1	Байгууллагад тавих нийтлэг шаардлага	8*12=96	78/81.3%	12/12.5%	6/6.3%
2	Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага	22*12=264	174/65.9%	50/18.9%	40/15.2%
3	Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлага	4*12=48	40/83.3%	7/14.6%	1/ 2.1%
4	Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих нийтлэг шаардлага	5*12=60	47/78.3%	8/13.3%	5/8.3%
5	Санхүүжилт	3*12=36	26/72.2%	5/13.9%	5/13.9%
6	Хүний нөөц	11*12=132	79/59.8%	30/22.7%	23/17.4%
7	Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага	9*12=108	95/88.0%	5/4.6%	8/7.4%
8	Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага	6*12=78	71/98.6%	1/1.4%	0/0.0%
9	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	5*12=60	47/78.3%	8/13.3%	5/8.3%
10	Сэтгэлзүйн үйлчилгээ	4*12=48	41/85.4%	7/14.6%	0/0.0%
11	Хуулийн зөвлөгөө, туслалцаа	3*12=36	32/88.9%	1/ 2.8%	3/8.3%
12	Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ	4*12=48	34/70.8%	10/20.8%	4/8.3%
13	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	3*12=36	30/83.3%	4/11.1%	2/5.6%
14	Холбон зуучлах үйлчилгээ	3*12=36	34/94.4%	2/5.6%	0/0.0%
15	Үйлчилгээг дуусгах	2*12=24	19/79.2%	2/8.3%	3/12.5%
16	Нууцлалыг хангах	7*12=84	70/83.3%	9/10.7%	5/6.0%
17	Хориглох зүйл	4*12=48	44/91.7%	0/0.0%	4/8.3%

1. ТХБ, НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийг байгууллагад тавих нийтлэг шаардлагыг нийт 8 үзүүлэлтээр үнэлэхэд Нийгмийн үйлчилгээ, хохирогч хамгааллын чиглэлээр мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцтэй эсэх; Хохирогчид байрлах хугацаанд хэрэглэгдэх эрүүл ахуй, ариун цэврийн хэрэглэл, шаардлагатай тохиолдолд нэг удаагийн гутал, хувцсаар хангадаг эсэх зэрэг үзүүлэлтийг хэсэгчлэн хангасан хэд хэдэн тохиолдол харагдаж байна. Мөн хуулийн этгээдийн гэрчилгээтэй, Төрийн эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн эсэх шалгуурыг хангаагүй боловч үйл ажиллагаа явуулж буй ТХБ, НЦҮТ-үүд байна. Нийтлэг шаардлагын 1-р үзүүлэлтийг хоёр байгууллага хангаагүй бөгөөд байргүй, гэрчилгээ байхгүй, тусдаа гэрчилгээгүй гэсэн хариултыг өгсөн. Хэсэгчлэн хангасан нэг байгууллагын хувьд байгуулагдаад нэг жил болж байгаа гэж хариулжээ. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд Нийтлэг шаардлагын 2-р үзүүлэлтийг 3 байгууллага хангаагүй ба магадлан итгэмжлэл байхгүй буюу ороогүй гэж тус тус хариулжээ. Нийтлэг шаардлагын 3-р үзүүлэлтийг 1 байгууллага хангаагүй гэж хариулсан бөгөөд сул орон сууцнаас гаргаж өгсөн байр хэмээжээ. Мөн нийтлэг шаардлагын 5-р үзүүлэлтийг хангаагүй нэг байгууллага байгаа бөгөөд сэтгэл зүйч болон эмч дутуу гэж хариулсан байна. Нийтлэг шаардлагын 8-р үзүүлэлтийг 4 байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулсан ба зарим тохиолдолд ТББ-д хандах шаардлага гардаг, хувцасны нөөц байхгүй гэжээ. (Хавсралт 2 үзнэ үү)
2. Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагыг нийт 22 үзүүлэлтээр үнэлсэн. Тухайн үнэлгээнээс үзэхэд Түр хамгаалах байранд хохирогчдыг хамт байрлуулах тохиолдолд тухайн кэйсийн онцлогийг харгалзан гэр бүлийн эсвэл бэлгийн хүчирхийллийн хохирогч зэрэг хэлбэрээр зорилтот бүлгээр нь тус тусад нь байрлуулж байгаа эсэх-58.4%, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээ онцлог байдалд тохирсон түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдсан хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлдэг эсэх-50.0%, Хохирогч болон ажилтнууд тусдаа ариун цэврийн өрөө, шүршүүртэй байгаа эсэх-33.3% зэрэг үзүүлэлтийг хангахгүй байх нь өндөр хувьтай байна. Харин хэсэгчлэн хангасан үзүүлэлтийн хувьд Гэрийн орчинтой дүйцэхүйц амрах ор бүхий унтлагын өрөөтэй байх ба нэг хүнд ногдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5м кв-аас доошгүй байгаа эсэх-50.0%, Барилга байгууламж байгаа газар орчныг тойруулаад хашаа, Хамгаалалттай, гаднаас нэвтрэх боломжтой бүх цонхонд хаалт, хөшиг хийсэн, хаалга бүрэн ажиллагаатай, түгжээтэй, гадагшаа онгойдог эсэх-41.7%, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээ онцлог байдалд тохирсон түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдсан хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлдэг эсэх-33.3% зэрэг үзүүлэлт гарсан байна.
3. Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагыг нийт дөрвөн шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд хангаагүй 3, хэсэгчлэн хангасан 5 ТХБ, НЦҮТ байна. Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, мөн адил нэг байгууллага хэсэгчлэн хангадаг хэмээн хариулсан байна. 60280 тав хоногт хоол хүнс, үзүүлэх үйлчилгээ орсон байдаг нь хангалттай биш хүрэлцээгүй, өдөрт 5000 төгрөг ноогддог гэж үзэж байна хэмээн хариулжээ. Мөн түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу тогоочгүй гэж хариулсан байна.
4. Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих нийтлэг шаардлагыг нийт 5 шалгуураар үнэлсэн байна. Үнэлгээний үр дүнгээс үзэхэд 3 байгууллага хангаагүй, 7 байгууллага хэсэгчлэн хангасан байна.
5. Санхүүжилтэд тавих шаардлагыг нийт гурван шалгуур үзүүлэлтээр үнэлэв. Ингэхэд хангаагүй 4, хэсэгчлэн хангасан 5 байгууллага байлаа. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцож байгаа

- эсэхийг 3 байгууллага хангаагүй бөгөөд энэ нь санхүүжилтийн журам болон төсвийн хомсдолоос үүдэлтэй байна.
6. Хүний нөөцийн үзүүлэлтийг хангаагүй байгууллагууд цөөнгүй, хэсэгчлэн хангасан байгууллагууд олон байна. Тухайлбал, Түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон тогооч орон тоогоор ажиллаж байгаа эсэх шалгуурыг 58.3% нь хэсэгчлэн хангажээ. Мэргэжлийн нийгмийн ажилтан байхгүй, сэтгэл зүйч, эрх зүйч ажилладаг, тогооч байхгүй байна хэмээн тус тус хариулт өгсөн байна. Мөн Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалан байрлуулах төрөлжсөн хамгаалах байранд 11.1-т заасан мэргэжилтнүүдээс гадна эмнэлгийн мэргэжилтэн орон тоогоор ажиллаж байгаа эсэх шалгуурыг 25.0% нь хэсэгчлэн хангасан, 50% нь огт хангаагүй байсан юм. Мөн түр хамгаалах байрны хүчин чадал, санхүүжилтээс шалтгаалан хүүхэд хамгааллын ажилтан, халамжийн ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, харуул хамгаалалтын ажилтныг гэрээгээр ажиллуулж байгаа эсэх шаардлагыг 33.3% нь хангаагүй, 41.7% нь хэсэгчлэн хангасан байна.
 7. Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг 9 үзүүлэлтээр үнэлсэн. Үнэлгээнээс үзэхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг өвөрмөц хэрэгцээтэй үйлчлүүлэгчид тохирох хэрэгслээр хангаж, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн эсэх шалгуурыг хэсэгчлэн хангасан-4, хангаагүй-4 байгууллага байна. Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагын 4-р үзүүлэлтэд дөрвөн байгууллага хангаагүй (байхгүй, нөөц бололцоогоороо дутмаг, орчин бүрдээгүй), мөн адил дөрвөн байгууллага хэсэгчлэн хангасан (эрүүл мэндийн байдлаас нь шалтгаалдаг) хэмээн хариулжээ.
 8. Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагыг 6 шалгуураар үнэлсэн. Хохирогчийг хүлээн авах бүртгэх үйлчилгээнд тавих шаардлагыг ханган ажиллаж байна.
 9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг нийт таван шалгуураар үнэлсэн. Үнэлгээнээс үзэхэд Түр хамгаалах байранд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээдэг эсэх-41.7% хэсэгчлэн хангасан байна. Мөн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн, холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулахаар хүргүүлэн, нэгдсэн тайлан мэдээ гаргадаг эсэх шалгуурыг 1 байгууллага хэсэгчлэн хангасан, 2 байгууллага хангаагүй байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй (эмчгүй), нэг байгууллага хэсэгчлэн хангасан (хариуцсан хүн байдаггүй) хэмээн тус тус хариулсан байна.
 10. Сэтгэлзүйн үйлчилгээг нийт 4 шалгуураар үнэлсэн болно. Сэтгэл зүйн үйлчилгээнд тавих шаардлагын 2,3,4-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан (сэтгэл зүйч) хэмээн хариулжээ.
 11. Хуулийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх байдлыг нийт 3 шалгуураар үнэлсэн. Хуулийн зөвлөгөө туслалцаанд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй, нэг байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулжээ.
 12. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тавигдах шалгуурыг дөрвөн үзүүлэлтээр хэмжсэн. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, гурван байгууллага хэсэгчлэн хангасан буюу мэргэжлийн зөвлөгөө өгөх ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай, Нөхцөл байдлын үнэлгээг цөөхөн хамтарсан баг хийдэг хэмээн тус тус хариулсан байна. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй, таван байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулсан байна.
 13. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг гурван үзүүлэлтээр үнэлсэн. Тайлбар: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу цогц үйлчилгээ хүргэхэд

анхаардаг ч үр чадвар дутуу гэж хариулсан байна. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу хүүхэд авдаггүй хэмээн хариулжээ. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу хэрэглэгдэхүүн боломж дутмаг, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу шаардлагатай бол бичиг баримт бүрдүүлэхэд тусалдаг хэмээжээ.

14. Холбон зуучлах үйлчилгээг мөн гурван шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжих зорилгоор бусад байгууллага, үйлчилгээнд холбон зуучилдаг эсэх шалгуурыг хэсэгчлэн хангаж буй 2 байгууллага байна.
15. Үйлчилгээг дуусгахтай холбоотой үнэлгээг үндсэн хоёр шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Үйлчилгээг дуусгахад тавигдах шаардлагын 2-р үзүүлэлт Үйлчилгээг дуусгаж, кейс хаах, шилжүүлэх бүрд харьяа сум, хороо, багийн Хамтарсан багтай хамтран Нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулын зэргийг үнэлэх ажлыг дахин хийж, хүлээлгэн өгдөг эсэх шалгуурын хувьд нэг байгууллага хангаагүй, мөн адил нэг байгууллага хэсэгчлэн хангасан (ТХБ-аас гарахдаа хийдэггүй, гэрийн эргэлтээр очихдоо хийдэг) гэж хариулсан байна.
16. Нууцлалыг хангах шалгуурыг үндсэн 7 үзүүлэлтээр үнэлсэн юм. Хохирогчийг хүлээн авах хэсэг нь хамгаалах байрнаас тусдаа байх шаардлага хангагдсан эсэх шалгуурыг бүрэн хангасан 2, хангаагүй 3 байгууллага байна. Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд гурван байгууллага хангаагүй буюу тусдаа байргүй, цагдаа тухайн үйлчлүүлэгчийн авч ирдэг гэжээ. Хохирогчийн бүртгэл, тэмдэглэл болон бусад бүхий л бичиг баримт хамгаалалттай орчинд, цоожтой шүүгээнд хадгалдаг эсэх шалгуурыг 3 байгууллага хэсэгчлэн хангасан бол огт хангаагүй нэг байгууллага байлаа. Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу цоожгүй, гурван байгууллага хэсэгчлэн хангасан буюу цоож нь эвдэрсэн, цоожгүй шилэн хаалгатай шүүгээнд бичиг баримтууд байдаг хэмээн хариулсан юм. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь нууцын зэрэглэлтэй баримт бичиг хүлээн авах, хариу өгөх, хадгалах журамтай байгаа эсэх шалгуурыг 2 байгууллага хэсэгчлэн хангасан бол 1 байгууллага огт хангаагүй байв.
17. Хориглох зүйлтэй холбоотой шалгуур үзүүлэлтийг дөрвөн шалгуураар тодорхойлсон болно. Хяналтын камерыг хохирогчийн байрлах өрөөнд байршуулахыг хориглон ажилладаг эсэхийг 3 байгууллага хангаагүй байна. Дээрх хариултын хувьд өрөө болгонд камер байршуулсан гэж хариулжээ.

4.3 ТХБ, НЦҮТ-ийн стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал (Ярилцлагын үр дүн)

Өмнөх бүлэгт ТХБ болон НЦҮТ-ийн стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдлыг стандарт ажиглалтад тулгуурлан үнэлсэн бол энэ хэсэгт стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг авч үзлээ. ЖСХ-ийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэх Түр хамгаалах байр (ТХБ) 5, Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) 7 төвийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй бэрхшээл, үзүүлж буй үйлчилгээний төрөл түүнтэй холбоотой хүндрэлүүд, үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбоотой асуудлыг судлан, тодорхойлоход энэ хэсэг бүхэлдээ чиглэсэн юм.

ТХБ, НЦҮТ-ийн стандартыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох ганцаарчилсан ярилцлагад оролцогч нийгмийн ажилтнуудыг насны хувьд авч үзэхэд 22-50 хүртэлх насны

эмэгтэйчүүд байгаа бөгөөд дундаж нас нь 37 байна. Судалгаанд оролцогчдын 8 буюу 66.7% нь нийгмийн ажилтан мэргэжлийг эзэмшсэн мэргэжлийн хүмүүс бөгөөд 3 мэргэжлийн бүс хүн нь мэргэжилтэн болон ээлжийн ажилтан гэсэн албыг хашиж байна. Боловсролын зэргийн хувьд магистрын зэрэгтэй-2, бакалаврын зэрэгтэй 9 хүн хамрагдсан болно. Ажлын туршлагын хувьд хамгийн бага жил ажилласан нь 0.2 жил бол хамгийн олон жил ажилласан нь 10 жил ажилласан мэргэжлийн туршлагатай хүмүүс байв. Ажилтан, мэргэжилтнүүдийн ажилласан жилийн дундаж 2.7 жил байна.

Хүснэгт 4.3. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын ерөнхий мэдээлэл

	№	Нас	Хүйс	Мэргэжлийн зэрэг	Үндсэн мэргэжил	Албан тушаал	Байгууллагад ажиллаж буй жил
ТХБ	1.	26	Эм	Бакалавр	Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан	2 жил
	2.	31	Эм	Бакалавр	Эрх зүйч	Мэргэжилтэн	0.6 жил
	3.	45	Эм	Бакалавр	Эрхзүйч	Мэргэжилтэн	0.2 жил
	4.	22	Эм	Бакалавр	Нийгмийн ажилтан	Ээлжийн нийгмийн ажилтан	1 жил
	5.	40	Эм	Бакалавр	Нийгмийн ажилтан	Ахлах нийгмийн ажилтан	0.6 жил
НЦҮТ	1.	32	Эм	Магистр	Эрх зүйч	Эрүүл мэндийн нийгмийн ажилтан	10 жил
	2.	23	Эм	Бакалавр	Эрх зүйч	Нийгмийн ажилтан	0.8 жил
	3.	36	Эм	Бакалавр	Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан	4 жил
	4.	49	Эм	Коллежийн зэрэг	Бизнес судлаач, эдийн засагч	Ээлжийн ажилтан	5 жил
	5.	50	Эм	Бакалавр	Нийгмийн ажилтан	Нийгмийн ажилтан	3 жил
	6.	41	Эм	Бакалавр	Харилцааны сэтгэл зүй	Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	0.8 жил
	7.	52	Эм	Бакалавр	Хуульч	Зохицуулагч	9 жил

Тус ярилцлагад нийт 5 ТХБ, 7 НЦҮТ-ийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнууд хамрагдсан юм. Тус хүснэгтээс үзэхэд мэргэжлийн нийгмийн ажилтны зэрэгцээ мэргэжлийн хуульч, сэтгэл зүйч зэрэг хүмүүс ажил үүргийн онцлогийн дагуу ажиллаж буй нь харагдсан болно. ТХБ, НЦҮТ-ийн онцлогийг авч үзэхэд орон нутгаас 2 НЦҮТ, 3 ТХБ, нийслэлээс 5 НЦҮТ, 2 ТХБ тус тус хамрагджээ. ТХБ-ны хувьд 3 сар хүртэлх хугацаанд хамгаалах байрны үйлчилгээ үзүүлнэ. Эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төв бөгөөд 24-72 цагийн хугацаанд эрүүл мэндийн болон бусад төрлийн үйлчилгээг шуурхай үзүүлж байна. ХУД-ийн Нэг цэгийн үйлчилгээний төв гэсэн нэршлээр үйл ажиллагаа явуулдаг ч түр хамгаалах байрны үйлчилгээг давхар үзүүлдэг.

ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтэн албан хаагчдаас ажиллаж буй төвийн онцлог, төрөл хэлбэр, эрхэлж буй ажлын талаар энд товч танилцуулж байна.

ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний онцлог, нэгж хугацаанд үйлчилгээ үзүүлэх хүний багтаамж

Хүснэгт 4.4. ТХБ-ны үйл ажиллагааны онцлог

Байгууллагын төрөл	Байгууллага	Үйлчилгээний онцлог, төрөл хэлбэр
Түр хамгаалах байр	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний ТХБ	0-18 насны хүчирхийлэлд өртсөн хүүхдэд түр байршуулан хамгаалах үйлчилгээг үзүүлдэг. Баянзүрх дүүрэг, Сонгино хайрхан дүүрэг, Багануур дүүрэг, Налайх дүүргийн хүүхдүүдэд үйлчилгээг хүргэдэг.
	Баянгол дүүргийн түр хамгаалах байр	ТХБ нь байгуулагдаад 1 жил болж байна. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг. Гол онцлог нь хүүхэд энд байх хугацаандаа хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаанд хамрагддаг. Энд 7 хоног бүр бага, дунд, ахлах ангийн хөтөлбөр хэрэгждэг. 3 ээлжийн нийгмийн ажилтан ажил үүргээ хуваагаад гүйцэтгэдэг.
	Архангай аймгийн ГБХЗХХ-ийн Түр хамгаалах байр	2019 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Аймгийн ГБХЗХХ-ийн дэргэд байдаг. Олон улсын байгууллагын төсөл, санхүүжилтээр тусдаа байртай болсон Үйл ажиллагаа харьцангуй тогтворжсон.
	Орхон аймгийн ГБХЗХХ-ийн түр хамгаалах байр	Орхон аймгийн ТХБ нь нийтийн орон сууцны дунд 2 өрөө байр түрээслэх байдлаар үйл ажиллагаа явуулдаг. Нэг удирдлага, нэг нийгмийн ажилтантай, ТХБ дээр ажиллаж буй нэг хүн байна, хүний нөөц дутагдалтай.
	Сэлэнгэ аймгийн ГБХЗХХ-ийн түр хамгаалах байр	Сэлэнгэ аймагт ТХБ хоёр байдаг ба нэг нь Мандал суманд, нэг нь Алтанбулаг суманд тус тус үйл ажиллагаа явуулж байна. Уг хоёр газар нь нийт сумдын ард иргэдэд үйлчилгээ үзүүлдэг ер нь бол ойрын сумдынх манай дээр ирдэг. Гэхдээ нууцын зэрэглэлтэй гэдгийг хүмүүс мэдэхгүй.

Хүснэгт 4.5. НЦҮТ-ийн үйл ажиллагааны онцлог

Байгууллагын төрөл	Байгууллага	Үйлчилгээний онцлог, төрөл хэлбэр
Нэг цэгийн үйлчилгээний төвүүд	Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн дэргэдэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг Цэгийн Үйлчилгээний Төв”	Эрүүл мэндийн байгууллага түшиглэсэн учраас илүү эрүүл мэнд талаас нь үйлчилгээ үзүүлдэг. Хүчирхийлэлд өртсөн хүмүүст бүх л үйлчилгээг үзүүлнэ. Нэг дороос хууль эрх зүйн үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ гээд үзүүлдэг.
	БЗД-ийн Нэг цэгийн үйлчилгээний төв	Байгууллага нь гэр бүлийн хохирогчийг хамгаалах байр гэсэн чиглэлтэй явж байгаа. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах, үйлчилгээг 2019 оноос эхлүүлсэн байна. Манай онцлог нь бусад нэг цэг, түр хамгаалахаа бодвол БЗД-ийн цагдаагийн 3 дугаар хэлтсээ түшиглэн байгуулагдсанаараа давуу талтай. Мөн цалингийн систем нь ТББ нэрээр явдаг ч орон нутгийн ИТХ-аас санхүүждэг. Орон нутгийн төсвөөс санхүүждэг.

	Сүхбаатар дүүргийн эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн үйлчилгээний төв	Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ учраас эмнэлгийн үйлчилгээ түлхүү үзүүлнэ. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, нарийн мэргэжлийн эмч нар үйлчилгээ үзүүлдгээрээ давуу талтай. 72 цагийн хугацаанд түр хамгаалан байрлуулна гэж байгаа боловч кейсээс хамаараад удаан байлгах эсэхээ шийддэг. Дандаа багаар тусламж үйлчилгээ үзүүлдэг. Сэтгэл зүйн кабинетээрээ дамжуулан томоохон байгууллагуудад сургалт орж нөлөөллийн ажил хийдэг. Тухайлбал ЕБС, ЦЕГ, АТГ, Их дээд сургуулиудад сургалт орох болон сэтгэл зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг.
	Хан-Уул дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв	Манай хамгаалах байр нь гэр бүлийн болон, бэлгийн хүчирхийллийн хохирогчдыг хүлээн авч үйлчилгээ үзүүлдэг. Хамгаалан байршуулах, эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, хууль эрх зүйн үйлчилгээг үзүүлдэг. Журамд заасан хариу үйлчилгээнүүдээ үзүүлдэг. Миний хувьд түр хамгаалах байрандаа ээлжийн нийгмийн ажилтан хийдэг. 24 цаг гараад 48 цаг амардаг. Энэ хугацаандаа үйлчлүүлэгчдийн анхан шатны хэрэгцээг хангадаг.
	Чингэлтэй дүүргийн “Нэг Цэгийн Үйлчилгээний төв”	2019 оны 5 дугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. ЧД-ийн 17 дугаар хороондоо байршдаг. НЦҮТ нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүд, эрсдэлт нөхцөлд орсон ахмад настанд үйлчилгээ үзүүлнэ. 108-д ирсэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай хүмүүст үйлчилгээ хүргэнэ. Тэнд байгаа хүмүүсийг авах дуудлагаар очно.
	Дорнод аймгийн НЦҮТ	Анх энэ төв маань 2009 онд 7 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй Хэрлэн сумын зорилтот бүлгийн иргэдэд өдрийн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор ажиллаж эхэлсэн. Ингээд 2014 оноос Хохирогч хамгааллын байрны чиглэлээр 4 жил ажилласан. Тэгээд 2018 оноос эхлэн НҮБ-ын Хүн амын сангийн төслийн дэмжлэгтэйгээр “Нэг цэгийн үйлчилгээний төв” болж өргөжин одоог хүртэл хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна.
	Завхан аймгийн НЦҮТ	НЦҮТ цагдаагийн дэргэд байгуулагдсан цагдаагийн дэргэдэх НЦҮТ гэж явдаг Завхан аймгийн цагдаагийн газрын дарга, Завхан аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг, төрийн үзүүлэх үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа байгууллага юм.

Эдгээр ТХБ, НЦҮТ-ийн хувьд Үйлчилгээний өнөөгийн байдал, нэгж хугацаанд үйлчилгээ үзүүлэх хүний багтаамж, хүчин чадал, ТХБ ба НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээ, тулгамдаж буй асуудлууд, хохирогчийн эрх үүрэгтэй холбоотой асуудлууд, ТХБ, НЦҮТ-ийн бүтэц, байрлах хугацаатай холбоотой асуудлууд, үйлчилгээний төрөл ба түүнтэй холбоотой хүндрэлүүд, үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээтэй холбоотой хүндрэлүүд, үйлчилгээний тухай тайлагнал, үнэлгээ зэрэгт нарийвчилсан чанарын шинжилгээг Түр хамгаалах байр (ТХБ) 5, Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) 7 төвийн үйл ажиллагааг хийсэн.

Ганцаарчилсан ярилцлагын судалгаанд СХД, БЗД, Орхон, Сэлэнгэ, Архангай аймгуудын ТХБ-ны ажилтнууд, БЗД, СБД, ХУД, ЧД, Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төвийн (ГССҮТ), Дорнод Завхан аймгийн НЦҮТ-д ажиллаж буй ажилтнуудаас ганцаарчилсан ярилцлагын аргаар

судалгаа авсан юм. Ярилцлагад 22-26 насны ажилд ороод удаагүй 3 ажилтнаас бусад нь 31-52 насныхан энэ салбарт ажиллаж байгаа нь харьцангуй туршлага хуримтлуулсан ажиллагсадтай. Мэргэжлийн хувьд бүгд дээд боловсролтой ч, нийгмийн ажилтан мэргэжилтэй 6 байгаа нь хангалтгүй байна. Эрх зүйч-5, сэтгэл зүйч, хуульч, эдийн засагч мэргэжилтэй ажилтнууд энэ төвүүдэд ТХБ-ны нийгмийн ажилтан ба ээлжийн нийгмийн ажилтан, НЦҮТ-д нийгмийн ажилтан ба ээлжийн нийгмийн ажилтан, зохицуулагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан (ЭМНА), гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг албан тушаалуудад ажиллаж байна.

Ажилласан жилийн хувьд ТХБ-д дээд тал нь 2 сараас 2 жил хүртэл ажилласан ажилтнууд байсан бол НЦҮТ-д ажиллаж байгаа ажилтнуудаас 9-10 жил ажиллаж байгаа нь ГССҮТ, Завхан аймгийн НЦҮТ-ийн ажилтнууд, мөн ХУД, СБД, ЧД-ийн ажилтнууд 3-5 жил ажилласан, БЗД, Дорнод аймгийн НЦҮТ-ийн 8 хүртэлх сар ажилласан мэргэжилтнүүд тус тус судалгаанд оролцсон юм.

НЦҮТ, ТХБ-ийн үйлчилгээний онцлогтой холбоотой асуудлууд

НЦҮТ нь үйлчлүүлэгчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ, эрх зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээнүүдийг үйлчлүүлэгчдэд үзүүлдэг. Судалгаанд оролцсон 7 НЦҮТ-ийн БЗД, Завханых нь ЦЕГ-ын дэргэдэх, ГССҮТ, СБД нь эмнэлгийн дэргэдэх, ЧД, ХУД нь ГБХЗХХ-ийн дэргэд гэсэн статустай байна. Ихэвчлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид, охид эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настнууд мөн дуудлагын 108 төвөөр дамжин харьяаллаараа НЦҮТ-өөс үйлчилгээ авдаг байна. Хаана түшиглэн байгуулагдсан гэдгээс үзүүлж байгаа үйлчилгээнд ялгаатай дүр зураг ажиглагдсан. Тухайлбал: ГССҮТ, СБД-ийн НЦҮТ нь үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн үйлчилгээг түлхүү үзүүлдэг бол, ЦЕГ түшиглэсэн нь төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа байгууллага гэдэг утгаараа тухайн хохирогчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд илүү чармайлт гаргадаг, мөн цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан туршлагатай ажилтнууд энэ багт байдаг онцлогуудтай. Харин УБ хотын дүүргүүдээс СБД-ийн НЦҮТ-өөс ЕБС, ЦЕГ, АТГ, их дээд сургуулиудад 'архины хор хөнөөл, түүнээс үүдэлтэй хүчирхийлэл, хохирогчдын сэтгэл зүйн байдал' гэсэн сургалт болон сэтгэл зүйн туслалцаа үзүүлдэг үйлчилгээг давхар явуулсан нь онцлог байна.

Судалгаанд оролцсон 5 ТХБ-ны хувьд хүчирхийлэлд өртсөн 0-18 насны хүүхдүүдэд түр байршуулан хамгааллын хариу үйлчилгээг үзүүлдэг. ТХБ нь урт хугацаанд үйлчилгээ үзүүлдэг, байрлаж байгаа газар нь олон нийтэд ил биш зэрэг онцлогуудтай учраас УБ ба хөдөө орон нутаг гэсэн ангиллаар үйлчлүүлэгчээ авдаг байна. Тухайлбал, БЗД СХД, Багануур дүүрэг, Налайхын үйлчилгээнд хамрагдах шаардлагатай хүүхдүүд БЗД-ийн ТХБ-нд ирсэн байна. СХД-ийн хувьд бага, дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг төдийгүй, үйлчилгээ авч байгаа хүүхдүүд тус хөтөлбөрт хамрагддаг байна. Сэлэнгэ аймагт 2 ТХБ-тай бөгөөд Алтанбулаг, Мандал суманд байдаг. Харин Архангай аймагт анх олон улсын байгууллагын төслөөр тусдаа байртай болсноор үйл ажиллагаа нь тогтвортой явагддаг бол Орхон аймгийн ТХБ нь орон сууцны дунд 2 өрөө байр түрээслэн 3 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулдаг, хүний нөөц дутагдалтай ажиллаж байна. Стандартын нийтлэг шаардлагад тусгаснаар зориулалт бүхий өөрийн өмчийн эсхүл урт хугацаанд ашиглах боломжийг гэрээний нөхцөлөөр хангасан түрээсийн байртай байж болно гэж дурдсан боловч Орхон аймгийн ТХБ-түр хугацаанд түрээслэн ажиллаж байгаа нь стандарт хангасан гэж хэлэхэд бэрхшээлтэй байна.

Хуульд зааснаар НЦҮТ 7 төрлийн үйлчилгээг, ТХБ 6 төрлийн үйлчилгээг үзүүлэхийг заасан. НЦҮТ богино хугацаанд буюу 72 цаг хүртэлх хугацаанд үйлчлэх бол ТХБ нь нэгээс гурван сар


хохирогчийн байрлуулж, аюулгүй байдлыг хангах, нийгэм сэтгэл зүйн, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлдэг. Харин дамжих байр буюу хоёр дахь шатны түр хамгаалах байр нь 3-12 сарын хугацаанд хохирогчийг аюулгүй байрлуулах, хохирогчийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, бие даасан байдлыг хангахад туслах үйлчилгээ үйл ажиллагааг явуулдаг (М.Батбаатар, А.Батхишиг, Ш.Оюунханд, Г.Түмэннаст, 2019).

НЦҮТ-ийн үйлчилгээний төрөл	ТХБ-ны үйлчилгээний төрөл
Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33-р зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж үйчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ зэрэг 7 төрлийн үйлчилгээг хүргэнэ. Үйлчилгээг хүргэхдээ эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйчээс гадна цагдаагийн ажилтан, эрх зүйч, шүүхийн шинжээч, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, төвийн мэргэжилтнүүд болон шаардлагатай бусад мэргэжилтнүүдийг татан оролцуулна	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 5-р зүйлд зааснаар хамгаалах байр нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн төрийн, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран хохирогчид түүний эрх, хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ. Ингэхдээ эмнэлгийн тусламж үйчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, түр хамгаалан байрлуулах үйлчилгээний онцлогт тохирсон бусад үйлчилгээг буюу 6 төрлийн үйлчилгээг хүргэж ажиллана

НЦҮТ, ТХБ-д ЖСХ-ийн хохирогчийн эрх үүрэг, үзүүлэх үйлчилгээний стандарттай холбоотой асуудлууд



Нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах ба дамжих байрнууд нь бүгд хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангах, соёлын өвөрмөц онцлогийг харгалзах, албан байгууллагад бус гэр орондоо байгаа мэдрэмж төрүүлэх, бүх насны хүмүүст хүртээмжтэй, тэдэнд асаргаа сувилгаа үзүүлэх боломжтой байх, өвөрмөц хэрэгцээг хангах, хүмүүсийн ялгаатай амьдралын хэв маягт хүндэтгэлтэй хандах, хохирогчийг чадваржуулах гэх мэт зарчмуудыг баримтлах нийтлэг шинжүүдтэй. Харин манай судалгааны хувьд НЦҮТ, ТХБ-ын өнөөгийн дүр төрх үйлчлүүлэгчид гэртээ байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхүйц НЦҮТ, ТХБ байгаа нь сайшаалтай. Барилгын чанар стандартыг хамгийн сайн хангасан байгууллага бол БГД-ийн ТХБ бөгөөд 2021 онд ашиглалтад орсон. Хүүхэд хамгаалан байрлуулах стандартаар баригдсан. Нийтдээ 10 өрөөтэй, эрэгтэй эмэгтэй хүүхдүүдийг тусад нь байрлуулах боломжтой нийт 4 өрөөтэй.

Зураг 4.1. Стандартад нийцсэн байртай БГД-ийн ТХБ



Үүнээс гадна бага насны болон нярай хүүхдийг хүлээн авах боломжтой тусдаа өрөөтэй, нярай хүүхдийг унтуулах, суулгахад зориулсан ор, зориулалтын сандалтай байна.

Зураг 4.2. Стандартад нийцсэн байртай БГД-ийн ТХБ-ны оффис, ярилцлагын өрөө



Төвийн дулаанд холбогдсон, камержуулалт сайтай, амралтын өрөө, ганцаарчилсан ярилцлагын өрөөтэй, албан хаагчид болон үйлчлүүлэгчид тус тусдаа угаалгын өрөөтэй юм. Мөн үйл ажиллагаагаа жишиг болохуйц хэмжээнд явуулж буй Талита Ази ТББ-ын туршлагаас бусад ТХБ, НЦҮТ тодорхой туршлага солилцох шаардлагатай байна.



Шигтгээ

Талита Ази ТББ-ын туршлага, стандартаар явна гэвэл Монгол Улсын стандартыг зөрчсөн зүйл ярих байх. Үүдэндээ харуултай байна, манайх байхгүй, цонхондоо тортой байхад манайх байх шаардлагагүй гэж үздэг. 2 давхар ортой нэг өрөөнд 8 хүүхэд амьдардаг байх жишээтэй гэхэд манайх 1 өрөөнд 2 хүүхэд амьдруулж байна. Гэртээ байгаа юм шиг байдаг. Төрийн байгууллагаас манайд хүн ирээд Та нар арай давраачихсан, дураар нь байлгадаг юм биш үү гэдэг. Яг л орон гэр шиг том зай талбайтай байдаг. Тэгэхээр ТХБ-ны журам дээр зааснаас манай орчин нөхцөл байдал тэс өөр болчихож байгаа юм. Үйлчлүүлэгчийн аятай таатай нөхцөл байдлыг хангаснаараа бид бараг Монгол улсын журам зөрчсөн юм шиг л болчихно.

Урт хугацаа гэхээр 1 жил болж байгаа, манай төслөөс өмнө 5 жил болсон 19 хүрсэн гадна үйлчилгээ аваад явж байгаа үйлчлүүлэгч ч байна. Төрийн байгууллагаас манай байгууллагыг үзэж харсан хүмүүс бол үйлчлүүлэгч нь гэртээ байгаа юм шиг байдаг юм байна гэж ярьдаг.

Талита Ази ТББ, Нийгмийн ажилтан

ЖСХ, бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидод үзүүлэх үйлчилгээний стандарт гэж тусдаа гарсан баримт бичиг байдаггүй, бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх эрүүл мэндийн журмыг барин үйлчилгээг үзүүлдэг. Тиймд хуульд заасанчлан НЦҮТ нь 7 төрлийн, ТХБ нь 6 төрлийн үйлчилгээгээ үзүүлж байна. Үйлчлүүлэгчийг хамгаалан байрлуулах, эрх зүйн, сэтгэл заслын, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэн хүүхдийн аюулгүй байдал, тайван стрессгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Харин Ковид-19 цар тахлын халдвараас үүдэлтэй хорио цээрийн дэглэмийн үед бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо өмнөхөөсөө нэмэгдсэн байна.



Шигтгээ

Бэлгийн хохирогч хүүхдүүдийн тоо хөл хорионы үед тодорхой хэмжээнд өссөн байна. Өөрөөр хэлбэл 2020, 2021 онд болсон зүйл одоо илэрч мэдэгдэж байна. Яагаад гэхлээр гэр бүлийн хүмүүс болон хамаарал бүхий хүмүүс нь сүүлд мэдээд мэргэжлийн холбогдох байгууллагуудад мэдэгдэж байна. Жилдээ 5-7 хүүхэд байсан бол одоо буюу энэ жил 10-15 хүүхэд болоод байна. Нөхөн сэргээгдэх хугацаа цаг их ордог учраас мэргэжлийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх шаардлага их байна.

Дорнод аймгийн НЦҮТ-ийн Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Үйлчилгээ үзүүлэхэд саад болж нэг хүчин зүйл нь хувьд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид тусламж үзүүлэх орчны стандарт зарим НЦҮТ-д бүрдээгүй. Тухайлбал тусад нь байрлуулах боломж байхгүй, цөөхөн ортой, цөөн өрөөтэй байгаа нь саад болдог. Байр савны дутагдалтай байдлаас үүдэн, бусад хүүхдүүдтэй холилдоод өөрийнхөө тухай нууцаа дэлгэх, улмаар энэ нь сэтгэл зүйн асуудалд оруулах нөхцөл бүрддэг гэж нийгмийн ажилтнууд үзэж байна. Байрны хувьд УБ хотын хувьд ХУД-ын НЦҮТ стандартыг дунд зэрэг хангасан бол, СБД-ийн НЦҮТ стандарт хангаагүй байртай байна.

Стандарт дунд зэрэг хангасан байр: Хан-уул дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв нь 2017 оны 6 сараас хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа. Нийт 8 өрөөтэй. Эрэгтэй хүн хүлээн авах 1 өрөө, эмэгтэй хүн хүлээн авах 1 өрөө буюу хүчирхийллийн хохирогчийг хүлээн авах 2 өрөөтэй. Хохирогчийг кейсийн онцлогоос хамаарч тусдаа өрөөнд байрлуулах боломжгүй байна.

Зураг 4.3. Стандарт дунд зэрэг хангасан байртай ХУД-ийн НЦҮТ



Мөн албан хаагч нь тусдаа ажлын өрөөгүй, үйлчлүүлэгчид тусдаа хооллох хэсэг байхгүй гэх мэт дотоод зохион байгуулалт болон өрөөнүүдийн шийдэл нь стандартыг бүрэн хангаж чадахгүй байна.


Зураг 4.4. Стандарт дунд зэрэг хангасан байртай ХУД-ийн НЦҮТ-ийн гал тогоо, оффис



Зураг 3-аас харахад оффисын өрөө, хүүхэд саатуулах хэсэг, гал тогоо, хооллох өрөөний шаарлага хангагдаагүйгээс гадна, засвар үйлчилгээг ч сайн хийгдээгүй нь анзаарагдаж байна.

Стандарт хангаагүй байр: СБД-ийн НЦҮТ нь нийтдээ 3 өрөөтэй. Үйлчлүүлэгчийг хүлээн авах 1 өрөөтэй. Энэ нь үйлчлүүлэгчийг эрэгтэй эмэгтэйдээр болон кейсийн онцлогоос нь хамаарч тусад нь байрлуулах боломжгүй. Мөн энэ 2022 оны 5 сарын 1-ний өдрөөс эхлэн СБД-ийн нэг цэгийн үйлчилгээний төвийн байрыг Эрт илрүүлгийн зориулалтаар ашиглаж эхэлсэн байна.

Зураг 4.5. Стандарт хангаагүй байр: СБД, НЦҮТ



Дээрх байдлаас дүгнэхэд ТХБ, НЦҮТ зэрэг төрөөс хуулиар тогтоосон эрх үүргийн хүрээнд ажиллаж буй эдгээр байгууллагуудын байрны нөхцөл байдлын нэгдсэн стандартыг мөрдүүлэх, шаардлагатай газруудад яаралтай засвар үйлчилгээ цаашлаад шинээр барих арга хэмжээг авах шаардлагатай байна. Зарим НЦҮТ-ийн хувьд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг тусад нь байрлуулан үйлчилгээ үзүүлэх боломж бүрдээгүйгээс бэрхшээлүүд гардгийг мэргэжилтнүүд онцолж байна. Мөн удаан хугацаагаар байрлуулан үйлчилгээ үзүүлдэг ТХБ-ны нөхцөл байдлуудыг сайжруулснаар үйлчлүүлэгчид олон төрлийн сургалтад хамрагдах, сэтгэл зүйн хувьд хэвийн байдалдаа ороход үлэмж үүрэгтэй юм.

ТХБ-ны хувьд шаардлагатай мэргэжилтнүүдийн орон тоо хязгаарлагдмал, ялангуяа сэтгэл зүйчид шаардлагатай байна. БЗД-ын ТХБ-ны хувьд хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн нууцлалын аюулгүй байдал хангагдаж чадахгүй байна.

НЦҮТ-ийн 7 байгууллагад нийт 39 ажилтан албан хаагч ажиллаж байгаа нь дунджаар 5 албан хаагч нэг НЦҮТ-д ажиллаж байна. ТХБ-тай адил мэргэжлийн хүний нөөц дутагдалтайг, сургалт судалгаа хэрэгтэй байгааг, санхүүжилттэй холбоотой хүндрэлүүд нийтлэг ажиглагдаж байна.

ЖСХ-ийн хохирогчидтой хэрхэн ажиллах талаар заавар байхгүйгээс НЦҮТ, ТХБ-ны мэргэжилтнүүд үйлчилгээгээ хүртээмжтэй чанартай хүргэж чадахгүй байна. Тохиромжгүй асуулт асуучих вий, буруу ойлголт төрүүлчих вий гэсэн айдсаас үүдэлтэй ярилцлага хийх, үйлчлүүлэгчийнхээ итгэлийг олохоос үүдэлтэй харилцааны ур чадварууд дутагдалтай байна.

НЦҮТ, ТХБ-д ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, түүнтэй холбоотой асуудлууд

Судалгаанд оролцсон 7 НЦҮТ, 5 ТХБ нь үзүүлж буй үйлчилгээний төрлийг судлахад сэтгэл зүйн үйлчилгээ, эмнэлгийн, эрүүл мэндийн үйлчилгээг 10 газар нь хэрэгжүүлдэг, нийгмийн ажлын хүүхэд хамгааллын, холбон зуучлах үйлчилгээ, халамжийн хэмээн 7 газар, шаардлагатай тохиолдолд эрх зүйн туслалцаа үзүүлдэг хэмээн 5 газар хариулсан нь хамгийн өндөр давтамжтай байна.

Хүснэгт 4.6. НЦҮТ болон ТХБ ажиллаж байгаа ажилтнууд, бэлгийн хүчирхийллийн хохирогчийн талаарх мэдээлэл

Дүүрэг, аймаг	НЦҮТ, ТХБ-т ажиллагсдын тоо	Үйлчилгээ авч буй хүүхдийн тоо (сараар)	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын тоо	Үзүүлж буй үйлчилгээний төрөл
НЦҮТ				
Баянзүрх дүүрэг	8	14	-	Сэтгэл зүйн зөвлөгөө, эмнэлгийн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ
ГССҮТ	5	49	-	Эрүүл мэндийн үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ
Сүхбаатар дүүрэг	1	4	-	Шинжилгээ өгөх, анхан шатны эмнэлгийн үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө
Хан Уул дүүрэг	4	7	1	Аюулгүй байдлыг хамгаалах, шүүх эмнэлэгт хандах, анхан шатны тусламж, холбон зуучлах үйлчилгээ
Чингэлтэй дүүрэг	7	-	-	Эмчилгээ, зөвлөгөө, сэтгэл зүйг эмчлэх зураг зуруулах, яаралтай тусламж үзүүлэх
Дорнод аймаг	7	5	1	Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн оношилгоо, сэтгэл заслын үйлчилгээ
Завхан аймаг	7	8	8	Аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн ажлын үйлчилгээ, урлагийн сэтгэл засал, холбон зуучлах үйлчилгээ, хөгжлийн багц сургалт, гэр бүлд эргэн нэгтгэх
ТХБ				
Баянгол дүүрэг	7	17	-	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхэд хамгааллын үйлчилгээ, халамжийн үйлчилгээ, анхан шатны хэрэгцээг хангах үйлчилгээ, эмнэлгийн үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд эрх зүйн үйлчилгээнд холбон зуучилна
Баянзүрх дүүрэг	14	106	16	Сэтгэлзүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, асрах үйлчилгээ, нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ
Орхон аймаг	3	85	1	Сэтгэлзүйн үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, асрах үйлчилгээ, нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ
Сэлэнгэ аймаг	2	3-4	1	Эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрх зүй холбон зуучлах үйлчилгээ,
Архангай аймаг	5	21	2	Хүүхэд хамгааллын үйлчилгээ, хуульд заасан 7 төрлийн үйлчилгээ

Судалгаанд 7 НЦҮТ-д нийт 39 ажилтан ажиллаж байгаагаас дунджаар нэг байгууллагад 5 ажилтан ажилладаг бол Сүхбаатар дүүрэгт нэг л ажилтантай, Баянзүрх дүүрэг хамгийн олон 8 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. НЦҮТ-д бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэж бүртгэгдсэн 10 хохирогч байгаагаас Завхан аймагт 8 байгаа нь хамгийн их тохиолдол байлаа. Тэдэнд үзүүлж буй үйлчилгээний төрлүүдэд дараах үйлчилгээнүүд багтаж байна. Үүнд: Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл зүйн оношилгоо, сэтгэл заслын үйлчилгээ аюулгүй байдлыг хамгаалах, нийгмийн ажлын үйлчилгээ, урлагийн сэтгэл засал, холбон зуучлах үйлчилгээ, хөгжлийн багц сургалт, гэр бүлд эргэн нэгтгэх үйлчилгээнүүд байна.

5 ТХБ-нд нийтдээ 31 ажилтан ажиллаж байна. Баянзүрх дүүрэгт 14 ажилтан ажиллаж бол Баянгол дүүрэг 7, Архангай аймагт 5 ажилтан ажиллаж байна. ТХБ нь чиг үүргийнхээ хувьд НЦҮТ-өөс урт хугацаагаар үйлчилгээ үзүүлэх байгууллага атал Орхон, Сэлэнгэ аймгуудад зөвхөн 2-3 хан ажилтантай ч, сард 90 орчим хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн гэснээс мэргэжилтнүүд нь хаанаа ч хүрдэггүй байдал ажиглагдаж байна.



Шигтгээ

Тухайлбал БЗД-т ажиллаж буй мэргэжилтэн цалин маш бага, эрүүл мэндийн хувьд маш хүнд нярай хүүхдүүд хүртэл ирдгээс ажлын ачаалал өндөр байдаг тухай, Орхон аймагт үйлчилгээ үзүүлэхэд мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар дутагддаг, нийгмийн ажилтан хүрэлцдэггүй тухай, үйлчилгээг гардан гүйцэтгэдэг ганц хүн нь өөрийгөө үнэлэхэд ч, үйлчилгээний чанарын асуудлыг ярихад ч хүндрэлтэй байгаагаа, ялангуяа бэлгийн хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгч ирэхэд яриагаа хаанаас эхлэх вэ гэдэг нь үнэхээр хүнд.

Орхон аймгийн ТХБ-ны мэргэжилтэн

Бидний хувьд сургалт маш их хэрэгтэй байна. Ялангуяа стрессээс өөрсдөө хэрхэн ангижрах тухай, сургалт зөвлөгөө орж ур чадвартай болмоор байна.

Архангай аймгийн ТХБ-ны мэргэжилтэн

Бэлгийн хүчирхийллийн хохирогчийн талаарх мэдлэг мэдээллийг 'Хөөрхөн Зүрх' ТББ-аас явуулсан сургалтад сууж, бэлгийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар мэдлэгтэй болсон. Ер нь энэ талын мэдлэг мэдээлэл маш бага байна.

Баянзүрх дүүргийн ТХБ-ны мэргэжилтэн

Эндээс ТХБ-ны мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, холбогдох төсөв мөнгийг хэрхэн шийдэх асуудал, цаашлаад мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг авч ажиллуулах зэрэг нь эн тэргүүний асуудал болсон байна. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаар нарийвчилсан мэдлэг мэдээллүүдийг НЦҮТ болон ТХБ-ны мэргэжилтнүүдэд дээрх Хөөрхөн Зүрх ТББ болон энэ чиглэлийн бусад туршлагатай байгууллагуудаас сургалт зөвлөгөө авах шаардлагатай байна.

Хүснэгт 4.7. НЦҮТ, ТХБ-ны үйлчилгээг 1-5 оноогоор үнэлсэн байдал

	Үзүүлж буй үйлчилгээний төрөл	НЦҮТ								ТХБ					
		БЗД	ГССҮТ	Дорнод Аймаг	Завхан аймаг	СБД	ХУД	ЧД	Нийт оноо	БГД	БЗД	Орхон аймаг	Сэлэнгэ аймаг	Архангай аймаг	Нийт оноо
1	Хүрэлцээ	4	4	4	5	5	5	3	30	4	3	5	3	5	20
2	Хүртээмж	4	3	5	4	5	5	3	29	4	3	3	3	5	18
3	Уян хатан байдал	4	3	4	5	4	5	3	28	4	4	5	4	5	22
4	Тохиромжтой байдал	4	3	5	5	3	5	2	27	4	2	4	3	5	18
5	Аюулгүй байдал	4	3	5	5	5	3	3	28	4	4	5	3	5	21
6	Зөвшөөрөл авах	5	5	5	5	5	4	4	33	4	4	4	4	5	21
7	Нууцыг хадгалах	5	5	5	5	5	4	4	33	5	4	5	4	4	22
8	Мэдээлэл цуглуулах, мэдээллийн удирдлага	5	5	5	5	5	4	3	32	5	4	4	4	3	20
9	Холбон зуучлах, зохицуулах	5	5	5	5	5	3	4	32	5	4	5	4	4	22
	Нийт оноо	40	36	43	44	42	38	29		39	32	40	32	41	

Ганцаарчилсан ярилцлагад оролцсон ажиллагсдыг өөрийн ажиллаж буй НЦҮТ болон ТХБ-ны үйлчлүүлэгчдэд үзүүлж буй 9 төрлийн үйлчилгээг хэрхэн хүргэж байгааг 1-5 оноогоор (1-2 хангалтгүй, 3 дунд зэрэг, 4-5 хангалттай) үнэлүүлсэн юм. НЦҮТ болон ТХБ-ны хамгийн сайн үйлчилгээ нь үйлчилгээний уян хатан байдал, зөвшөөрөл авах, нууцыг хадгалах, мэдээлэл цуглуулах ба мэдээллийн удирдлага, салбар байгууллагуудад холбон зуучлах ба зохицуулах зэрэг үйлчилгээнүүд тус төвүүдэд амжилттай явагдаж, нутагшиж байна.

Сард хамгийн олон үйлчлүүлэгч хүлээн авдаг ГССҮТ болон Чингэлтэй дүүргийн НЦҮТ үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, уян хатан байдал, тохиромжтой байдал, аюулгүй байдал зэргүүдийг тааруу гэж үнэлсэн төдийгүй, Чингэлтэй дүүргийн НЦҮТ нь үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой байдал хангагдаагүй гэж үнэлжээ. Дээрх үйлчилгээний нөхцөл байдлаа хангалттай сайн гэж үнэлсэн нь хөдөө орон нутгаас Дорнод, Завхан аймгууд, УБ хотоос Сүхбаатар дүүргийн НЦҮТ байна.

ТХБ-ны хувьд Баянзүрх дүүрэг, Сэлэнгэ аймгийн ТХБ-ны хүрэлцээ хүртээмжийг, Сэлэнгэ аймаг тохиромжтой байдал, аюулгүй байдлаа тус бүр дунд зэрэгт байгааг ажиллагсад үнэлсэн бол, Баянзүрх дүүргийн үйлчилгээний тохиромжтой байдал дундаас доогуур гэж үзсэн. ТХБ дахь дээрх үйлчилгээний төрлүүдийг сайнаас дээш гэж үнэлсэн Архангай, Орхон аймгууд, УБ хотоос Баянгол дүүргийн ажиллагсад байна.

НЦҮТ-ийн орны хүрэлцээ маш бага буюу 2-6 хүн түр хугацаанд хүлээн авах бөгөөд нэгэн зэрэг олон хүн хүлээн авах боломж хомс, тухайн үйлчлүүлэгчийг нас, хүйс, кейсийн онцлогоос нь хамаарч тусдаа байрлуулах боломж байдаггүй гэсэн нийтлэг шалтгаанууд тохиолдож байна.

Харин ТХБ-ны хувьд 8-21 хүн хүлээн авах боломжтой буюу үйлчлүүлэгчийн кейс, нас, хүйсийг харгалзан өөр өөр өрөөнд тусдаа байрлуулан урт хугацаанд үйлчилгээ үзүүлж байна.

Үйлчилгээ үзүүлэх явцад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, хүүхдүүд ирж үйлчлүүлдэг нь хамгийн хэцүү тохиолдол байдаг. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглаж болохуйц зориулалтын ариун цэврийн өрөө, суух сандал байдаггүйгээс нийгмийн ажилтан өөрөө асран халамжлах үйлчилгээ үзүүлж маш их ачаалал авдаг байна.



Шигтгээ

Саяхан манай төвд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2 ихэр хүүхэдтэй эмэгтэй ирсэн. Нэг хүүхэд нь саажилттай учраас эмчилгээ хийлгэхийн тулд эрүүл мэндийн үйлчилгээгээ дотроосоо авч 7 хоног байрласан. Байрлуулах өрөө маань 2 ортой жижигхэн зайтай. Саажилттай хүүхэд суулгах сандал ч байхгүй. Би ганцаараа ажилладаг учраас зав муутай, тэр болгонд нь туслах боломж байгаагүй. Тухайн үед үйлчлүүлэгч маань их л ядарсан тэгээд л гарсан.

СБД-ийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Зөвлөгөө өгөх өрөө нь стандарт хангагдаагүй. Тоног төхөөрөмж нь дутмаг байгаа нь үзүүлж буй үйлчилгээний тохиромжтой байдал хангагдаагүй байдаг.

Сүхбаатар дүүргийн НЦҮТ ажилтан

Хамгаалах байр 100 хувь хамгаалалт сайтай биш байна. Орон тоо санхүү үнэхээр хүнд байгаа нь НЦҮТ-ийн стандарт хангагдсан гэж хэлэхэд үнэхээр бэрхшээлтэй байгаа.

Хан-Уул үүргийн НЦҮТ ажилтан

Цаашдаа дээрх 9 төрлийн үйлчилгээнээс үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний тохиромжтой байдал дээр илүү шинэчлэлийг хийх шаардлагатай нь харагдаж байна.

ТХБ, НЦҮТ-д ажиллаж буй нийгмийн ажилтны хүлээх үүрэг нь ойролцоо байгаа ч, зарим нэг үүргүүдийг тухайн байгууллагад нийгмийн ажилтнууд түлхүү гүйцэтгэж байгаа нь анзаарагдсан юм.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан нь:

- Шаардлагатай тохиолдолд хохирогчийг хамгаалах байр руу шилжүүлэх арга хэмжээ авах,
- Хохирогчийг хүлээн авч 24-72 цагийн хооронд үйлчилгээ үзүүлнэ.
- Хүчирхийллийн тохиолдлыг илрүүлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах үүрэг давамгайл байна.

ТХБ-ны нийгмийн ажилтан нь:

- Эмнэлгийн байгууллагад холбон зуучлах
- Эрүүл мэндийн үйлчилгээний бүхий л үе шатанд үйлчилгээг хариуцан ажиллах
- 1-3 сар хүртэлх хугацаанд хохирогчийг байрлуулах, үйлчилгээ үзүүлэх үүргүүдийг ихэвчлэн гүйцэтгэдэг байна.

НЦҮТ, ТХБ-д ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнд учирч буй хүндрэлүүд

Санхүүжилттэй холбоотой хүндрэлүүд: Хүндрэлтэй асуудлын эн тэргүүнийх нь цалингийн асуудал байна. НЦҮТ, ХБ-ны ажиллагсдын цалин шатлалын хувьд доогуур бага цалинтай байна. Гар дээрээ 500.000₮ авч, ажлын орчин нөхцөл хангалгүй газар ажиллаж байна. Зарим газруудад цалин дээр нэмээд унааны мөнгө өгдөг байна. Өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад санхүүжилттэй холбоотой дараагийн хүндрэл нь тухайн үйлчлүүлэгчийг даган ирж байрлаж буй хүмүүсийн асуудал байдаг. Ийм тохиолдолд тухайн байгууллагын ажилтнууд л өөрсдөө зохицуулалт хийж байна. Цаашдаа энэ тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх шийдлийг тодорхой болгох хэрэгтэйг НЦҮТ-ийн судалгаанд оролцогчид өгүүлж байлаа.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний дэргэдэх түр хамгаалах байрны үйлчилгээний хүртээмжийг авч үзвэл үйлчилгээ явуулж эхэлсэн цагаасаа хойш өнөөг хүртэл нийт 3433 хүүхдэд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлсэн бөгөөд 2020 онд 841 хүүхдэд 5084 ор хоног үйлчилгээ 2021 онд 341 хүүхдэд 8104 ор хоногийн үйлчилгээ хүргэсэн байна. Үүнээс улбаалан ор хоногийн урсгал зардлыг бодож үзвэл 2020 онд ор хоногийн зардалд 70,159,200 төгрөг, 2021 онд ор хоногийн зардалд 111,835,200 төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хүснэгт 4.8. 2020, 2021 онуудын ор хоногийн урсгал зардал

Огноо	Хүүхдийн тоо	Ор хоногийн тоо	Нэг хүнд ногдох урсгал зардал ор хоногоор
2020	841 хүүхдэд	5084 ор хоногийн	70,159,200₮ зарцуулсан
2021	341 хүүхдэд	8104 ор хоногийн	111,835,200₮ зарцуулсан

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний дэргэдэх түр хамгаалах байрны санхүүгийн бүтэц зарцуулалтыг товч авч үзэхэд тухайн байгууллага нь төрөөс санхүүждэг. Улсдаа томд тооцогдох тухайн түр хамгаалах байранд жилд ердөө 220 сая төгрөгийн төсөв батлагддаг бөгөөд жилийн санхүүжилтийн 160 сая төгрөгийг ажилчдын цалинд үлдсэн 60 сая төгрөгийг газрын татвар, тог цахилгаан, дулаан, халуун хүйтэн ус, мөн хоолны материалд, ахуйн хэрэгцээний зардалд зарцуулдаг байна. ТХБ-ны хувьд хувьсах зардлаар санхүүжиж байгаа бөгөөд журамд заасан норматив зардал ямагт хасагдаж, танагдах байдалтай, байнгын төсвийн хомсдолтой байдаг ажээ. Жишээ болгон ТХБ-ны нэг жилийн хувьсах зардлын тооцоо болон бодит зардлыг дараах Хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.9. Нэг хүнд ноогдох хувьсах зардал, төгрөгөөр

Зардлын утга	Норматив зардал журамд зааснаар	Түр хамгаалах байр 1 хоног-1 хүүхдэд	Зөрүү
Хоол хүнс	26,800	3500	23,300
Хувцас, ариун цэврийн хэрэгсэл	6,400	5,800	600
Төлбөртэй тусламж үйлчилгээ	27,480	4,500	22,980
Нийт	60,680	13,800	46,880

Нөхцөл байдал зөвхөн танагдах, хасагдаа биш тухайн үйлчилгээний зардлыг төсвөөс үл хайхарч, байнгын хомсдолтой нөхцөлд, төсөвт багтаан үйлчилгээг үзүүлэх шийдвэр гаргаж буй нь гол бэрхшээл болж байна. Иймээс ч ихэнх ТХБ-ны хувьд батлагдсан төсөвт “хөнжлийн хэрээр хөлөө жийж” үйлчилгээг хүргэж хоол хүнс, ариун цэвэр гэх мэт үйлчилгээнээс илүү гарч чадахгүй байна.

Хүний нөөцийн дутмаг байдалтай холбоотой хүндрэл: Ажиллагсдын цалин бага байгаагаас мэргэжлийн хүмүүс ирдэггүй, түүнээс болоод бүтэц орон тоогоо гүйцээн ажиллахгүй байгаа нь ажлын ачааллыг бүр нэмэгдүүлдэг байна. Тухайлбал: БЗД, ЧД, СБД, Гэмтлийн эмнэлгийн НЦҮТ нь бүтцийн хувьд орон тоо бага байгаа учраас мэргэжилтнүүдэд ажил үүргийн давхцал их гардаг. НЦҮТ-ийн албан хаагчид тэр дундаа нийгмийн ажилтнуудад ажлын ачаалал өндөр байна. Мөн үүнтэй адил орон тоо дутмаг, нэг хүнд ноогдох ачаалал их байдаг тухай аймаг, орон нутгийн ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүд өгүүлж байна.



Шигтгээ

ГБХЗХГ-ын зүгээс зөвхөн хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн зардлыг бидэнд өгдөг гэтэл нэг хүүхэд ирж байрлах үед ээж нь заавал дагаж ирэх хэрэгцээ гардаг гэтэл энэ ээж аав дагаж ирж байрлаж байгаа хүмүүсийн зардал мөнгө орж ирдэггүй нь бидэнд хүндрэлтэй байдаг.

Завхан аймгийн НЦҮТ-ийн мэргэжилтэн

Дээрх нөхцөл байдлыг тодорхой нэг байгууллагаар жишээлэн нөхцөл байдал ямар байгааг авч үзье. Тухайлбал, ГБХЗХГ-ын харьяанд үйл ажиллагаа явуулдаг Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрыг жишээ болгон энд авч үзлээ. Тус ТХБ үүсгэн байгуулагдаад 2017 оны 9 сарын 22-ны өдрөөс хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч нарт үйлчилгээ хүргэж эхэлсэн бөгөөд мөн тус өдөр баталсан байгууллагынхаа дүрмийн дагуу түр байрлуулан хамгаалах үйлчилгээг 72-168 цаг буюу 3-7 хоногоор богино хугацааны үйлчилгээ үзүүлж байна. Уг түр хамгаалах байр нь зөвхөн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг хүлээн авч үйлчилгээ үзүүлдгээрээ онцлог юм.

Тухайн түр хамгаалах байрны хүний нөөц, ажилтны орон тоог авч үзвэл 2017 онд баталсан байгууллагын дүрэмд 11 хүний бүтэц орон тоог баталжээ. Гэвч одоогийн байдлаар 7 гэрээт ажилтны орон тоог шинээр бий болгож нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Гэрээт ажилтны орон тоог бий болгосон шалтгааны дурдвал тус түр хамгаалах байрны нийгмийн ажилтнууд нэг нэгээрээ 4 ээлжээр үйлчилгээ үзүүлдэг тэгвэл үйлчилгээ үзүүлж байх хугацаанд шинээр үйлчлүүлэгч ирэх тохиолдолд үйлчлүүлэгчийг хүлээн авч байх үед түр хамгаалах байранд байгаа хүүхдүүдийг харах мэргэжилтэнгүй болдог. Мөн ямар нэгэн уулзалт хурал чуулган, дуудлага зэрэгт явахад уг асуудал мөн ялгаагүй тохиолддог. Тийм учраас 4 ээлжийн нэмэлтээр нэг нэг мэргэжилтний хэрэгцээ бий болдог ажээ. Мэдээж хүний нөөц, орон тооны асуудал нь тухайн ТХБ-аар үйлчлүүлэгчдийн тоо болон ачаалалтай холбоотой.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний дэргэдэх түр хамгаалах байр нь 2020 онд нийт 841 хүүхдэд түр хамгаалан байршуулах үйлчилгээ үзүүлснээс 49.46% буюу 416 эрэгтэй хүүхэд, үлдсэн 50.53% буюу 425 эмэгтэй хүүхэд үйлчилгээ авсан байна. Харин 2021 онд нийт 341 хүүхэд үйлчилгээ авснаас 43% хувь буюу 159 эрэгтэй хүүхэд үлдсэн 57% буюу 182 эмэгтэй хүүхэд түр хамгаалан байршуулах үйлчилгээ үзүүлжээ. Ялангуяа ХХХҮ-ний дэргэдэх ТХБ-ны хувьд ихээхэн ачаалалт ажилладаг ба ор хүрэлцдэггүй, ачаалал ихтэй үед нэг орон дээр 2 хүүхэд байлгаж, үйлчилгээ үзүүлдэг талаар дурдаж байна.

Хүснэгт 4.10. 2020, 2021 онд үйлчилгээ авсан хүний тоо (харьяаллаар)

Харьяа дүүрэг	2020 оны жилийн эцэс		2021 оны 10 сар	
	Хүүхдийн тоо	Хувь	Хүүхдийн тоо	Хувь
Сонгинохайрхан дүүрэг	249	29.6%	90	26.0%
Баянзүрх дүүрэг	250	29.7%	115	33.0%
Баянгол дүүрэг	82	9.7%	9	3.0%
Чингэлтэй дүүрэг	162	19.2%	70	20.0%
Сүхбаатар дүүрэг	63	7.4%	19	6.0%
Хан-Уул дүүрэг	5	0.5%	3	0.8%
Багануур дүүрэг	1	0.1%	0	0.0%
Багахангай дүүрэг	0	0.0%	1	0.2%
Налайх дүүрэг	20	2.3%	19	6.0%
Орон нутаг	9	1.1%	15	5.0%
Дүн	841	100.0	341	100.0%

Түр хамгаалах байр нь байнгын дүүргэлттэй байдаг тэдгээр хүүхдүүдэд өдөрт дөрвөн удаагийн хоолоор хангахад тогоочийн ачаалал нэг хүнд ахдаж байсан учраас нэг ээлжийн тогоочийн орон тоог нэмж бий болгосон. Үүнээс гадна уг байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаатай байгууллага учраас нярав, санхүүчийн хэрэгцээ зайлшгүй гарч байгаа учраас дээрх орон тоонуудад гэрээт хэлбэрээр ажилтан авч ажиллуулж байгааг ХХХҮ-ний дэргэдэх ТХБ-ы мэргэжилтнүүд дурдаж байсан юм.

Хүний нөөцийн дутмаг байдал нь хэт их ачаалал, тухайлсан үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэхэд хүндрэлтэй төдийгүй, үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийг үнэлэхэд ч сөргөөр нөлөөлж байна хэмээн НЦҮТ, ТХБ-нд ажиллагсад үзэж байна.

ЖСХ-ийн хохирогчтой ажиллах арга зүй, мэдлэг ур чадвар дутмагтай холбоотой хүндрэл: Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах, сэтгэл заслын сургалт гээд янз бүрийн сургалтуудад хамрагддаг. Харин яг бэлгийн хүчирхийллийн хохирогчтой яаж ажиллах вэ гэсэн сургалт байдаггүй гэж судалгаанд оролцсон байгууллагуудын мэргэжилтнүүд тэмдэглэж байлаа.

Хамгийн их дутагдаж буй ур чадварууд

НЦҮТ	ТХБ
Кейсийн маягтууд, экозураглал, генограмм дээр ажиллахад бэрхшээл тулгардаг. Маягт дээр ажиллах боломж олддоггүй. Мөн маягт дээр ажиллах зарим зүйлийг нь мартсан байдаг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд ирлээ гэж бодоход би яаг яаж харилцах ёстой вэ? Тухайн хүүхэд нь өсвөр насны хүүхэд байвал яаж харилцах ёстой вэ? Огт юм ярихгүй байвал ямар асуулт асуух ёстой вэ? гэх зэрэг харилцааны ур чадварт суралцаж сургалт авах хэрэгтэй байна.	Бэлгийн хүчирхийллийн талаар нийт албан хаагчдад мэргэшсэн хүн байдаггүй тул мэргэшүүлэх зайлшгүй шаардлагатай. Үнэхээр очих газаргүй хараа хяналтгүй хүнийг яаж ч болдоггүй хэцүү байдаг. Түүнээс болоод дээд газраас түр байрлуулах болохоос бүр байрлуулах биш шүү гэж шахалт үзүүлдэгтэй холбоотойгоор ТХБ-ны ажилтнууд ийм тохиолдлыг хэрхэх тухайд суралцах

Сургалтын хувьд БЗХӨ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх сургалтуудад сууж байсан, Сэтгэц наркологийн төвтэй хамтарч ажилладаг, Хөөрхөн Зүрх ТББ-ын сургалтуудад хамрагдаж байсан зарим нэг байгууллага байгаа ч, нийтлэг байдлаар бэлгийн хүчирхийллийн талаарх ойлголт

хандлагад суралцах, хэрхэн ажиллах талаар мэдлэг мэдээлэл чамлалттай байна. Байрлах хугацаатай холбоотой хэд хэдэн хүндрэл гарч байгааг НЦҮТ, ТХБ гэдгээр нь ялган харахад орон нутгийн НЦҮТ-ийн тогтолцоо хангалтгүй байгаа, эрх зүйн орчин бүрдээгүй, стандарттай холбоотой асуудлууд, мөн ТХБ-ны хувьд хугацаа сунгадагтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээтэй байна.



Шигтгээ

Орон нутагт тогтолцоо хангалтгүй гэж бодож байна.

БЗД-ийн НЦҮТ нийгмийн ажилтан

Манайд эрх зүйн орчин бүрдээгүй. Хүний нөөцийн стандарт ч гэж байхгүй. Жишээ нь, манайх хуулийн зөвлөгөө өгдөг эрх зүйчтэй байх ёстой. Үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж үйлчилгээ авчихлаа, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авчихлаа, тухайн хүн салмаар байгаа шүү дээ. Мөн байрны стандарт хангалтгүй. 3 өрөөтэй.

Сүхбаатар дүүргийн НЦҮТ

Орчны стандартын асуудал нь НЦҮТ-дийн хамгийн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудал юм. Ялангуяа ЖСХ-ийн хохирогч хүүхдүүдийг байрлуулах түүнд үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх асуудалд шийдэл хэрэгтэй байна.

ХУД-ийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Журамд тусгагдсанаар 168 цаг буюу 7 хоног үйлчилгээ үзүүлдэг. Гэвч яг амьдрал дээр та 7 хоног боллоо гар гэж шууд хэлж болдоггүй үйлчилгээг дуусах хүртэл байршуулдаг. Долоогоос дээш хоног байрласан хүүхдүүдийн хэтэрсэн хоногийн төсвийг ирсэн дүүрэгт нь мэдэгддэг.

БЗД-ийн ТХБ нийгмийн ажилтан

НЦҮТ, ТХБ-д ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнд учирч буй хүндрэлүүдийг санхүүжилт, хүний нөөц, тодорхой үр чадварт суралцуулах замаар шийдвэрлэх шаардлагатай байгааг дараах зурагт ямар үр чадвар, зөвлөгөө гэдгийг нарийвчлан харуулсан юм. Түүнчлэн НЦҮТ, ТХБ-д ажиллагсад сургалт, ялангуяа ЖСХ-ийн хохирогчтой хэрхэн ажиллах талаарх гарын авлага дутагдаж байгааг өгүүлсэн юм.

Зураг 4.6. ЖСХ-ийн хохирогчтой ажиллах нийгмийн ажилтнуудад тулгамдаж буй асуудал

Харилцааны үр чадвар	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үр чадвар	Ажилтныг санхүүгээр дэмжих	Хүний нөөц
- Насны онцлогт тохируулан харилцах - Кейсийн онцлогт тохируулах, харилцах - Харилцааны асуудалтай үйлчлүүлэгчтэй харилцах	- Анхан шатны зөвлөгөө - Үйлчлүүлэгчийн хямралыг бууруулах	- Цалин урамшуулал, санхүүгээр дэмжих - Нийгмийн ажилтныг чадавхжуулах сургалт - Нийгмийн ажилтанд зориулсан гарын авлага	- Мэргэжлийн нийгмийн ажилтны нөөц - Мэргэжлийн сэтгэл зүйчийн нөөц - Хөгжлийн үйлчилгээ үзүүлэх хамтрагч байгууллагыг нэмэгдүүлэх

ТХБ, НЦҮТ-ийн ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг илүү үр дүнтэй болгохын тулд та юу хийх байсан бэ? гэсэн асуултад сайжруулж болох арга замын талаар дараах саналуудыг дэвшүүлсэн юм. Үүнд:

- Байрлах байрны орон зайг нэмэх, эсвэл дүүрэг дүүрэг дээр үйлчилгээ авч байгаа хүмүүсээр төрөлжүүлж, хамгаалах байр нэг цэгийн үйлчилгээний байрыг байгуулбал илүү үр дүнтэй. Орон тоогоор хангалттай хангах, цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх
- Кейс гарсан, ялангуяа хүчирхийлэлд өртсөн кейсийн онцлогт хэрхэн тохируулж үйлчилгээг хүргэх вэ, хэрхэн харилцах вэ гэдэг талаар сургалт, зөвлөгөө явуулах
- Хүний нөөцийг нэмэгдүүлэх, өрөө тасалгааг томруулах хэрэгтэй байна.
- Хамгаалах байраа тохижуулахын тулд заримдаа өөрөөсөө мөнгө гаргаж тохижуулдаг
- НЦҮТ, ТХБ-д мэргэжлийн хүний нөөц хэрэгтэй байна. Хохирогчид хүнд хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн, эрсдэлтэй нөхцөлд байх юм бол мэргэжлийн багийг 24 цагаар ажиллуулах шаардлагатай.
- Хүчирхийллийн хэлбэрээр нь задлаад ТХБ-аа зохион байгуулбал өгөөжтэй зэрэг саналуудыг дэвшүүлжээ.

Үйлчилгээний хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлагнал

ТХБ-ны нийгмийн ажилтнууд сараар, улирлаар, жилээр тайлан гаргаж дүүргийнхээ хэлтэст хянуулдаг. Хэдэн үйлчлүүлэгч ирж үйлчилгээ авсан, ямар хүн ирсэн, ямар арга хэмжээ авсан бэ гэдгээ тайлангаар дамжуулж хянуулдаг. Гэхдээ тайлан хураалгах үед мэргэжилтнүүд цагийг нь тулган хэлдэг, тайлан хураалгах тогтсон цаг байдаггүй, тайлангийн нэгдсэн загвар байдаггүй гээд асуудлуудыг тоочсон байна.

Харин НЦҮТ нь тайлангаа эмнэлгийнхээ эрүүл мэндийн албанд хянуулдаг. Судалгаанд хамрагдсан нэг НЦҮТ нь дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийг түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг учраас ТХБ-ны тайлагнах үнэлүүлэх байдалтай адилхан байна. Эмнэлэгт түшиглэсэн хоёр НЦҮТ нь үзүүлсэн үйлчилгээгээ тайлагнах гэхээс илүү үйлчлүүлэгчийн хүчирхийлэлд өртсөн мэдээлэл, хэдэн хүн үйлчлүүлсэн зэргийг 2-3 мэдээллийн санд шивж оруулдаг. Харин үйлчилгээг хэрхэн үзүүлсэн тал дээр албаны ахлах хяналт тавьдаг. Бидний үзүүлж буй бүхий л үйлчилгээнд хяналт тавьж үнэлж дүгнэсэн зүйл байдаггүй хэмээн ярилцлагын үед дурдаж байсан.

ТОВЧ ДҮГНЭЛТ

Тус ярилцлагад нийт 5 ТХБ, 7 НЦҮТ-ийн мэргэжилтэн, нийгмийн ажилтнууд хамрагдсан юм. Тус хүснэгтээс үзэхэд мэргэжлийн нийгмийн ажилтны зэрэгцээ мэргэжлийн хуульч, сэтгэл зүйч зэрэг хүмүүс ажил үүргийн онцлогийн дагуу ажиллаж байна. 5 ТХБ, 7 НЦҮТ-ээс судалгаа авч дүгнэхэд ажилласан жилийн хувьд ТХБ-д дээд тал нь 2 сараас 2 жил хүртэл ажилласан ажилтнууд байсан бол НЦҮТ-д ажиллаж байгаа ажилтнуудаас 9-10 жил ажилласан.

Нэгж хугацаанд үзүүлэх хүний багтаамжийн хувьд Орхон, Сэлэнгэ аймгуудад зөвхөн 2-3 хан ажилтантай ч, сард 90 орчим хүүхдэд НЦҮТ үйлчилгээ үзүүлсэн гэснээс мэргэжилтнүүд нь хаанаа ч хүрдэггүй байдал ажиглагдаж байна. Энэ байдал нийслэл хотод тэр дундаа томоохон дүүргийн хүн амд үйлчилгээ үзүүлдэг ХХХҮ-ний ТХБ-нд ч ажиглагдаж байна.

ТХБ, НЦҮТ зэрэг төрөөс хуулиар тогтоосон эрх үүргийн хүрээнд ажиллаж буй эдгээр байгууллагуудын байрны нөхцөл байдлын нэгдсэн стандартыг мөрдүүлэх, шаардлагатай газруудад яаралтай засвар үйлчилгээ цаашлаад шинээр барих арга хэмжээг авах шаардлагатай байна. Тухайлбал: Сард хамгийн олон үйлчлүүлэгч хүлээн авдаг ГССҮТ болон Чингэлтэй дүүргийн НЦҮТ үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, уян хатан байдал, тохиромжтой байдал, аюулгүй байдал зэргүүдийг тааруу гэж үнэлсэн төдийгүй, Чингэлтэй дүүргийн НЦҮТ нь үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой байдал хангагдаагүй гэж үнэлжээ.

Хуульд зааснаар НЦҮТ 7 төрлийн үйлчилгээг, ТХБ 6 төрлийн үйлчилгээг үзүүлэхийг заасан. НЦҮТ богино хугацаанд буюу 72 цаг хүртэлх хугацаанд үйлчлэх бол ТХБ нь нэгээс гурван сар хохирогчийн байрлуулж, аюулгүй байдлыг хангах, нийгэм сэтгэл зүйн, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлдэг. Хэрэгжилт нь харьцангуй ялгаатай байна. Баянгол дүүрэг нь сэтгэл зүйч байхгүй учир зарим кейс тохиолдол дээр гэрээгээр сэтгэл зүйч авч зөвлөгөө өгдөг бол, зарим газарт бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч ирэхэд эрүүл мэндийн байгууллагатай л нийлэхийг чухалчилдаг зэргийг дурдсан. Үзүүлж буй үйлчилгээнээс үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний тохиромжтой байдал дээр илүү шинэчлэлийг хийх, мэргэжилтнүүдийг авч ажиллуулах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах, сэтгэл заслын сургалт гээд янз бүрийн сургалтуудад ажилтнууд нь хамрагддаг. Харин яг бэлгийн хүчирхийллийн хохирогчтой яаж ажиллах вэ? гэсэн сургалт байдаггүйг анхаарч цаашид энэ чиглэлийн сургалт явуулах хэрэгцээ шаардлага байна.

Судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнуудын хувьд ТХБ, НЦҮТ-д тусгагдаж буй төсвийн хэмжээг харьцангуй бага байгаа гэж үзэж байгаа юм. Үйлчилгээ авч буй хүүхдүүд, хохирогчид нь энгийн биш, хэд дахин их үйлчилгээ хэрэгцээ шаардлагуудтай тулгардаг. Харьяа газраас төсөвлөгдөж байгаа төсөв одоогийн эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай учир төсвийн үр дүнтэй зарцуулах боломжгүйг анхаарах хэрэгтэй байна.

НЦҮТ, ТХБ-ны тайлан хураалгах үед мэргэжилтнүүд цагийг нь тулган хэлдэг, тайлан хураалгах тогтсон цаг байдаггүй, тайлангийн нэгдсэн загвар байдаггүйг анхаарч цаашид нэгдсэн загвар, хугацаатай болгох шаардлагатай байна.

4.3 ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтэн, албан хаагчдын чадавхын үнэлгээ

Судалгаанд оролцогчдыг нутаг дэвсгэрийн байдлаар аваад үзвэл аймаг, нийслэлийн хүрээнд Архангай, Дорнод, Завхан, Орхон, Сэлэнгэ, Улаанбаатар зэрэг аймаг нийслэлийн түр хамгаалах байрны ажилтан албан хаагчид хамрагдсан. Уг асуулгад хамрагдсан ажилтан албан хаагчдын давтамжийн тоог аймаг, нийслэлийн хэмжээнд авч үзвэл Хүснэгт 4.13-т авч үзлээ. Нийслэл Улаанбаатар хотоос нийт 29 албан хаагч оролцсон бөгөөд энэ нийт судалгаанд хамрагдагсдын 72.5 хувийг эзэлж байна. Үүнээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 72.5 хувь буюу 29 хүн нийслэлээс оролцсон бол хөдөө орон нутгаас 27.5 хувь буюу 11 хүн хөдөө орон нутгаас оролцжээ. Уг асуумжийн үр дүнг хүснэгт 4.8-д харуулав.

Хүснэгт 4.11. Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын харьяалал(аймаг, нийслэл)

	Давтамж	Хувь	Хүчинтэй хувь	Хуримтлагдсан хувь
Архангай аймаг	3	7.5	7.5	7.5
Дорнод аймаг	1	2.5	2.5	10.0
Завхан аймаг	3	7.5	7.5	17.5
Орхон аймаг	1	2.5	2.5	20.0
Сэлэнгэ аймаг	3	7.5	7.5	27.5
Улаанбаатар хот	29	72.5	72.5	100.0
Нийт	40	100.0	100.0	


Сургалтад хамрагдсан ТХБ, НЦҮТ-ийн албан хаагчдыг оршин суугаа газар болон нийгэм хүн ам зүйн үзүүлэлт болох нас, хүйсийн байдал, боловсрол болон ажилласан жилээр нь харьцуулж авч үзье. Судалгаанд хамрагдсан ТХБ, НЦҮТ-ийн нийт ажилтан албан хаагчдын насны байдлыг судалж үзэхэд 21-61 насны 40 хүн хамрагдсан байна. Асуумж судалгаанд оролцсон мэргэжилтэн, нийгмийн ажилтнуудыг насны хувьд авч үзэхэд хамгийн бага нь 21, хамгийн их нь 61 настай байв. Дундаж насыг тооцож үзэхэд 35 байна. Насны үзүүлэлтийг бүлэглэж үзэхэд 25 хүртэлх насны 13 хүн, 26-35 насны 9, 36-45 хүртэлх насны 11 хүн, 46 ба түүнээс дээш насны 7 хүн тус тус хамрагджээ.

Хүснэгт 4.12. Албан хаагчдын нас, хүйсийн байдал

	Нас, хүйсийн байдал	Давтамж	Хувь
Насны бүлэг	25 хүртэлх настай	13	32.5
	26-35 хүртэлх настай	9	22.5
	36-45 хүртэлх настай	11	27.5
	46 ба түүнээс дээш	7	17.5
Хүйсийн байдал	Эрэгтэй	3	7.5
	Эмэгтэй	37	92.5
	Нийт	40	100.0

Дээрх харьцаанаас харахад шинэ залуу боловсон хүчин ТХБ, НЦҮТ-ийн ажлын байран дээр давамгайл ажиллаж байгаа нь харагдаж байна. Судалгаанд оролцсон ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн хүйсийн харьцааг авч үзэхэд нийт 40 хүнээс 7.5 хувь буюу ердөө гуравхан оролцогч эрэгтэй, бусад нь эмэгтэй хүмүүс байлаа. Судалгаанд оролцсон ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн албан тушаалын байдлыг харахад дараах онцлог харагдаж байна.

График 4.1. Судалгаанд оролцогчдын албан тушаал (хувиар)



Судалгаанд оролцогчдын албан тушаалыг авч үзэхэд нийгмийн ажилтнууд, мэргэжилтэн, зохион байгуулагч, эмч, сэтгэл зүйч гэх мэт төрөл бүрийн мэргэжилтэй хүмүүс байв. Түр

хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгаа, цалин хөлс болон ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах бодит нөхцөл тааруу байгаа нь судалгаанаас харагдсан болно. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинг авч үзэхэд нийт ажилтан мэргэжилтнүүдийн 95 хувь буюу 38 хүн дээд боловсролтой үлдсэн хоёр хүн нь (5 хувь) тусгай дунд болон бүрэн дунд боловсролтой байлаа. Тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын боловсролын түвшин сайн хэдий ч мэргэжлийн бус хүмүүс нийгмийн ажилтан хийж байгаа, тусгай дунд боловсролтой хүн НЦҮТ-ийн зохион байгуулагч хийж байгаа учир дутагдалтай талууд судалгааны явцад ажиглагдаж байлаа.

Хүснэгт 4.13. Албан хаагчдын боловсролын байдал

Боловсрол	Давтамж	Хувь	Хүчинтэй хувь	Хуримтлагдсан хувь
Дээд	38	95.0	95.0	95.0
Тусгай дунд	1	2.5	2.5	97.5
Бүрэн дунд	1	2.5	2.5	100.0
Нийт	40	100.0	100.0	

Судалгаанд хамрагдсан ТХБ, НЦҮТ-ийн ажилтан, албан хаагчдын үндсэн мэргэжлийг судалж үзэхэд дараах онцлог харагдсан юм. Үүнд багш мэргэжилтэй 3 хүн, нийгмийн ажилтан мэргэжилтэй 15 хүн, эрх зүйч мэргэжилтэй 5 хүн, сэтгэл зүйч мэргэжилтэй 3 хүн, бизнес судлаач эдийн засагч, гэр бүл судлаач, их эмч, нягтлан бодогч, эрх зүйч, олон улсын эрх зүйч, санхүүгийн удирдлага, сувилахуйн арга зүй, сэтгүүлч, тусгай мэргэжлийн, хүний нөөц, цагдаа, эрх зүйч, нийгмийн ажилтан, эх барих-бага эмч мэргэжилтэй тус бүр 1 хүн судалгаанд хамрагджээ. Үүнээс үзэхэд ТХБ, НЦҮТ-д олон мэргэжлийн хүмүүс нэг дор нэгдэн ажилладаг болох нь харагдаж байна.

ТХБ, НЦҮТ-ийн ажилтан албан хаагчдын тус ажлын байранд орох болсон шалтгааныг мөн судалж үзсэн бөгөөд асуумжийн үр дүнгээс үзэхэд нийт судалгаанд оролцогчдын 37.5 хувь буюу 15 хүн нийгмийн ажилтан мэргэжилтэй гэж хариулсан бол хүчирхийллийн даван туулагч гэж нэг хүн хариулсан байна. Харин бусдад туслах чин хүсэлтэй учраас гэж хариулсан 14 хүн буюу 35% байна. Үлдсэн 9 хүн нь бусад шалтгааны улмаас гэж хариулсан ба ажил мэргэжлийн шалгуур, ажлын чиг үүргийн дагуу, өөрийн үндсэн мэргэжилтэй төстэй, хүүхэдтэй ажиллах сонирхолтой, эмч мэргэжилтэй зэрэг хариултыг өгсөн байна. Тухайн асуултад хариулахаас татгалзсан нэг хүн байсан юм. Хариултын үр дүнг хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4.14. Судалгаанд оролцогчдын ажлын байранд ажиллах болсон шалтгаан

Ажиллах болсон шалтгаан	Давтамж	Хувь	Хүчинтэй хувь	Хуримтлагдсан хувь
Нийгмийн ажлын мэргэжилтэй	15	37.5	38.5	38.5
Хүчирхийллийн даван туулагч учраас	1	2.5	2.6	41.0
Бусдад туслах чин хүсэлтэй учраас	14	35.0	35.9	76.9
Бусад	9	22.5	23.1	100.0
Нийт хариулсан	39	97.5	100.0	
Хариулахаас татгалзсан	1	2.5		
Нийт	40	100.0		

Судалгаанд оролцсон ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн сарын дундаж, цалин орлогыг авч үзэхэд хамгийн бага нь 500.0 мянга, хамгийн өндөр нь 1.3 сая байгаа бөгөөд дунджаар 687.0 мянган төгрөгийн цалин авдаг байна.


Хүснэгт 4.15. Сарын дундаж цалин орлого

	N	Доод утга	Дээд утга	Дундаж	Стандарт хазайлт
Сарын дундаж цалин, орлого	39	500,000	1,300,000	687,025	173,891
Өрхийн нэг хүнд ноогдох орлого	39	89,285	433,333	193,995	82,812

Мөн цалин орлогын хэмжээг өрхийн ам бүлийн тоонд хувааж, нэг хүнд ноогдох орлогын дундаж үзүүлэлтийг тооцож үзэхэд дунджаар 193.9 мянга байгаа нь тухайн цалин орлого харьцангуй бага болохыг нотолж байна.


Орлогын байдлыг бүлэглэж үзэхэд албан хаагчдын 76.1 хувь буюу 30 албан хаагч 500.0-750.0 мянга хүртэлх төгрөгийн цалинтай байна.

График 4.2. НЦҮТ-ийн ажилтнуудын орлогын бүлэг (тоогоор)



Орлогын энэхүү хязгаарлагдмал байдал нь өрхийн сарын хэрэглээнд тодорхой утгаараа нөлөөлж байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн 65.0 хувь нь өдөр тутмын хэрэгцээгээ хангаж байгаа бол 22.5 хувь нь өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй гэсэн хариулт өгсөн байв.

График 4.3. Сарын орлого ба өдөр тутмын хэрэгцээгээ хангах байдал



Судалгаанд оролцсон 40 хүнээс хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах шаардлага нь ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй хэр зэрэг нийцэж байна вэ гэсэн асуултад нийт оролцогчдын 2.5 хувь буюу 1 хүн муу гэсэн үнэлгээг өгсөн бол 10 хүн буюу судалгаанд оролцогчдын 25% нь дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн байна. Харин сайн гэсэн үнэлгээг 16 хүн буюу судалгаанд оролцогчдын 40% өгсөн байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 30 хувь буюу 12 хүн маш сайн гэсэн үнэлгээг өгчээ.

Тухайн асуумжийн хүрээнд дараах үндсэн асуултуудыг харьцуулж дүн шинжилгээ хийсэн юм.

ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудад тавигдах нийтлэг шалгуур, чиг үүрэгтэй холбоотой (1-маш муу, 5-маш сайн гэсэн дарааллаар тэмдэглэнэ. Оролцогч асуулт бүрд өөрийн үнэлгээг харгалзуулан үнэлсэн)

Хүснэгт 4.16. ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудад тавигдах нийтлэг шалгуур, чиг үүрэг

Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ				
	1	2	3	4	5
Б1. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага нь ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй хэр зэрэг нийцэж байна вэ?	---	2.5	27.5	37.5	32.5
Б2. Хамгаалах байранд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн орон тоо, бүтэц нь танай байгууллагын үйл ажиллагааны зорилгыг хангахад хэр нийцтэй, хүртээмжтэй байна вэ?	10.0	15.0	27.5	25.0	22.5
Б3. Хамгаалах байранд ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг та хэрхэн үнэлэх вэ?	---	2.5	15.0	40.0	42.5

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага нь ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй хэр зэрэг нийцэж байна вэ? гэсэн асуултад тааруу буюу муу гэж хариулсан ажилтан, мэргэжилтнүүд дараах хариултыг өгсөн.

- Ажил давхарддаг, асаргаа давхар хийдэг
- Давхар ажил хийдэг
- Олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулахад оролцдог
- Хүний нөөц дутмаг
- Ажиллах орчин болон хамгаалалт дутмаг

Хамгаалах байранд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн орон тоо, бүтэц нь танай байгууллагын үйл ажиллагааны зорилгыг хангахад хэр нийцтэй, хүртээмжтэй байна вэ? гэсэн асуултад маш муу, муу гэж хариулсан оролцогчдын шалтгааныг авч үзэхэд дараах тайлбарыг өгсөн байна.

- Мэргэжлийн нийгмийн ажилтан ховор ажилладаг, сэтгэл зүйч дутмаг
- 1 өдөрт ээлжийн нэг л ажилтан ажиллаж байгаа
- Оройгоор дуудлага ирдэг тул ээлжийн ажилтан шаардлагатай
- Санхүүжилт байдаггүй
- Хүний нөөц хомс

Хамгаалах байранд ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг та хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад маш муу болон муу гэсэн хариулт харьцангуй бага, дунд зэрэг гэсэн хариулт 15.0 хувьтай байна. Зарим хариултын тайлбарыг авч үзэхэд Мэргэжлийн нийгмийн ажилтнууд бага, мөн мэргэжлийн бус нийгмийн ажилтан хүүхэдтэй зүй бус харилцах явдал их байна.

Тулгамдаж буй бэрхшээл, шаардлагатай хүчин зүйлс

Судалгааны хүрээнд тулгамдаж буй бэрхшээл болон, шаардлагатай хүчин зүйлсийг авч үзсэн ба судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах мэдлэг, ойлголт дутмаг байдаг болохыг дурдсан байна.

Хүснэгт 4.17. ТХБ, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдэд тулгамдаж буй бэрхшээл, санал бодол

Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй	Тийм бол ямар? /бичих/
Б4. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаа нарт хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдлэг дутмаг байдаг.	18/45.0%	22/55.0%	ажиллах чадвар дутмаг, бэлгийн хүчирхийллийн сэтгэл зүйн үйлчилгээ дутмаг, олон төрлийн кейс тохиолддог тул хүндрэлтэй, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд дутмаг, хандлага мэдрэмж дутмаг байдаг, хохирогч хүүхдийн ахин хохирох тохиолдол мэдүүлэг авах зэрэгт гардаг
Б5. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн талаарх мэдлэг ойлголт дутмаг байна.	17/42.5%	23/57.5%	байнгын сургалтад хамрагдах шаардлагатай, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллахад дутмаг мэдээллээр хангах, нийгэмд мэдлэг дутуу байна, хохирогч эрх зүйн мэдлэг дутмаг байдаг, Хүүхэд хамгаалуулах эрхтэй гэдгээ мэддэггүй
Б6. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй хэрхэн ажиллах арга зүй, аргачлал дутмаг.	18/45.0%	22/55.0%	Ажилтнуудыг мэргэшүүлэх, БХ хохирогч сэтгэл зүйн хувьд хүндрэлтэй байдаг учир удаан хугацааны үйлчилгээ шаардлагатай байдаг. Түүнд мэргэжилтний хүрэлцээ арга аргачлал бага байдаг төрөлжсөн хууль, журам, дүрэм дутмаг үйлчлүүлэгч бүр өөр өөрөөр мэдүүлэх хандлагатай, чадвар дутмаг, чадавхжуулах
Б7. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах ажил үүргийн уялдаа холбоо тааруу байна.	16/40.0%	23/57.5%	бүх хохирогч хүүхэд зарим нь л хэрэг нь хаагддаг, шат шатандаа тааруу, сайн биш, чиглэл өгөх
Б8.Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулахгүй найдвартай явуулахад хүний нөөцийн чадавх, мэргэжлийн ур чадвар хангалтгүй	21/52.5%	18/45.0%	ажлын ачаалал их үед үйлчилгээ үзүүлэх цаг байдаггүй ачаалал их, мэргэшсэн хүн тун цөөн, орон тоо дутмаг, сэтгэл зүйч байхгүй, тогтвортой сэтгэл зүйч байхгүй хөгжлийн нийгмийн үйлчилгээ муу үндсэн орон тоогоор 1 НА ажилладаг, хүний нөөц дутмаг, хүний нөөц дутмаг урьдчилан сэргийлэх ажил дутмаг, хүний нөөц мэргэжлийн хүч дутуу, хүний нөөц тогтвор суурьшилгүй байдаг
Б9. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд санхүү, мөнгөний асуудал тулгамдаж байна	23/57.5%	15/37.5%	санхүү, цалин бага, санхүүжилт муу, үйлчилгээ авч буй хохирогчид эм бэлдмэл авах гэх мэт, хувьсах зардал бага, цалин тогтмол биш санхүүжилт гүйцэтгэлээр өгдөг
Б10. Хувь хүний кейсийн төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах үйл ажиллагаа дутмаг байна.	14/35.0%	26/65.0%	олон ажил зэрэг хийдэг, төлөвлөгөөний дагуу ажиллана, хүний нөөц дутмаг

ТХБ, НЦҮТ-өөс үзүүлж байгаа мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар

ТХБ, НЦҮТ-өөс үзүүлж байгаа мэргэжлийн тусламж үйлчилгээний чанарыг 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн гэсэн таван үзүүлэлтээр үнэлүүлсэн ба үндсэн үр дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4.18. ТХБ, НЦҮТ-өөс үзүүлж байгаа мэргэжлийн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Хохирогчдод хэрэгцээтэй эрх зүйн болон бусад мэдээлэл олгох	2.5	5.0	27.5	35.0	35.0
2	Нийгмийн сэтгэл зүйн хямралт байдлыг арилгах	0.0	5.0	30.0	35.0	27.5
3	Нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээ ажиллагаа	0.0	21.1	21.1	42.1	15.8
4	Эрсдэлт хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийх	2.6	5.1	20.5	38.5	33.3
5	Эрсдэлт болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн талаарх мэргэжлийн дүгнэлт хийх	2.6	12.8	20.5	46.2	17.9
6	Эрсдэлт болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод эрсдэлийн менежмент хийх.	2.6	2.6	33.3	46.2	15.4
7	Боловсрол мэргэжил, сургалтын үйлчилгээ	5.1	2.6	20.5	56.4	15.4
8	Бичиг баримттай болоход туслах үйлчилгээ	5.0	7.5	15.0	37.5	35.0
9	Хамгаалах байрнаас гарахаас өмнөх тусламж үйлчилгээ	---	5.0	15.0	32.5	47.5

Хүний нөөцөд тавигдаж буй шаардлага, хангагдаж буй байдал, чиг үүргийн давхцал

ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг, үйл ажиллагааг 360 градусын үнэлгээг ашиглан хийсэн болно. Судалгааны үр дүнгээс үзэхэд ТХБ, НЦҮТ-ийн ажилтнууд чиг үүрэг болон үйл ажиллагаагаа харьцангуй өндөр 80-аас дээш хувьтай үнэлсэн юм.

Хүснэгт 4.19. ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын үйл ажиллагааны үнэлгээ

№	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг	Үнэлгээ				
		1	2	3	4	5
А. Менежер						
1	Хамгаалах байрны үйлчилгээг удирдан чиглүүлэх	0	2.9	14.3	42.9	40.0
2	Байрлах болон явах асуудлыг шийдэх	0	2.9	14.3	45.7	37.1
3	7 хоног тутмын ажилтнуудын хурлыг тэргүүлэх, үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаад мониторинг, үнэлгээ хийх	2.9	5.7	2.9	60.0	28.6
4	Сар бүрийн тайланг бэлтгэх, хянах	0	2.9	5.7	42.9	48.6
5	Бусад ижил төрлийн байгууллагуудтай холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлж зохион байгуулах	0	2.9	17.1	34.3	45.7
Б. Нийгмийн ажилтан/зөвлөгч						
6	Хохирогчтой эхний уулзалт хийх, хамгаалах байрны тухай танилцуулах	0	4.8	4.8	38.1	52.4
7	Байран дотор болон гадуур үйлчилгээ үзүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэхээр хандалтууд хийх	0	0	19.0	47.6	33.3
8	Үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшил амжилтад мониторинг хийх	0	14.3	9.5	57.1	19.0
9	Хэрвээ эх орондоо байгаа үйлчлүүлэгч хамгаалах байрнаас гарснаас хойш 6 сарын турш холбоотой байдаг эсэх	4.8	4.8	28.6	47.6	14.3

В. Сэтгэл зүйч						
10	Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үнэлгээ, оношлох тест хийх	0	0	13.6	36.4	50.0
11	Сэтгэцийн өөрчлөлт өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг тодорхойлон сэтгэц заслын эмчилгээнд явуулах	8.7	4.3	13.0	17.4	56.5
12	Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн асуудалд асуудал тулгарвал менежер бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх	8.3	4.2	4.2	20.8	62.5
Г. Цагдаа, эрх зүйч бол энэ хэсгийг алгасна уу						
13	Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хэрэг бүртгэлд бичиж тэмдэглэх, мэргэшсэн мөрдөн байцаагчтай холбох.	13.0	---	...	47.8	39.1
14	Хохирогч хүүхдийн гэр бүлийн харилцаа, амьдрал ахуйн нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхдийн гэрээр очих, эцэг эхтэй ярилцах.	4.3	13.0	8.7	30.4	43.5
15	Аюулын эрсдэлийн үнэлгээ хийх, нийгмийн ажилтан, эмчтэй хамтран ажиллах.	---	8.7	4.3	34.8	52.2
16	Бэлгийн хүчирхийллийн хохирогчид хууль эрх зүйн мэдээлэл өгөх.	---	17.4	4.3	30.4	47.8
Д. Эмнэлгийн ажилтан бол энэ хэсгийг алгасна уу?						
17	Хохирогчид үзлэг, шинжилгээ оношилгоо хийх, дүгнэлт гаргах.	---	---	9.5	42.9	47.6
18	Хохирогч сэтгэл зүйн болон сэтгэцийн гэмтлийн дараах хямралыг даван туулахад нь сэтгэл зүйчид нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах.	---	4.0	28.0	28.0	40.0
19	Эмчилгээний явцын талаарх бүх мэдээллийн нууцлалыг чанд хадгалах.	---	4.0	16.0	16.0	64.0

Хүний нөөц


Хүний нөөцөд тавигдах шаардлага хэр хангагдаж байгаа талаар тодруулах асуултыг асуухад ТХБ, НЦҮТ-д 24 цагаар ажиллах хүний нөөц хэр хангалттай байдаг, бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах жендэр, хүүхэд хамгааллаар мэргэшсэн байдал зэргийг тааруу буюу муу гэсэн хариулт харьцангуй олон тохиолдож байна.

Хүснэгт 4.20. ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг

№	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	ТХБ, НЦҮТ-д 24 цагаар ажиллах хүний нөөцийн хангалттай байдал	10.3	20.5	28.2	25.6	15.4
2	Нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, шүүхийн шинжээч, цагдаагийн ажилтан сэтгэл зүйч, хуулийн ажилтан бүтэн бүрэлдэхүүнээр ажиллах байдал	2.6	17.9	43.6	20.5	15.4
3	Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах жендер, хүүхэд хамгааллаар мэргэшсэн байдал	2.6	20.5	25.6	35.9	15.4
4	Яаралтай тусламж үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ хүргэхдээ нийтлэг журам, удирдамжийг баримталж ажиллах байдал	---	5.1	15.4	46.2	33.3
5	НЦҮТ, ТХБ-ын үйл ажиллагаанд холбогдох үнэлгээ маягтуудыг ашиглах мэдлэг ур чадварын байдал	---	---	20.5	38.5	41.0

Таны эрхэлж буй ажил албаны чиг үүрэг бусад ажилтны чиг үүрэгтэй давхцдаг уу гэсэн асуултад 20.0 хувь нь Өдөр тутмын үйл ажиллагааны чиг үүргийн давхцал их гардаг, 42.5% нь өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхцал гараад байдаггүй ч шаардлагатай тохиолдол бий гэж хариулжээ.

График 4.4. Ажилтнуудын ажил албаны чиг үүргийн давхцал




Өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхцал байдаггүй, өөр өөрийн ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу үүргээ хэрэгжүүлнэ гэж гурван албан хаагч тутмын нэг буюу 35.0 хувь нь хариулсан байна.

Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг болон ур чадвар, дээшлүүлэх шаардлагатай арга хэмжээ

Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварын үнэлгээний өмнө ТХБ, НЦҮТ-ийн ажилтны ёс зүйн байдлыг үнэлсэн юм. Тус үнэлгээнээс үзэхэд сайн ба маш сайн гэсэн үнэлгээ давамгайлж байна.

График 4.5. ТХБ, НЦҮТ-ийн ажилтны ёс зүйн байдлын үнэлгээ



Мөн ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварт үнэлгээг өгсөн. Хариултаас үзэхэд сайн, маш сайн гэсэн хариултын зэрэгцээ дунд зэрэг гэсэн хариулт өндөр байна. Ялангуяа жендэрийн талаарх ойлголт, мэдлэг болон гэр бүл, бүлэгтэй ажиллах мэдлэг дунд зэрэг гэсэн хариулт өндөр байсан юм.

Хүснэгт 4.21. Ажилтнуудын мэргэжлийн мэдлэг болон үр чадварын үнэлгээ

№	Шаардагдах үр чадвар	Үнэлгээ /1-Маш муу, 5-Маш сайн/				
		1	2	3	4	5
1	Үйлчлүүлэгчийг тайвшруулах, зөвлөгөө өгөх	---	---	17.9	43.6	38.5
2	Гэр бүл, бүлэгтэй ажиллах	2.6	---	30.8	38.5	28.2
3	Жендэрийн талаарх ойлголт мэдлэг	---	2.6	33.3	35.9	28.2
4	Хүний эрхийн ойлголт мэдлэг	---	5.1	12.8	51.3	30.8
5	Гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэг	---	---	12.8	35.9	51.3
6	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг	---	---	10.3	35.9	53.8
7	Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн харилцааны талаарх ойлголт мэдлэг	2.6	2.6	15.4	35.9	43.6
8	Кейс менежментийн талаарх мэдлэг ойлголт	---	7.9	21.1	39.5	31.6
9	Хууль эрх зүйн мэдлэг	---	7.9	21.1	39.5	31.6
10	Багаар ажиллах чадвар	---	2.6	10.5	34.2	52.6

Хүснэгтэд байгаа мэдээллээс харахад 80 гаруй хувь нь хангалттай сайн үр чадвартай гэж өөрсдийгөө үнэлсэн боловч хохирогчид сэтгэлзүйн зөвлөгөө өгөх нь хүний нөөцөд тулгарч байгаа үндсэн бэрхшээл болохыг ганцаарчилсан ярилцлагад оролцогчид дурдаж байсан юм.

ТХБ, НЦҮТ-ийн ажилтан, албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ажлын үр чадварыг дээшлүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай дараах сургалт, арга хэмжээ, дэмжлэгийг дурдсан байна. Үүнд:

- Ажилтнуудыг чадавхжуулах сургалт хийх
- Ажилтнуудын мэдлэг ажиллах чадвар дээшлүүлэхэд зориулагдсан сургалт тодорхой хугацаанд давтамжтай зохион байгуулах
- Ажлын байр үндсэн чиг үүргийн холбоотой гарын авлага гаргах
- Мэргэшсэн алба хаагчаар цахим болон танхимын сургалт явуулах
- Англи хэлний сургалт
- Бусад хамгаалах байрнаас туршлага судлах, танхимаар сургалт авах
- Генограм, эко зураглал хэрхэн ойлгомжтой зурж сурах талаар сургалт
- Зөвлөн туслах арга зүйчээр хангах
- Мэргэжлийн баг, ажиллах таатай орчин бүрдүүлэх
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах сүүлийн үеийн арга, хандлагын сургалт
- Сар бүр сургалтад тогтмол хамруулах
- Сэтгэл зүйн чиглэлээр сургалт авах
- Сургалт зохион байгуулах, ганцаарчилсан сургалтын боломж болон дадлагын байгууллагуудтай уялдааг сайжруулах
- Сургалт хэлэлцүүлэг стресс менежментийн хөтөлбөртэй болох, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах
- Мэргэшүүлэх сургалт болон хэлний бэлтгэлд хамрагдах.
- Шинээр ажилд орсон нийгмийн ажилтнуудад зориулсан сургалт хийх, бэлгийн хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчтэй ажиллах сургалт зохион байгуулах
- Сургалтад тогтмол хамруулж мэдлэгээр хангах, сэтгэл зүй, сэтгэц, хууль эрх зүйн шинэ мэдлэг хэрэгтэй
- Танхимын сургалт, туршлага солилцох уулзалт зохион байгуулах.
- Туршлага судлуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэйчүүдтэй ажиллах арга барилд суралцуулах.
- ТХБ, НЦҮТ-ийн ажилтныг мэргэшүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах үйл ажиллагаа, сургалтыг шат дараалан зохион байгуулах.

- ТХБ-ны нийгмийн ажилтнуудтай уулзалт хэлэлцүүлэг шаардлагатай.
- Хохирогчийн сэтгэл зүйн үйлчилгээ, харилцааны үр чадвар дээшлүүлэх сургалт
- Хууль эрх зүй, хүний эрх, жендэртэй холбоотой сургалтад шат дараалан хамруулах
- Хүүхдүүдтэй тулж харилцах ажилдаг учир өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах
- Хүүхэдтэй ажиллахад хэрэгтэй мэдлэг мэдээлэл байнга өгөх
- Чадавхжуулах сургалт ажил мэргэжлийн онцлогтой стрессийг тайлах, даван туулах сургалт

Дурдсан саналуудаас үзэхэд ТХБ, НЦҮТ-ийн ажилтан, албан хаагчдад хамтын ажиллагаа, сургалт зөвлөгөө болон чадавхжуулах үйл ажиллагаа нэн чухал байгаа нь харагдаж байна.

Хөдөлмөрийн нөхцөл байдал

Санал асуулгын хүрээнд ажилтан албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл байдлыг аюулгүй байдал, шаардлагатай тоног төхөөрөмж, ажлын өрөө тасалгаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал, ажлын цагийн ачаалал зэргээр тодорхойлсон.

Хүснэгт 4.22. Хөдөлмөрийн нөхцөл

№	Үзүүлэлт	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Аюулгүй байдал	5.0	17.5	20.0	30.0	27.5
2	Шаардлагатай тоног төхөөрөмж	2.5	10.0	22.5	40.0	25.0
3	Ажлын өрөө, тасалгаа	---	17.9	30.8	28.2	23.1
4	Эрүүл ахуйн шаардлага хангасан	5.0	12.5	20.0	22.5	40.0
5	Ажлын цагийн ачаалал	5.1	12.8	30.8	23.1	28.2
	Дундаж	4.4	14.1	24.8	28.7	28.7

Хариултаас үзэхэд сайн ба маш сайн гэсэн үзүүлэлтийн нийлбэрийн дундаж 57.4 хувьтай байгаа бол тааруу буюу муу гэсэн хариулт дунджаар 18.5 хувьтай байна.

ТХБ, НЦҮТ-ийн ажилтан, албан хаагчид хариуцаж буй ажил үүрэг, үр чадвартай холбоотой дараах сургалтуудыг явуулах хэрэгцээ байна гэж үзжээ.

- Арга зүй олгох сургалт
- Ажилтнуудыг мэргэшүүлэх, мэдээллээр хангах сургалт
- Ажилтнуудын сэтгэл зүй эрүүл мэнд болон ажлын байрны халшрах хам шинжээс сэргийлэх
- Ажилчдыг чадавхжуулах сургалт, хамтарсан багийн хурал уулзалт
- Байгууллагын удирдлагуудад SASA сургалт авмаар байна
- Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй хэрхэн харилцаж дэмжлэг үзүүлэг туслалцаа үзүүлэх арга зүйн сургалт
- ГБХ сургалт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн сургалт, илрүүлэлтийн сургалтууд авмаар байна.
- жендэр бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах сургалт, сургууль завсардсан хүүхдэд боловсрол олгох сургалт
- Зан төлөвийн өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах
- Мэдлэг дээшлүүлэх сургалт хамруулах

- Мэргэжилтнүүдийн стресс менежмент сүүлийн үеийн арга зүй
- Мэргэжлийн болон ажил үүргийн онцлогоос хамаарсан сургалт
- Стресс даван туулах байгууллага хамт олны уур амьсгалыг нэмэгдүүлэх сайжруулах сургалт
- Стрессээс ангижрах, өөрийгөө хайрлах сургалт
- Сэтгэл зүй, заавал сургалт
- Туршлага солилцох нийгмийн ажилтнуудын уулзалт кейс менежмент чадавхжуулах ажил
- ТХБ-нд 24 цаг болон түүнээс олон цаг хоногоор гардаг ачааллыг ойлгодог байх.
- Ур чадвар олгох, мэдлэг мэдээлэл өгөх шаардлагатай.
- Үйлчилгээ үзүүлэх 7 чиглэлийн дагуу чадавхжуулах сургалт
- Үйлчилгээ авахаар ирж буй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах болон стресс менежмент сургалт авах
- Фотошоп бусад программ
- Хохирогчтой ажиллах сургалтууд авах
- Хөгжлийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр сургалт авах
- Хүүхэдтэй ажиллах арга зүй, хүүхдүүдийн насны онцлог хамрах харилцах арга зүй
- Хэл сурах, мэргэжил дээшлүүлэх
- Хэт стрессээс урьдчилан сэргийлэх даван туулах чадварын талаарх сургалт
- Чадавх дээшлүүлэх, чадавхжуулах сургалт

ТХБ, НЦҮТ-ийн Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартын өнөөгийн байдлыг үнэлэхэд энэхүү судалгаа чиглэсэн юм. Иймд тухайн зорилго, агуулгын хүрээнд хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, ТХБ, НЦҮТ-ийн өнөөгийн нөхцөл байдал, стандартын хэрэгжилтийг ажиглалт ярилцлагад тулгуурлан үнэлж, албан хаагчдын чадавхыг асуумжийн үр дүнд тулгуурлан тодорхойллоо.

Хууль эрх зүйн шинжилгээнээс үзэхэд ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний талаар хууль эрх зүйн орчин бүрдэж, тухайн үйлчилгээний хувьд журам, стандарт батлан гаргасан зэрэг үр дүнгээс үзэхэд Монгол Улсад хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд эрх зүйн орчин сайжирсан болох нь харагдаж байна. Гэвч хууль эрх зүйн хувьд ямар нэг байдлаар зохицуулагдаагүй, эргэлзээтэй зохицуулалтууд байгаа нь цаашид дээрх ойлголтыг нэг мөр болгох, үйлчилгээг ЖСХ-ийн хохирогчтой уялдуулан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэмэлт зохицуулалтууд оруулах хэрэгцээ шаардлага бий болохыг нотолж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэгт нийцүүлэн, ХНХЯ-ны сайдын 2017 оны А/116 тоот тушаалаар Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмыг батлан гаргасан боловч тус журмын 2.5-д заасан Түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, эрэгтэй, эмэгтэй хохирогчдын хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлж байгуулах тухай, мөн стандартын 5.2-д заасан түр хамгаалах байрыг хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэргээр үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэн байгуулж болно гэсэн заалт биелэхгүй, хэрэгжилт хангалтгүй байна. Энэ талаар голлох хууль болох Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.4-д хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг хангана гэж хэт ерөнхий оруулсан. Энд хохирогчдын хэрэгцээ ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогчийн өвөрмөц хэрэгцээ, шаардлагыг харгалзан төрөлжүүлэх талаар тусгаагүй. Мөн төрөлжсөн хамгаалах байр байхгүй байгаа тохиолдолд бэлгийн хүчирхийллийн хохирогчийн өвөрмөц хэрэгцээ, онцлог байдлыг харгалзан үйлчилгээ үзүүлэх талаар тусгаагүй байгаа нь харагдлаа.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн НЦҮТ-өөр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх хувь нь нөхөр болон хамтран амьдрагчийнхаа зүгээс сэтгэл санаа болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байдалтай ирдэг ажээ. Харин ТХБ-д үйлчлүүлж байгаа бага насны хүүхдүүд бэлгийн хүчирхийлэлд өртсөний улмаас ирдэг байна. Хохирогчдод үзүүлсэн үйлчилгээ болон нийгмийн ажилтантай ярилцсан ганцаарчилсан ярилцлагаас дүгнэж үзэхэд НЦҮТ-ийн нийгмийн ажилтнууд ихэвчлэн үйлчлүүлэгчийн анхан шатны хэрэгцээг хангах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, нотлох баримт бүрдүүлэх зэрэг үйлчилгээг түлхүү хүргэж байна. Харин холбон зуучлах үйлчилгээ буюу тэр дундаа сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах, сэтгэл зүйн болон хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах тал дээр дутагдалтай байна.

Хуульд зааснаар НЦҮТ 7 төрлийн үйлчилгээг, ТХБ 6 төрлийн үйлчилгээг үзүүлэхийг заасан. НЦҮТ богино хугацаанд буюу 72 цаг хүртэлх хугацаанд үйлчлэх бол ТХБ нь нэгээс гурван сар

хохирогчийн байрлуулж, аюулгүй байдлыг хангах, нийгэм сэтгэл зүйн, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлдэг. Үйлчилгээний хэрэгжилт нь харьцангуй ялгаатай байна.

Баянгол дүүрэг нь сэтгэл зүйч байхгүй учир зарим кейс тохиолдол дээр гэрээгээр сэтгэл зүйч авч зөвлөгөө өгдөг бол, зарим газарт бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч ирэхэд эрүүл мэндийн байгууллагатай л нийлэхийг чухалчилдаг зэргийг дурдсан.

Нэгж хугацаанд үзүүлэх хүний багтаамжийн хувьд Орхон, Сэлэнгэ аймгуудад зөвхөн 2-3 хан ажилтантай ч, сард 90 орчим хүүхдэд НЦҮТ үйлчилгээ үзүүлснээс үзэхэд мэргэжилтнүүд нь хаанаа ч хүрдэггүй байдал ажиглагдаж байна.

ТХБ-ын хувьд нийгмийн ажилтнууд нь үйлчлүүлэгчийг асран халамжлах, анхан шатны хэрэгцээг нь хангах, нууцлалыг хадгалах, аюулгүй байдлыг нь хамгаалах үйлчилгээг түлхүү үзүүлж байгаа бөгөөд хөгжлийн үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх боломж хомс байгаа нь харагдсан юм. Эдгээр үйлчилгээнүүдийг үзүүлэхэд нийгмийн ажилтны хувийн чадвараас гадна хөрөнгө мөнгө, цаг хугацаа, орчны стандартын асуудал зэрэг санхүүжилттэй холбоотой асуудлууд саад болж байна.

Судалгаанд хамрагдсан нийгмийн ажилтнуудын хувьд ТХБ, НЦҮТ-д тусгагдаж буй төсвийн хэмжээг харьцангуй бага байгаа гэж үзэж байгаа юм. Үйлчилгээ авч буй хүүхдүүд, хохирогчид нь энгийн биш, хэд дахин их үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагатай тулгардаг ажээ.

ТХБ, НЦҮТ-д байрлаж буй ЖСХ-д өртсөн үйлчлүүлэгчидтэй харилцахад нийгмийн ажилтнуудад нийтлэг харилцааны чадвар дутагддаг. Тэр дундаа бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах үед тэдэнтэй харилцаж ярилцах, санаа бодлыг нь ойлгоход хүндрэл учирдаг байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүдэд ТХБ, НЦҮТ-өөр үйлчилгээ үзүүлэхдээ тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх нь дутмаг байна.

НЦҮТ-д үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн хувьд байрлаж буй орчин нөхцөл, аюулгүй байдлаа хамгаалуулж байгаа байдал, холбон зуучлах үйлчилгээнд хамрагдаж байгаа байдал нь хангалтгүй байна. Тэгвэл ТХБ-аар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчид хувийн нууцаа хамгаалуулах, удаан хугацаанд байрлах хугацаандаа нөхөн сэргээх болон, хөгжлийн үйлчилгээ авч байгаа байдал тааруу байгаа нь ажиглагдсан.

Хуульд зааснаар НЦҮТ 7 төрлийн үйлчилгээг, ТХБ 6 төрлийн үйлчилгээг үзүүлэхийг заасан. НЦҮТ богино хугацаанд буюу 72 цаг хүртэлх хугацаанд үйлчлэх бол ТХБ нь нэгээс гурван сар хохирогчийн байрлуулж, аюулгүй байдлыг хангах, нийгэм сэтгэл зүйн, эрх зүйн туслалцаа, зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлдэг. Хэрэгжилт нь харьцангуй ялгаатай байна.

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтан, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгаа, цалин хөлс болон ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах бодит нөхцөл тааруу байгаа нь тоон ба чанарын судалгааны үр дүнгээс харагдсан болно.

Албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны үр дүнгээс харахад 80 гаруй хувь нь хангалттай сайн ур чадвартай гэж өөрсдийгөө үнэлсэн боловч хохирогчид сэтгэлзүйн зөвлөгөө өгөх нь хүний нөөцөд тулгарч байгаа үндсэн бэрхшээл болохыг ганцаарчилсан ярилцлагад оролцогчид дурдаж байсан.

НЦҮТ-ийн нэг онцлог нь эмнэлгийн байгууллага, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, орон нутгийн цагдаагийн хэлтэст түшиглэн байгуулагдсан байх боловч эдгээр байгууллага, НЦҮТ-д зориулсан төсвийн тусгай зүйл анги байхгүй болохоор, эрүүл мэндийн болон цагдаагийн байгууллагууд өөрийн хязгаарлагдмал нөөцөө зохицуулах байдлаар НЦҮТ-ийн ажилтнуудын цалин, бусад зардлыг хариуцсаар иржээ. Үүнтэй холбоотойгоор, ихэнх НЦҮТ-дийн санхүүжилт хангалтгүй байгаа нь үнэлгээгээр харагдсан болно. Иймд бодлогын хувьд НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээний зааг ялгааг илүү тодорхой болгох, аль эсвэл нэгтгэж нэг стандарттай болгох, бодлого, дүрэм журмын хувьд ойлгомжтой хэрэгжүүлж, хяналт тавихад хялбар цөөн тооны дүрэм журамтай болгох зэргээр бодлогын гарц шийдэл хайх шаардлагатай байна.

ЗУРГАА

ЗӨВЛӨМЖ

Хууль, эрх зүйн хэрэгжилтийн үнэлгээ болон судалгааны үр дүн, мэдээлэлд тулгуурлан дараах санал, зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

Хууль эрх зүйн орчныг хангах:

ТХБ, болон НЦҮТ-ийн Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний стандарт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд цаашид анхаарах, тодорхой болгох шаардлагатай дараах асуудлууд байна.

- Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх талаар нарийвчилсан заалт байхгүй, хэт ерөнхий зүйл заалтууд холбогдох гол болон бусад эрх зүйн баримтуудад туссан гэж үзэж байна. Ялангуяа ТХБ болон НЦҮТ зэрэг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тусгасан үйлчилгээг үзүүлдэг боловч статусын хувьд чухам ямар ялгаатай гэдэг нь тодорхой биш байна. Мөн эдгээр төвүүдийн хувьд бие даасан хуулийн этгээдийн шинж байхгүй байгаа нь харагдаж байна.
- Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.5-д заасан тодорхойлолтоор «түрхамгаалах байр» гэж хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан тус хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ гэж тодорхойлсон. Харин Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040;2019) стандартад "...Түр хамгаалах байр гэж гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг гэр бүлийн бусад гишүүдийн хамт байрлуулан амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг нь хамгаалах зориулалт бүхий стандарт хангасан газрыг" хэлнэ гэжээ. Эндээс үзэхэд ТХБ-ны тодорхойлолт, үйлчилгээний талаар харилцан адилгүй ойлголттой байна.
- Харин ямар чиглэлийн төрөлжсөн ТХБ байгуулж болох, түүний хэрэгцээ шаардлагын талаар судалж үзэхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ байгуулах хэрэгцээ шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна. Иймд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид зориулсан төрөлжсөн ТХБ байгуулах нь хэрэгцээ шаардлага нийгэмд байгаа тул, хууль болон журамд бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх ТХБ-ны төрлийг нэмж хуульчилж, журамлаж өгөх шаардлагатай байна.
- Мөн журмын 1.3-д заасан түр хамгаалан байрлуулах үйлчилгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.10-т заасан стандартчилал хэмжилзүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан түр хамгаалах байрны стандартыг хангасан байранд үзүүлэхээр заасан боловч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна.
- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 2.7 дахь хэсгийн хэрэгжилт тааруу байна. Журамд зааснаар шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлж үйлчилгээ үзүүлэхээр журамлаж өгсөн боловч судалгааны үр дүнгээс үзвэл шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх зорилгодоо хүрч чадаагүй байна. Үүний шалтгаан нөхцөл нь ажилчдын цалин бага, мөн боловсон хүчний дутагдалтай байдал, улмаар ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл хангалттай бүрдэж чадаагүй байдал, санхүүжилтийн асуудал, ажлын

ачаалал зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Иймд ажилчдын цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэх, тэдгээрийн ажлын ачааллыг судлах, улсын хэмжээнд шаардлагатай байгаа ТХБ болон НЦҮТ-ийн тоог гаргах, үүнд ажиллах шаардлагатай нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, эрх зүйчийг бэлтгэх, мэргэшүүлэх цогц судалгаа хийх шаардлагатай байна.

- Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмын 5.1 дэх хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна. ТХБ-ны санхүүжилтийг нэг хүнд ноогдох хувьсах зардлаар санхүүжүүлэхээр хууль болон журамд тусгаж өгсөн өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй хэвээр байсаар байна. Үүнээс үүдээд орон тоо дутуу ажиллах, нэг хүнд ноогдох ачаалал их байх, ажилчдын цалин хангамж бага тул хүний нөөцийн тогтворгүй байдал үүсэх, эд материал, хоол хүнс, эм зэрэг үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай наад захын хэрэгцээгээ хангахад төсөв мөнгө, санхүүжилт хүрэлцдэггүй байна. Түүнчлэн сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг хүртээмжтэй үзүүлж чадахгүй байгаа тул ТХБ нь үйлчлүүлэгчдээ цогц үйлчилгээ үзүүлж чадахгүй байна. Иймд ГБХТТХ-д заасан ТХБ болон НЦҮТ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ нэг хүнд ноогдох хувьсах зардлаар тооцох буюу үзүүлсэн үйлчилгээнд нь үндэслэн зардлыг олгодог болох зохицуулалтын хэрэгжилтийг хангах, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн цалин хөлсний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.
- Журмын 5.5.1-д хохирогчийн сэтгэлзүйн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, нөхөн сэргээх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх талаар дурдсан боловч бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллах талаар тусгайлан зааж өгөөгүй.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35.4-т 35.4.Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцох бөгөөд хувьсах зардлыг тооцох журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах, Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040;2019) стандартын 10-д Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцохоор тусгасан байна. Гэвч хувьсах зардал нь шууд төлөвлөхөд бэрхшээлтэй, үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээ, онцлогтой шууд уялдаатай байдлыг харгалзаагүй байна.
- Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага(MNS6040;2019)стандартын 5.1-д түр хамгаалах байр нь тодорхой хугацаагаар байрлуулна гэж заасан боловч НЦҮТ болон ТХБ-ны хувьд кейсийн онцлогоос хамаарч харилцан адилгүй хугацаанд үйлчилгээг хүргэж байгаа юм.
- ГБХТТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т «Нэг цэгийн үйлчилгээ» гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг гэж хуульчилсан байх боловч бодит байдал, практикаас үзэхэд ТХБ болон НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээ төдийлөн ялгаатай биш байна. Энэ нь ч ТХБ болон НЦҮТ-ийн үзүүлэх үйлчилгээг хуульд ижил байдлаар хуульчилж өгсөнтэй холбоотой байна.
- Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журмын 6.5 дахь хэсгийн хэрэгжилт тааруу байна. НЦҮТ-ийг санхүүжүүлэх журам нь ТХБ-ыг санхүүжүүлэх журамтай ижил байдлаар, нэг хүнд ноогдох хувьсах зардлаар санхүүжүүлэхээр хууль болон журамд нь тусгаж өгчээ. Гэтэл өнөөдрийг хүртэл хугацаанд энэ журам хэрэгжээгүй байна. Түүнчлэн эмнэлэг, цагдаа, Шүүх шинжилгээний үндэсний төвд түшиглэсэн НЦҮТ-дийн санхүүжилтийг шийдэхдээ тухайн байгууллагын төсөвт тусгайлан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх төсвийн багцыг баталж, мөрдүүлдэг байхаар хууль болон журамд өөрчлөлт оруулах шаардлагатай.

ТХБ, НЦҮТ-ийн ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартын хэрэгжилт

- Түр хамгаалах байрны үйлчилгээг сайжруулахын тулд тухайн байгууллагад авах эхний арга хэмжээ нь төрөлжсөн мэргэжлийн хүний нөөцийг бий болгох юм. Жишээ нь тухайн байгууллагад эрх зүйч, анхан шатны тусламж үзүүлэх эмчийн орон тоо дутмаг байна.
- Мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлж, үйлчилгээг илүү үр дүнтэй болгоход нөлөөлж байгаа хамгийн чухал зүйл бол ТХБ, НЦҮТ-ийн орчны стандарт юм. Ихэнх ТХБ, НЦҮТ-ийн хувьд үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангаж үйлчилгээгээ үзүүлэхийг хичээж байгаа ч тэдний тав тух, аюул эрсдэлгүй байх хэрэгцээг нь бүрэн хангаж чадахгүй байна. Стандартад нийцээгүй барилгын зохион байгуулалт, ор болон өрөөний хэрэгцээ, тохижуулалт зэрэг нь хохирогчийн унтах, тав тухтай байх гэх мэт анхан шатны хэрэгцээг хангахад саад болж байна. Тиймээс ТХБ, НЦҮТ-ийн орчныг илүү тав тухтай, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн зохион байгуулалттай болгохын тулд үйлчилгээнд суурилсан нэмэлт санхүүжилт шаардлагатай байна.
- Одоогийн ТХБ болон НЦҮТ-ийн санхүүжилт нь улсын төсвөөс гарч байгаа нөхцөлд тулгуурлан нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр байгуулагдсан ТХБ болон НЦҮТ-ыг түлхүү байгуулах, ийнхүү байгуулах түлхэц, хөшүүргийг бий болгох шаардлагатай байна.
- ТХБ, НЦҮТ зэрэг төрөөс хуулиар тогтоосон эрх үүргийн хүрээнд ажиллаж буй эдгээр байгууллагуудын байрны нөхцөл байдлын нэгдсэн стандартыг мөрдүүлэх, шаардлагатай газруудад яаралтай засвар үйлчилгээ хийх, цаашилбал шинээр барих арга хэмжээг авах шаардлагатай.
- ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудал болох гадаад орчны зай талбай, тохижилт аюулгүй байдлын түвшнийг сайжруулах нь чухал байна.
- Мөн тухайн түр хамгаалах байранд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн саадгүй зорчих нөхцөлийг бий болгох шаардлага байна.
- Түр хамгаалах байрны кейс файлыг хадгалах стандарт хангагдахгүй байгаад анхаарч өнөөгийн боломжит нөхцөл байдалд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй. Тухайлбал мэргэжлийн архив бүртгэлийн ажилтны орон тоог бий болгох, архивын өрөөг бий болгох.
- Үзүүлж буй үйлчилгээнээс үйлчилгээний хүртээмж, үйлчилгээний тохиромжтой байдал дээр илүү шинэчлэлийг хийх, мэргэжилтнүүдийг авч ажиллуулах шаардлагатай байна.
- Харьяа газраас төсөвлөгдөж байгаа төсөв одоогийн эдийн засгийн өсөлттэй урвуу хамааралтай учир төсвийн үр дүнтэй зарцуулах боломжгүйг анхаарах хэрэгтэй байна.
- ТХБ, НЦҮТ зэрэг төрөөс хуулиар тогтоосон эрх үүргийн хүрээнд ажиллаж буй эдгээр байгууллагуудын байрны нөхцөл байдлын нэгдсэн стандартыг мөрдүүлэх, шаардлагатай газруудад яаралтай засвар үйлчилгээ хийх, шинээр барих арга хэмжээг авах шаардлагатай байна.
- НЦҮТ, ТХБ-ны тайлан хураалгах үед мэргэжилтнүүд цагийг нь тулган хэлдэг, тайлан хураалгах тогтсон цаг байдаггүй, тайлангийн нэгдсэн загвар байдаггүйг анхаарч цаашид нэгдсэн загвар, хугацаатай болгох шаардлагатай байна.

Мэргэжлийн боловсон хүчнийг чадавхжуулах, дэмжих:

- НЦҮТ-ийн нийгмийн ажилтнуудын хувьд хүний нөөц дутмаг байдгаас болж түлхүү үйлчлүүлэгчид чиглэсэн мэргэжлийн үйлчилгээгээ үзүүлэх боломж бага байдаг. Тухайлбал судалгаанд хамрагдсан нэг НЦҮТ-ийн хувьд ганцхан нийгмийн ажилтан ажилладаг бөгөөд бүхий л үүргээ ганцаараа гүйцэтгэдэг. Тиймээс ажилтны орон тоог нэмж, үйлчилгээг олон мэргэжлийн багаар, хамтран үзүүлдэг болох хэрэгтэй байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах, сэтгэл заслын сургалт гээд янз бүрийн сургалтуудад ажилтнууд нь хамрагддаг. Харин яг бэлгийн хүчирхийллийн хохирогчтой

яаж ажиллах вэ гэсэн сургалт байдаггүйг анхаарч цаашид энэ чиглэлийн сургалт явуулах шаардлагатай.

- Мөн бүх албан хаагчдын бичиг баримт хөтлөлт, бүрдүүлэх, албан бичгийн стандартад сурган чадавхжуулах хэрэгцээ бий.
- Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүдэд зориулсан сэтгэл заслын үйлчилгээ маш их шаардлагатай байдаг. Тухайн үйлчлүүлэгчид хямралд өртсөн, сэтгэл зүйн хувьд хямралд өртсөн байдаг учраас аль болох сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байдаг. ТХБ, НЦҮТ аль аль нь сэтгэл зүйч байхгүй бөгөөд нийгмийн ажилтнууд нь өөрсдөө анхан шатны сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зайлшгүй тохиолдол ч гардаг. Тиймээс байгууллагадаа байнгын сэтгэл зүйчтэй болох эсвэл сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх мэргэжлийн цогц сургалт авах шаардлагатай байна.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээг сайжруулахын тулд авч үзэх зайлшгүй шаардлагатай асуудал бол тухайн байгууллагад ажиллаж байгаа мэргэжилтэн ажилтнуудыг урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хууль эрх зүйн заалтаар бий болгож өгөх, мөн одоо ажиллаж буй мэргэжилтэн албан хаагчдын үр чадварыг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнд тогтмол хамруулдаг байх хэрэгтэй гэж албан хаагчид үзэж байна.
- Байгууллагын зүгээс нийгмийн ажилтнуудыг өөрт байгаа бүхий л нөөц бололцоогоо ашиглан үйлчилгээгээ хүргэдэг байхыг шаарддаг ч ажилтнаа дэмжсэн үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэх таатай орчин нөхцөлийг нь бүрдүүлдэггүй болох нь судалгааны үр дүнгээр нотлогдсон юм.
- Түр хамгаалах байрны мэргэжилтнүүдийн дийлэнх хувь нь шинэ залуу ажлын туршлага бага боловсон хүчин, мэргэжлийн бус албан хаагчид байгаа нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байгаад анхаарч, мэргэжлийн хүний нөөцийг бий болгох явдал чухал байна.
- Цалин орлого, ажлын таатай орчин зэрэг нь ажлын үр бүтээмжид онцгой нөлөөлдөг учраас энэ тал дээр мэргэжилтэн, албан хаагч, нийгмийн ажилтнуудаа дэмжсэн бодлого, шийдвэр хэрэгтэй байна.

Хууль, журам, стандартын баримт бичгүүд

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, УИХ, 2016
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, УБ.2013
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль. УИХ, 2011
4. Нийгмийн халамжийн тухай хууль, УБ. 2012
5. Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ 2016
6. Хүүхэд хамгааллын тухай хууль, УБ.2016
7. Зөрчлийн тухай хууль, УБ.2017
8. Эрүүгийн хууль, УБ.2015
9. Эрүүл мэндийн тухай хууль, УБ.2011
10. НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооноос эрхлэн гаргасан 19 дүгээр зөвлөмжид Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
11. Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол: 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр
12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/116 тоот тушаалаар батлагдсан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам
13. Хууль зүйн дотоор хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/132 хамтарсан тушаалаар батлагдсан Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам
14. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 04 сарын 06 өдрийн А/80, А/32, А/60 тоот тушаалаар батлагдсан “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам
15. ХЗДХЯ, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн аюулгүй байдалд хяналт, тавих журам, 2017
16. ХНХЯ, Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам, 2017
17. ХНХЯ, Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ноогдох хувьсах зардал тооцох тухай, 2020)
18. Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах стандарт. MNS 6040, 2019
19. Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага. MNS6949:2021
20. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт, 2017

Судалгааны материал

UNFPA. (2017). *UNFPA Mongolia*. bit.ly/3juM03R

Б.Буянзаяа. (2021). *Түр хамгаалах байрны хүүхдийг хамгалах, гэрт нь эргэн нэгтгэх үйлчилгээнд хийсэн дүн шинжилгээ*. Улаанбаатар: Б.Буянзаяа.

М.Батбаатар, А.Батхишиг, Ш.Оюунханд, Г.Түмэннаст . (2019). *Жендэрт суурилсан хүчирхийлэл ба нийгмийн ажлын арга зүй*. Улаанбаатар: Ануулин принт.

Х.Энхжаргал. (2017). *Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний*

төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ. Улаанбаатар: НҮБХАС.

Х.Энхжаргал. (2017). *Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ. Улаанбаатар: НҮБХАС.*

ХЗДХЯ. (2017). *Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн аюулгүй байдалд хяналт, тавих журам. Улаанбаатар: ХЗДХЯ.*

ХНХЯ. (2017). *Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам. Улаанбаатар: ХНХЯ.*

ХНХЯ. (2019). *Жендэрт суурилсан хүчирхийлэл . Х. н. яам-Д, Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй (хууд. 10). УБ: Мөнхийг үсэг .*

ХНХЯ. (2020). *Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ноогдох хувьсах зардал тооцох тухай. Улаанбаатар: ХНХЯ.*

ЭМЯ. (2019). *Гэмтэл согог судлалын үндэсний төв . <https://gemtel.mn/>: <https://gemtel.mn/uploads/Unelgee%20mongol.pdf>-ээс Гаргасан*

Х.Энхжаргал, Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, 2017

ХНХЯ, Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй. УБ. 2019

ЭМЯ, Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх эмнэлэгт түшиглэсэн “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвтэй холбоотой бодлогын баримт бичгийн нөхцөл байдлын үнэлгээ. УБ. 2019

ЭМЯ. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн мэдээ. УБ.2019

UNFPA. (2017, UNFPA Mongolia. Retrieved from <https://mongolia.unfpa.org/>:

UNFPA. (2017, October UNFPA Mongolia. Retrieved from <https://mongolia.unfpa.org/>:

ХАВСРАЛТ СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, МАТЕРИАЛУУД

“Охидыг хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартыг үнэлэхдээ төслийн үр шимийг хүртэгч, зорилтот бүлгийн мэргэжилтэн, алба хаагч, холбогдох хүмүүсээс ганцаарчилсан сурвалжилга, чадавхыг үнэлэх асуумж, бүлгийн сурвалжилга болон баримт бичгийн шинжилгээний аргуудыг тус тус ашигласан болно.

Хүснэгт 6. Судалгааны хэрэглэгдэхүүн

	Бүтээгдэхүүн	Тоо хэмжээ	Тайлбар
1	Мэргэжилтэн алба хаагчидтай хийх ганцаарчилсан сурвалжилга	Багц асуулт-1	ТХБ болон НЦҮТ-дийн үзүүлж буй үйлчилгээнд(хүрэлцээ, хүртээмж, уян хатан байдал, тохиромжтой байдал, аюулгүй байдлыг хангаж байгаа байдал, зөвшөөрөл авах, нууцлал хадгалах, мэдээлэл цуглуулах, мэдээллийн удирдлага, бусад салбар байгууллагуудад холбон зуучлах ба зохицуулах гм) үнэлгээ өгөх
2	ТХБ ба НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн чадавхыг үнэлэх асуумж	Багц асуулт-1	ТХБ болон НЦҮТ-ийн хүний нөөцийн чадавхыг үнэлж, шийдэх асуудлуудыг тодорхойлж, зөвлөмж өгөх
3	Оролцсон ажиглалтаар хийх стандарт үнэлгээний маягт	Багц асуулт-1	ТХБ, НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээний одоогийн стандартад үнэлгээ өгөх
4	Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн шинжилгээ хийх	Багц материал	ЖСХ-ийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх ТХБ, НЦҮТ дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх

1. ГАНЦААРЧИЛСАН СУРВАЛЖИЛГА ХИЙХ УДИРДАМЖ

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх сангийн “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, стандартад үнэлгээ хийх зорилгоор Социологийн Боловсрол төвөөс энэхүү судалгааг явуулж байна.

Таны өгсөн мэдээллийн нууцыг Монгол Улсын «Хувь хүний тухай» хуулийн 5-р зүйлийн дөрөв дэх хэсэг болон, «Статистикийн тухай» хуулийн 22-р зүйлийн гурав дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгална.

Ганцаарчилсан сурвалжилгын удирдамж, асуултын чиглэл (Мэргэжилтэн, албан хаагч)

Ярилцлагын тэмдэглэлийн дугаар:
Ярилцлага хөтөлсөн судлаач:
Ярилцлага хийсэн огноо:
Утасны дугаар:

А. Ярилцлагад оролцогчийн хувийн мэдээлэл

1. Аймаг, дүүрэг
2. Сум, хороо
3. Таны ажиллаж буй салбар
4. Таны нас
5. Таны хүйс
6. Таны боловсрол
7. Таны мэргэжил
8. Таны хашиж буй албан тушаал
9. Ажилласан жил

Б. Бүлэг асуултууд

Мэргэжилтэн, албан хаагчаас асуух асуултын чиглэлүүд:

- 1) Та өөрийн ажиллаж буй ТХБ, НЦҮТ-ийн онцлог, төрөл хэлбэр, эрхэлж буй ажлын талаар товч танилцуулна уу?
- 2) Танай байгууллагын ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний стандарт, нийтлэг шаардлагын хэрэгжилтийн өнөөгийн байдал ямар байна вэ?
- 3) ТХБ, НЦҮТ-ийн талаар мэдээлэл өгнө үү?/ажилтан, албан хаагчийн тоо, багтаамж, ЖСХ-ийн хохирогчийн тоо, хүйсээр/

		Хариулт
1	Нийт ажилтны тоо	- Удирдлага..... - Мэргэжилтэн..... - Алба хаагч.....
2	Нэгж хугацаанд үйлчилгээ үзүүлэх хүний багтаамж, хүчин чадал	- Нийт өрөө..... - Гэр бүлийн өрөө..... - Насанд хүрсэн хүн/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../ - Хүүхэд/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../
3	Сард үйлчилгээ авч буй нийт иргэд, хүүхдийн тоо	- Хүний тоо/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../ - Хүүхдийн тоо/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../
4	ЖСХ-ийн хохирогчийн тоо	- Хүний тоо/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../ - Хүүхдийн тоо/Эрэгтэй/...../Эмэгтэй/...../
5	ЖСХ-ийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээ	

4) Та өөрийн ажиллаж буй ТХБ буюу НЦҮТ-ийн үзүүлж буй үйлчилгээнд үнэлгээ өгнө үү?

		Үнэлгээ				
		А	Б	В	Г	Д
1	Үйлчилгээний хүрэлцээ	5	4	3	2	1
2	Үйлчилгээний хүртээмж	5	4	3	2	1
3	Үйлчилгээний уян хатан байдал	5	4	3	2	1
4	Үйлчилгээний тохиромжтой байдал	5	4	3	2	1
5	Үйлчилгээнд аюулгүй байдлыг хангаж байгаа байдал	5	4	3	2	1
6	Зөвшөөрөл авах байдал	5	4	3	2	1
7	Нууцлал хадгалах байдал	5	4	3	2	1
8	Мэдээлэл цуглуулах ба мэдээллийн удирдлага	5	4	3	2	1
9	Салбар байгууллагуудад холбон зуучлах ба зохицуулах байдал	5	4	3	2	1

Код: А.Маш сайн, Б.Зарим талаар сайн, В.Дунд зэрэг, Г.Тааруу, Д.Маш муу

- Дээрх асуултад маш сайн эсвэл маш муу гэж хариулсан шалтгаанаа тайлбарлана уу, яагаад?
- Хамгаалах байранд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн орон тоо, бүтэц, мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь танай байгууллагын үйл ажиллагааны зорилгыг хангахад хэр нийцтэй, хүртээмжтэй байна вэ?
- Өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулахгүй найдвартай явуулахад ямар хүндрэл, бэрхшээл, эрсдэл байна вэ?
- ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд ТХБ, НЦҮТ-д ажиллаж байгаа мэргэжилтнүүдэд нийтлэг ямар ур чадвар дутагдалтай буюу шаардлагатай байна вэ?

В. ЖСХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд тулгарах бэрхшээлүүд

- ЖСХ-ийн хохирогч, даван туулагчдад үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тусгайлсан заавар зөвлөгөө, тэдэнтэй ажиллах арга зүй байдаг уу? Юугаараа онцлог байдаг вэ? Үйлчилгээ үзүүлсэн тухай жишээгээр тайлбарлана уу?
- ЖСХ-ийн хохирогч, даван туулагчдад үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тусгайлсан сургалтад сууж байсан уу? Ямар байгууллагын ямар сургалт байсан бэ?
- ТХБ, НЦҮТ-тэд ирж үйлчлүүлж байгаа ЖСХ-ийн хохирогчдын талаарх ерөнхий шинжүүд

юу вэ? Түүнд хариу арга хэмжээ авахад нийгмийн ажилтнуудын гүйцэтгэж буй гол үүрэг юу вэ? Нийгмийн ажилтнууд эдгээр үүргээ гүйцэтгэхэд, ялангуяа ЖСХ-ийн хохирогчидтой ажиллахад ямар ур чадварт суралцах шаардлагатай вэ?

Г. ТХБ, НЦҮ-ний бүтэц, байрлах хугацаатай холбоотой асуудлууд

- 12) ЖСХ-тэй тэмцэх, ТХБ, НЦҮТ-ийн болон эрх зүйн орчин бүрдсэн эсэх, стандартыг хэрэгжүүлэхэд орон нутагт бүтэц тогтолцооны хувьд тулгарч буй асуудал юу вэ?
- 13) ТХБ, НЦҮТ-д ЖСХ-ийн хохирогчид хэдий хугацаагаар байрлаж байна вэ? Байрлахтай холбоотой орчин нөхцөл, тухтай байдалд таны санаа зовоосон ямар асуудлууд байдаг вэ?
 - а) НЦҮТ 24 цагийн хугацаанд байрлуулах журамтай ч энэхүү хугацаанаас хэтэрвэл ямар арга хэмжээ авдаг вэ? Энэ хугацаанд нийгмийн ажлын ямар үйлчилгээг тухайн хохирогчдод үзүүлдэг вэ? Ямар нэг байгууллагаас, тухайлбал эмнэлэг, ТББ, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг хэрхэн хангаж ажилладаг вэ?
 - б) ТХБ долоогоос -2 сар хүртэлх хугацаанд байрлуулна гэж заасан ч, үүнээс урт хугацаагаар байлгах шаардлага гардаг уу? Тийм нөхцөлд нийгмийн ажилтнууд урт хугацаанд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох зүйлийг хэрхэн зохион байгуулдаг вэ? Ямар нэг байгууллагаас, тухайлбал дүүргийн ГБХЗХ, ТББ-даас туслалцаа, заавар зөвлөгөө авдаг уу?

Д. Үйлчилгээний бүтэцтэй холбоотой хүндрэлүүд

- 14) Нийгмийн ажилтнуудын үзүүлэх үйлчилгээний аль шатанд хүндрэл бэрхшээл ихэнхдээ тохиолддог болохыг асууна. Дараах 5 үйлчилгээ тус бүрээр хүндрэлтэй эсэхийг асуугаад ХҮНДРЭЛТЭЙ гэсэн шатны үйл ажиллагааг тодруулан асууна

	Илрүүлэлт 108, эсвэл хохирогч өөрөө мэдээлэх	Нөхцөл байдлын үнэлгээ (1-5 маягтаар)	Кэйс төлөвлөх	Кэйс шийдвэрлэх дүгнэх	Кэйс хаах
ТХБ					
НЦҮТ					

ТХБ хүндрэлтэй гэж хариулсан шалтгааныг бич?

.....

НЦҮТ хүндрэлтэй гэж хариулсан шалтгааныг бич?

.....

- 15) ТХБ, НЦҮТ-ийн ЖСХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг илүү үр дүнтэй болгохын тулд та юу хийх байсан бэ? сайжруулж болох арга замын талаарх өөрийн санал бодлоо хуваалцана уу?

2. МЭРГЭЖИЛТЭН, АЛБА ХААГЧДЫН ЧАДАВХЫГ ҮНЭЛЭХ АСУУМЖ

(ТХБ ба НЦҮТ-ийн Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч, Цагдаа, Эмч)

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх сан “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, стандартад үнэлгээ хийх, хүний нөөцийн чадавхыг үнэлж, шийдвэрлэх асуудлыг тодорхойлж, зөвлөмж өгөх зорилгоор Социологийн Боловсрол төвөөс энэхүү судалгааг явуулж байна. Та энэхүү судалгаанд идэвхтэй оролцож, асуултад чин сэтгэлээсээ хариулна уу.

Таны өгсөн мэдээллийг Монгол Улсын «Хувь хүний тухай» хуулийн 5-р зүйлийн 4 дэх хэсэг болон, «Статистикийн тухай» хуулийн 22-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хадгална.

А. ЕРӨНХИЙ АСУУЛТ

	Бичих	Код
A01. Аймаг/хотын нэр		
A02. Байгууллагын нэр, хаяг		
A03. Албан тушаал		
A04. Утасны дугаар, мэйл		

Судалгаанд оролцсон				
Он				
Сар				
Өдөр				
Мин				

A05. Таны нас: [.....]

A06. Таны хүйс: 1. Эрэгтэй
2. Эмэгтэй

A07. Таны боловсролын түвшин

1. Дээд
2. Тусгай мэргэжлийн
3. Бүрэн дунд
4. Суурь
5. Бага, боловсролгүй

A08. Таны үндсэн мэргэжил [.....]

A09. Таны ам бүлийн тоо хэд вэ? [.....]

A10. Та тухайн ТХБ/НЦҮТ-д хэдэн жил ажиллаж байна вэ? [.....]

A11. Уг ажлын байранд ажиллах болсон шалтгаан юутай холбоотой вэ?

1. Нийгмийн ажлын мэргэжилтэй
2. Хүчирхийллийн даван туулагч учраас
3. Бусдад туслах чин хүсэлтэй учраас
4. Бусад (нэрлэнэ үү) [.....]

A12. Таны сарын дундаж цалин, орлого хэд вэ? [.....]

А13. Таны цалин орлого өрх, гэр бүлийн хэрэгцээг хангаж чаддаг уу?

1. Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй
2. Өдөр тутмын хэрэгцээгээ л хангадаг
3. Өдөр тутмын хэрэгцээгээ хангаж, дээр нь хэрэгцээтэй зүйлээ авчихдаг
4. Тэдгээрээс гадна үнэ цэнтэй зүйлийг ч авчихдаг
5. Хүссэн зүйлээ авч чаддаг

Б. ҮНДСЭН АСУУЛТУУД

ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудад тавигдах нийтлэг шалгуур, чиг үүрэгтэй холбоотой асуулт

(1-маш муу, 5-маш сайн гэсэн дарааллаар тэмдэглэнэ. Та асуулт бүрд өөрийн үнэлгээг харгалзуулан дугуйлна уу)

Ажлын байрны тодорхойлолт, орон тоо, мэдлэг ур чадвартай холбоотой асуултууд

Асуулт	1	2	3	4	5
Б1. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага нь ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй хэр зэрэг нийцэж байна вэ?	1	2	3	4	5
Яагаад?/бичнэ үү					
Б2. Хамгаалах байранд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн орон тоо, бүтэц нь танай байгууллагын үйл ажиллагааны зорилгыг хангахад хэр нийцтэй, хүртээмжтэй байна вэ?	1	2	3	4	5
Яагаад?/бичнэ үү					
Б3. Хамгаалах байранд ажиллаж байгаа ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг та хэрхэн үнэлэх вэ?	1	2	3	4	5
Яагаад?/бичнэ үү					

Тулгамдаж буй бэрхшээл ба шаардлагатай хүчин зүйлстэй холбоотой асуултууд

Асуулт	Тийм	Үгүй	Тийм бол ямар?/ тодорхой бичих
Б4. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, цагдаа нарт хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдлэг дутмаг байдаг.	1	0	
Б5. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийн талаарх мэдлэг ойлголт дутмаг байна.	1	0	
Б6. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй хэрхэн ажиллах арга зүй, аргачлал дутмаг	1	0	
Б7. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллах ажил үүргийн уялдаа холбоо тааруу байна.	1	0	
Б8. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, өдөр тутмын үйл ажиллагааг тасалдуулахгүй найдвартай явуулахад хүний нөөцийн чадавх, мэргэжлийн ур чадвар хангалтгүй байна.	1	0	
Б9. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд санхүү, мөнгөний асуудал тулгамдаж байна.	1	0	
Б10. Хувь хүний кейсийн төлөвлөгөөний дагуу үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах үйл ажиллагаа дутмаг байна.	1	0	

Б11. ТХБ, НЦҮТ-өөс үзүүлж байгаа мэргэжлийн тусламж үйлчилгээг үнэлнэ үү?. (1-маш муу, 5-маш сайн гэсэн дарааллаар тэмдэглэнэ. Та асуулт бүрд өөрийн үнэлгээг харгалзуулан дугуйлна уу)

№	Тусламж, үйлчилгээний төрөл	1	2	3	4	5
1	Хохирогчдод хэрэгцээтэй эрх зүйн болон бусад мэдээлэл өгөх	1	2	3	4	5
2	Нийгэм сэтгэл зүйн хямралт байдлыг арилгах	1	2	3	4	5
3	Нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйл ажиллагаа	1	2	3	4	5
4	Эрсдэлт хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийх	1	2	3	4	5
5	Эрсдэлт болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийн талаарх мэргэжлийн дүгнэлт гаргах	1	2	3	4	5
6	Эрсдэлт болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод эрсдэлийн менежмент хийх	1	2	3	4	5
7	Боловсрол мэргэжил, сургалтын үйлчилгээ	1	2	3	4	5
8	Бичиг баримттай болоход туслах үйлчилгээ	1	2	3	4	5
9	Хамгаалах байрнаас гарахаас өмнөх тусламж үйлчилгээ	1	2	3	4	5

Б12. ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын үйл ажиллагааг үнэлнэ үү?. (1-маш муу, 5-маш сайн гэсэн дарааллаар тэмдэглэнэ. Та асуулт бүрд өөрийн үнэлгээг харгалзуулан дугуйлна уу)

№	ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын чиг үүрэг	1	2	3	4	5
А. Менежер бол энэ хэсгийг алгасна уу.						
1	Хамгаалах байрны үйлчилгээг удирдан чиглүүлэх	1	2	3	4	5
2	Байрлах болон явах асуудлыг шийдэх	1	2	3	4	5
3	7 хоног тутмын ажилтнуудын хурлыг тэргүүлэх, үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаад мониторинг, үнэлгээ хийх	1	2	3	4	5
4	Сар бүрийн тайланг бэлтгэх, хянах	1	2	3	4	5
5	Бусад ижил төрлийн байгууллагуудтай холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлж зохион байгуулах	1	2	3	4	5
Б. Нийгмийн ажилтан/зөвлөгч бол энэ хэсгийг алгасна уу.						
6	Хохирогчтой эхний уулзалт хийх, хамгаалах байрны тухай танилцуулах	1	2	3	4	5
7	Байран дотор болон гадуур үйлчилгээ үзүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэхээр хандалтууд хийх	1	2	3	4	5
8	Үйлчлүүлэгчид гарсан ахиц дэвшил амжилтад мониторинг хийх	1	2	3	4	5
9	Хэрвээ эх орондоо байгаа үйлчлүүлэгч хамгаалах байрнаас гарснаас хойш 6 сарын турш холбоотой байдаг эсэх	1	2	3	4	5
В. Сэтгэл зүйч бол энэ хэсгийг алгасна уу.						
10	Үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үнэлгээ, оношлох тест хийх	1	2	3	4	5
11	Сэтгэцийн өөрчлөлт өвчний шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг тодорхойлон сэтгэгц заслын эмчилгээнд явуулах	1	2	3	4	5
12	Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн асуудалд асуудал тулгарвал менежер бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэх	1	2	3	4	5
Г. Цагдаа, эрх зүйч бол энэ хэсгийг алгасна уу.						
13	Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хэрэг бүртгэлд бичиж тэмдэглэх, мэргэшсэн мөрдөн байцаагчтай холбох	1	2	3	4	5
14	Хохирогч хүүхдийн гэр бүлийн харилцаа, амьдрал ахуйн нөхцөл байдлыг тодорхойлох, хүүхдийн гэрээр очих, эцэг эхтэй ярилцах	1	2	3	4	5
15	Аюулын эрсдэлийн үнэлгээ хийх, нийгмийн ажилтан, эмчтэй хамтран ажиллах	1	2	3	4	5

16	Бэлгийн хүчирхийллийн хохирогчид хууль эрх зүйн мэдээлэл өгөх	1	2	3	4	5
Д. Эмнэлгийн ажилтан бол энэ хэсгийг алгасна уу.						
17	Хохирогчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх, дүгнэлт гаргах	1	2	3	4	5
18	Хохирогч сэтгэл зүйн болон сэтгэцийн гэмтлийн дараах хямралыг даван туулахад нь сэтгэл зүйчид илгээж нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах	1	2	3	4	5
19	Эмчилгээний явцын талаарх бүх мэдээллийн нууцлалыг чанд хадгалах	1	2	3	4	5

Б.13. Хүний нөөцөд тавигдах шаардлага хэр хангагдаж байгаа талаар тодруулах асуулт

№	Асуулт	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Хангалтгүй	Огт хангалтгүй
1	ТХБ, НЦҮТ-д 24 цагаар ажиллах хүний нөөц хэр хангалттай байдаг вэ?	5	4	3	2	1
2	Нийгмийн ажилтан, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, шүүхийн шинжээч, цагдаагийн ажилтан сэтгэл зүйч, хуулийн ажилтан бүтэн бүрэлдэхүүнээр ажиллах байдал хэр хангалттай вэ?	5	4	3	2	1
3	Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах жендер, хүүхэд хамгааллаар мэргэшсэн байдал хэр вэ?	5	4	3	2	1
4	Яаралтай туламж үзүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ хүргэхдээ нийтлэг журам, удирдамжийг хэр баримталж ажиллаж байна вэ?	5	4	3	2	1
5	НЦҮТ, ТХБ-ын үйл ажиллагаанд холбогдох үнэлгээ маягтуудыг ашиглах мэдлэг ур чадвар хэр байна вэ?	5	4	3	2	1

Б14. Таны эрхэлж буй ажил албаны чиг үүрэг бусад ажилтны чиг үүрэгтэй давхцадаг уу?

1. Өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхцал их гардаг
2. Өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхцал их гараад байдаггүй ч шаардлагатай тохиолдол бий.
3. Өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхцал байдаггүй, өөр өөрийн ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу үүргээ хэрэгжүүлнэ.
4. Бусад

Б15. Өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн давхардал байдаг бол ямар чиг үүрэг, үйл ажиллагаатай давхцаж байгааг тодруулж бичнэ үү.

.....
.....
.....

Б16. Та “ажлын байрны чиг үүрэг”-т тусгагдаагүй өөр ямар ажил үүргүүдийг гүйцэтгэдэг талаар дэлгэрэнгүй бичнэ үү.

.....
.....
.....

Б.17. ТХБ, НЦҮТ-ийн ажилтны ёс зүйн байдлыг Та үнэлнэ үү? /1-Маш муу, 5-Маш сайн/

	5	4	3	2	1
Удирдлага	5	4	3	2	1
Ажилтан, мэргэжилтэн	5	4	3	2	1
Ажилчин, үйлчлэгч	5	4	3	2	1

Б18. Ажилтнуудын дараах мэргэжлийн болон ур чадварт үнэлгээ өгнө үү

№	Шаардагдах ур чадвар	Үнэлгээ /1-Маш муу, 5-Маш сайн/				
		1	2	3	4	5
1	Үйлчлүүлэгчийг тайвшруулах, зөвлөгөө өгөх	1	2	3	4	5
2	Гэр бүл, бүлэгтэй ажиллах	1	2	3	4	5
3	Жендерийн талаарх ойлголт мэдлэг	1	2	3	4	5
4	Хүний эрхийн ойлголт мэдлэг	1	2	3	4	5
5	Гэр бүлийн хүчирхийллийн талаар ойлголт, мэдлэг	1	2	3	4	5
6	Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг	1	2	3	4	5
7	Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн харилцааны талаарх ойлголт мэдлэг	1	2	3	4	5
8	Кейс менежментийн талаарх мэдлэг ойлголт	1	2	3	4	5
9	Хууль эрх зүйн мэдлэг	1	2	3	4	5
10	Багаар ажиллах чадвар	1	2	3	4	5

Б19. ТХБ, НЦҮТ-ийн ажилтан таны мэргэжлийн мэдлэг, ажлын ур чадварыг дээшлүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, дэмжлэгийн талаар бичнэ үү.

.....

.....

.....

ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлох асуулт

Б20. Хөдөлмөрийн нөхцөл байдлын талаарх Таны үнэлгээ?

(1-маш муу, 5-маш сайн гэсэн дарааллаар тэмдэглэнэ. Та асуулт бүрд өөрийн үнэлгээг харгалзуулан дугуйлна үү)

№	Үзүүлэлт	1	2	3	4	5
1	Аюулгүй байдал	1	2	3	4	5
2	Шаардлагатай тоног төхөөрөмж	1	2	3	4	5
3	Ажлын өрөө, тасалгаа	1	2	3	4	5
4	Эрүүл ахуйн шаардлага хангасан	1	2	3	4	5
5	Ажлын цагийн ачаалал	1	2	3	4	5
6	Бусад:	1	2	3	4	5

Б21. Хариуцаж буй ажил үүрэг, ур чадвартай холбоотой сургалтын ямар хэрэгцээ Танд болон танай байгууллагад байна вэ?

.....

.....

.....

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА.

3. ТХБ, НЦҮТ-ИЙН СТАНДАРТАД ОРОЛЦСОН АЖИГЛАЛТААР ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, ҮР ДҮН

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх сан “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, стандартад үнэлгээ хийх зорилгоор Социологийн Боловсрол төвөөс энэхүү судалгааг явуулж байна.

Жич: Судалгааны мэдээллийн нууцыг Монгол Улсын «Хувь хүний тухай» хуулийн 5-р зүйлийн 4 дэх хэсэг болон, «Статистикийн тухай» хуулийн 22-р зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгалах талаар танилцуулна.

Ажиглалтын бланк хөтөлсөн судлаач:
Ажиглалт хийсэн огноо:
Аймаг, дүүрэг
Сум, хороо

А. Ажиглалтын ерөнхий мэдээлэл

А.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ажиглалтын байршил:	
Ажиглалт хийсэн газрын код:	1.Түр хамгаалах байр-5 2.Нэг цэгийн үйлчилгээний төв-7
Судлаачийн нэр:	
Судлаачийн код:	
Он сар өдөр:	

Б.ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Нэг. Байгууллагад тавих нийтлэг шаардлага

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
№	Шалгуур үзүүлэлтүүд	3	2	1
1.	Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг эмзэг, эрсдэлт бүлгийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хоёроос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн, хуулийн этгээдийн гэрчилгээтэй эсэх.	7/58.3%	1/8.3%	2/16.7%
2.	Төрийн эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн эсэх.	7/58.3%	0/0%	3/25%
3.	Зориулалт бүхий өөрийн өмчийн эсхүл урт хугацаанд ашиглах боломжийг гэрээний нөхцөлөөр хангасан түрээсийн байртай эсэх.	11/91.7	0/0%	1/8.3%
4.	Хамгаалан байрлуулах үйлчилгээний журам, ажилтнуудын баримтлах ёс зүйн дүрэм болон хүүхэд хамгааллын бодлоготой эсэх.	11/91.7%	1/8.3%	---
5.	Нийгмийн үйлчилгээ, хохирогч хамгааллын чиглэлээр мэргэжлийн, мэргэшсэн хүний нөөцтэй эсэх;	8/66.7%	3/33.3	---
6.	Нэгээс доошгүй жил үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилт, хөрөнгийн баталгаатай эсэх;	10/83.3%	2/16.7	---

7.	Тухайн байгууллагын удирдлага болон ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол улсын иргэн байгаа эсэх.	12/100%	---	---
8.	Хохирогчид байрлах хугацаанд хэрэглэгдэх эрүүл ахуй, ариун цэврийн хэрэглэл, шаардлагатай тохиолдолд нэг удаагийн гутал, хувцсаар хангадаг эсэх.	8/66.7%	4/33.3%	---

Тайлбар: Нийтлэг шаардлагын 1-р үзүүлэлтийг хоёр байгууллага хангаагүй бөгөөд байргүй, гэрчилгээ байхгүй, тусдаа гэрчилгээгүй гэсэн хариултыг өгсөн. Хэсэгчлэн хангасан нэг байгууллагын хувьд байгуулагдаад нэг жил болж байгаа гэж хариулжээ.

Тайлбар: Нийтлэг шаардлагын 2-р үзүүлэлтийг 3 байгууллага хангаагүй ба магадлан итгэмжлэл байхгүй буюу ороогүй гэж тус тус хариулжээ.

Тайлбар: Нийтлэг шаардлагын 3-р үзүүлэлтийг 1 байгууллага хангаагүй гэж хариулсан бөгөөд сул орон сууцнаас гаргаж өгсөн байр хэмээн хариулжээ.

Тайлбар: Нийтлэг шаардлагын 5-р үзүүлэлтийг хангаагүй нэг байгууллага байгаа бөгөөд сэтгэл зүйч болон эмч дутуу гэж хариулсан байна.

Тайлбар: Нийтлэг шаардлагын 8-р үзүүлэлтийг 4 байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн харилжээ. Үүнд: зарим тохиолдолд ТББ-д хандах шаардлага гардаг, хувцасны нөөц байхгүй гэж тус тус хариулжээ.

Хоёр. Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлага

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Цахилгаан холбоо харилцаа, дэд бүтэц хөгжсөн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжтой төв суурин газрыг түшиглэсэн эсэх.	3/91.7%	1/8.3	
2.	Төвлөрсөн цахилгаан, халуун, хүйтэн ус, бохирын ус зайлуулах инженерийн шугамд холбогдсон буюу зөөврийн усан хангамжтай нөхцөлд нам даралтын зуухаар халаах эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хүйтэн усан сантай байгаа эсэх.	8/66.7	3/25%	1/8.3
3.	Барилга байгууламжийн нэг болон хоёр давхарт байрлах ба аюулгүйн дохиолол, гадаад, дотоод орчныг хянах хяналтын сүлжээтэй, хамгаалалтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагатай гэрээ хийсэн эсэх.	8/66.6%	2/16.7%	2/16.7%
4.	Өрөө, тасалгаа, хонгил нь хаяг, чиглэл заасан тайлбартай, агаарын хэвийн солилцоог хангах ердийн болон механик салхивчтай, байгалийн гэрэлтүүлэгтэй байгаа эсэх.	7/58.3%	5/41.7%	---
5.	Хохирогчийг хүлээн авч ярилцах өрөө (хэсэг), ганцаарчлан зөвлөгөө өгөхөд зориулагдсан дуу чимээ багатай, тав тухтай, камерын хяналттай уулзалтын өрөөтэй байгаа эсэх.	9/75%	2/16.7%	1/8.3%
6.	Ажилтнуудын ажлын өрөө нь компьютер, хэвлэгч, хувилагч, зургийн аппарат, дуу хураагуур, үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг хадгалах цоожтой төмөр шүүгээ хохирогчийн бичиг баримт, үнэт эдлэлийг хадгалах цоожтой сейфтэй, суурин утастай байгаа эсэх.	6/50%	6/50%	---

7.	Гэрийн орчинтой дүйцэхүйц амрах ор бүхий унтлагын өрөөтэй байх ба нэг хүнд ногдох унтлагын өрөөний талбайн хэмжээ 5м кв-аас доошгүй байгаа эсэх.	5/41.7%	6/50%	1/8.3%
8.	Хохирогчийн хамт ирсэн гэр бүлийн гишүүдийг хамт байрлуулж байгаа эсэх.	10/83.3%	---	2/16.7%
9.	Ганцаараа ирсэн хүүхдийг эрэгтэй, эмэгтэй хүйсээр нь тусдаа өрөө, давхарт байрлуулахаар зохион байгуулсан эсэх.	7/58.3%	---	5/41.7%
10.	Түр хамгаалах байранд хохирогчдыг хамт байрлуулах тохиолдолд тухайн кэйсийн онцлогийг харгалзан гэр бүлийн эсвэл бэлгийн хүчирхийллийн хохирогч зэрэг хэлбэрээр зорилтот бүлгээр нь тус тусад нь байрлуулж байгаа эсэх.	4/33.3%	1/8.3%	7/58.4%
11.	Хохирогчид хоорондоо харилцах, хамтдаа чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулалт бүхий амралтын өрөөтэй байгаа эсэх.	7/58.3%	2/16.7%	3/25%
12.	Ажилтнууд ажлын байрандаа тогтмол байгаа эсэх	11/91.7%	1/8.3%	---
13.	Ажилтнууд ажлын цагийг тогтмол барьж байгаа эсэх	12/100%	---	---
14.	Иргэдийг гадаад үзэмжээр ялгаварлан харьцаж байгаа эсэх	7/58.3%	---	5/41.7%
15.	Хохирогч болон ажилтнууд тусдаа ариун цэврийн өрөө, шүршүүртэй байгаа эсэх.	6/50%	2/16.7%	4/33.3%
16.	Өдөр тутам илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдөр, оройн хоолоор үйлчлэх гал тогооны өрөөтэй, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц орчин бүрдүүлсэн байгаа эсэх	10/83.3%	2/16.7%	---
17.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний өвөрмөц хэрэгцээ онцлог байдалд тохирсон түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдсан хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлдэг эсэх	2/16.7%	4/33.3%	6/50%
18.	Түр хамгаалах байранд хүүхэд амрах, тоглох, унтах, хооллох, гар угаах, бие засах нөхцөлийг бүрдүүлсэн байх ба байрны бүх төрлийн тавилга, хэрэгсэл төхөөрөмж хийц нь хүүхдийг бэртэж гэмтээхээс сэргийлсэн эсэх.	9/75%	2/16.7%	1/8.3%
19.	Барилга байгууламж байгаа газар орчныг тойруулаад хашаа, Хамгаалалттай, гаднаас нэвтрэх боломжтой бүх цонхонд хаалт. хөшиг хийсэн. хаалга бүрэн ажиллагаатай, түгжээтэй, гадагшаа онгойддог эсэх	7/58.3%	5/41.7%	---
20.	Өрөө, тасалгаа нь 20 хэмээс доошгүй дулаан байх шаардлагыг хангаж байгаа эсэх.	10/83.3%	2/16.7%	---
21.	Хохирогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эм, багаж хэрэгсэл, халдварт өвчнөөс хамгаалах наад захын шаардлагыг хангах тоног төхөөрөмж, ариутгалын бодисоор хангагдсан эсэх.	9/75%	3/25%	---
22.	Галын аюулын үед 'ММ5 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" стандартын дагуу ажиллаж байгаа эсэх.	9/75%	1/8.3%	2/16.7%

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 2-р үзүүлэлтийг нэг байгууллага хангаагүй (байшинд байдаг, голын уснаас халааж хэрэглэдэг, гадаа нойлтой), хэсэгчлэн хангасан 3 байгууллага байна. (бохир, зөөвөр, дулаан холбогдсон, халуун ус хэрэглэх боломжгүй хүйтэн устай)

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 3-р үзүүлэлтийг хоёр байгууллага хангаагүй, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж тус тус хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 4-р үзүүлэлтийг таван байгууллага хэсэгчлэн хангасан (ганц өрөөтэй багтаамж жижиг дөрвөн ортой, гэрэлтүүлэг муу).

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 5-р үзүүлэлтийг нэг байгууллага хангаагүй (тусдаа сэтгэл зүйчийн зөвлөгөө өгдөг өрөө суманд байхгүй), хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 6-р үзүүлэлтийг зургаан байгууллага хэсэгчлэн хангасан (аппарат хэвлэгч дуу хураагуур байхгүй, сайт байгаа, компьютер, интернэт, хэвлэгч байхгүй, цоожгүй шүүгээтэй) гэж тус тус хариулсан байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 7-р үзүүлэлтийг нэг байгууллага хангаагүй (45 м/кв-т 3 ор), 5 байгууллага хэсэгчлэн хангасан (дөрвөн өрөөтэй, 5м/кв хүрэхгүй) гэж хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 8-р үзүүлэлтийг хоёр байгууллага хангаагүй байна. Зөвхөн үйлчлүүлэгч авдаг, зөвхөн хүүхэд байрлуулдаг гэж хариулсан байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 9-р үзүүлэлтийг таван байгууллага хангаагүй бөгөөд өрөөний хүрэлцээгүй, хүүхэд авдаггүй гэж тус тус хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 10-р үзүүлэлтийг долоон байгууллага хангаагүй(боломжгүй, тусад нь байрлуулах боломжгүй), нэг байгууллага хэсэгчлэн хангажээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 11-р үзүүлэлтийг 3 байгууллага хангаагүй (нэг өрөөтэй), хоёр байгууллага хэсэгчлэн хангасан байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 14-р үзүүлэлтийг 5 байгууллага хангаагүй хэмээн (тэгдэггүй, үгүй) хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 15-р үзүүлэлтийг дөрвөн байгууллага хангаагүй, 2 байгууллага хэсэгчлэн хангасан (шүршүүр байхгүй) байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 17-р үзүүлэлтийг зургаан байгууллага хангаагүй, дөрвөн байгууллага хэсэгчлэн хангасан байна. Тусдаа өрөө байхгүй, одоогоор байхгүй, зөвхөн нойлын өрөө байдаг хэмээн тус тус хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 18-р үзүүлэлтийг нэг байгууллага хангаагүй, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулсан байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 19-р үзүүлэлтийг таван байгууллага хэсэгчлэн хангасан байна. Цонх торон хаалтгүй, цонхтой хаалга байхгүй, гадаа хашаа байхгүй цонх төмөр хаалтгүй хэмээн хариулжээ.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 20-р үзүүлэлтийг хоёр байгууллагын хувьд хэсэгчлэн хангажээ. Хариулсан байдлаас үзвэл тенгэр залган гал түлдэг гэх хариултыг өгсөн байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 21-р үзүүлэлтийг гурван байгууллага хэсэгчлэн хангасан (багаж хэрэгсэл дутуу) байна.

Тайлбар: Барилга байгууламж, орчны эрүүл ахуйн шаардлагын 22-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй (хангагдаагүй, хор байхгүй), нэг байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулжээ.

Гурав. Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлага

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Түр хамгаалах байрны нэг хүнд ногдох хоолны орц, тэжээллэг хэмжээ нь “жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ” ^{МКБ} -ээс багагүй байгаа эсэх.	10/83.4%	1/8.3%	1/8.3%
2.	Түр хамгаалах байранд байрлаж байгаа хүүхдийн хоол, хүнс, унд нь “Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээ”-ний шаардлагад нийцсэн эсэх.	10/83.3%	2/16.7%	---
3.	Түр хамгаалах байрны хоол, унд нь өдөр тутам илчлэг, орц, нормыг хангахуйц өглөөний цай, өдөр, оройн хоолтой эсэх.	10/83.3%	2/16.7%	---
4.	Хоол, хүнс бэлтгэх хэрэгсэл болон хадгалалт нь ариун цэврийн шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэх.	10/83.3%	---	2/16.7%

Тайлбар: Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, мөн адил нэг байгууллага хэсэгчлэн хангадаг хэмээх хариулсан байна. 60280 тав хоногт хоол хүнс, үзүүлэх үйлчилгээ орсон байдаг нь хангалттай биш хангаагүй, өдөрт 5000 төгрөг ноогддог гэж үзэж байна хэмээн хариулжээ.

Тайлбар: Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу тогоочгүй гэж хариулсан байна.

Тайлбар: Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэжээ.

Тайлбар: Түр хамгаалах байрны хоол хүнсэнд тавих шаардлагын 4-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй байна.

Дөрөв. Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалт

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Ор, ширээ, сандал, шүүгээ нь үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан, бат бөх хийцтэй, угааж цэвэрлэхэд хялбар, цайвар өнгөтэй эсэх.	9/75%	3/25%	---
2.	Орны хэмжээнд тохирсон тоос, чийг татдаггүй, жигд гадаргуутай гудас, матраас, ноосон буюу хөвөнтэй материалаар хийсэн хөнжилтэй эсэх.	9/75%	2/16.7%	---

3.	Цагаан хэрэглэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хөвөн бөс даавуун материалтай, цайвар өнгөтэй эсэх.	10/83.3%	1/8.3%	1/8.3%
4.	Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн чанарт жил бүр тогтмол шалгалт, тооллого хийж, шаардлага хангахгүй болсон эд зүйлийг актлан устгаж, шинээр нөхөн хангалт хийсэн эсэх.	11/91.7%	1/8.3%	---
5.	Ариутгах ажиллагаа нь “ММ8 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандартыг хангасан эсэх.	8/66.7%	1/8.3%	2/16.7%

Тайлбар: Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд гурван байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулсан байна.

Тайлбар: Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулжээ.

Тайлбар: Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, нэг байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулт өгчээ.

Тайлбар: Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих шаардлагын 4-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хэсэгчлэн хангасан гэжээ.

Тайлбар: Хатуу, зөөлөн эдлэлийн хангалт, үйлчилгээ түүний ашиглалтад тавих шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй, нэг байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн тус тус хариулсан байна.

Тав. Санхүүжилт

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлыг нэг хүнд ногдох хувьсах зардлын хэмжээгээр тооцож байгаа эсэх.	9/75%	---	3/25%
2.	Санхүүжилт, хандив, тусламж хүлээн авах, зарцуулах, ил тод тайлагнах журамтай эсэх.	8/66.7%	2/16.7%	1/8.3%
3.	Жил тутамд үйл ажиллагаа болон санхүүгийн хөндлөнгийн аудит хийлгэдэг эсэх.	9/75%	3/25%	---

Тайлбар: Санхүүжилтийн хувьд тавих шаардлагын 1-р үзүүлэлтэд гурван байгууллага хангаагүй гэж хариулжээ.

Тайлбар: Санхүүжилтийн хувьд тавих шаардлагын 2-р үзүүлэлтэд нэг байгууллага хангаагүй, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулсан байна.

Тайлбар: Санхүүжилтийн хувьд тавих шаардлагын 3-р үзүүлэлтэд гурван байгууллага хэсэгчлэн хангасан гэсэн байна.

Зургаа. Хүний нөөц

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Түр хамгаалах байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон тогооч орон тоогоор ажиллаж байгаа эсэх.	4/33.3%	7/58.3%	---
2.	Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалан байрлуулах төрөлжсөн хамгаалах байранд 11.1-т заасан мэргэжилтнүүдээс гадна эмнэлгийн мэргэжилтэн орон тоогоор ажиллаж байгаа эсэх.	3/25%	3/25%	6/50%
3.	Түр хамгаалах байрны хүчин чадал, санхүүжилтээс шалтгаалан хүүхэд хамгааллын ажилтан, халамжийн ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч, харуул хамгаалалтын ажилтныг гэрээгээр ажиллуулж байгаа эсэх.	3/25%	5/41.7%	4/33.3%
4.	Ажилтнууд нь хөдөлмөрийн гэрээ, үйлчилгээний чиг үүрэг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүхий ажлын байрны тодорхойлолт, баримтлах ёс зүйн дүрэмтэй байгаа эсэх.	5/41.7%	4/33.3%	3/25%
5.	Ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх бодлоготой байх ба нийт ажилтанд жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэн баталгаажуулсан байгаа байдал.	5/41.7%	4/33.3%	3/25%
6.	Ажилтнуудыг мэргэшүүлэх шаталсан багц сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлдэг эсэх.	9/75%	3/25%	---
7.	Бүх ажилтныг хагас жил тутам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулдаг эсэх.	7/58.3%	2/16.7%	3/25%
8.	Ажилтан бүр нь гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн газрын тодорхойлолттой байгаа эсэх.	10/83.3%	1/8.3%	1/8.3%
9.	Архины хамааралтай, мансууруулах бодис хэрэглэдэг, сэтгэцийн болон нийгмийн халдварт өвчтэй хүн ажиллуулахыг хориглосон эсэх.	11/91.7%	---	---
10.	Ажилтан нь түр хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх ажилтны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх.	9/75%	1/8.3%	1/8.3%
11.	Ажилтан нь үйлчлүүлэгчийн хувийн аюулгүй байдал, орон зайг хамгаалж, нууцыг хадгалж ажилладаг эсэх.	12/100%	---	---

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 1-р үзүүлэлтэд долоон байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулт өгсөн байна. Мэргэжлийн нийгмийн ажилтан байхгүй, сэтгэл зүйч, эрх зүйч ажилладаг, тогооч байхгүй байна хэмээн тус тус хариулт өгсөн байна.

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 2-р үзүүлэлтэд зургаан байгууллага хангаагүй (байхгүй), гурван байгууллага хэсэгчлэн хангасан буюу сумын эрүүл мэндийн эмч ажилладаг хэмээн хариулсан байна.

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 3-р үзүүлэлтэд дөрвөн байгууллага хангаагүй (ажилладаггүй өрхийн эмнэлэгтэй хамтарч ажилладаг), (эмч цагдаа харуул хамгаалалтын ажилтан байхгүй), таван байгууллага хэсэгчлэн хангасан гэж тус тус хариулсан байна.

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 4-р үзүүлэлтэд гурван байгууллага хангаагүй, дөрвөн байгууллага хэсэгчлэн хангасан (мэргэжлийн бус хүмүүс ажилладаг) хэмээн хариулжээ.

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 5-р үзүүлэлтэд гурван байгууллага хангаагүй, дөрвөн байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулсан байна.

Тайлбар: Хүний нөөцийн хувьд тавих шаардлагын 7-р үзүүлэлтэд гурван байгууллага хангаагүй, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан (бүтэн жилд нэг удаа) гэж тус тус хариулт өгчээ.

Долоо. Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ нь үнэ төлбөргүй байгаа эсэх.	12/100%	---	---
2.	Хохирогч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандаж, онцлог байдал, ялгаатай хэрэгцээг харгалзан үзэж байгаа эсэх.	12/100%	---	---
3.	Хохирогчийг нас, хүйс, гарал үүсэл, нийгмийн статус, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, шашин, улс төрийн үзэл бодол, санхүүгийн боломж зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглон ажиллаж байгаа эсэх.	11/91.7%	---	1/8.3%
4.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан зэрэг өвөрмөц хэрэгцээтэй үйлчлүүлэгчид тохирох хэрэгслээр хангаж, хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэх.	3/25%	4/33.3%	4/33.3%
5.	Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээг үзүүлэх ба байрлах хугацаанд нь боловсролын үйлчилгээнд тасалдалгүй хамруулан ажилладаг эсэх.	9/75%	1/8.3%	1/8.3%
6.	Түр хамгаалах байранд эхэлж байрлахад болон хамгаалах байрнаас гарах үед аюулын зэрэг болон нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулгүйн төлөвлөгөө гаргаж, хохирогчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн хамтарсан багтай хамтран ажилладаг эсэх.	11/91.7%	---	---
7.	Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээ өндөр, амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй тохиолдолд хамгаалалтыг өндөржүүлж, хохирогч зөвшөөрөх эсэхийг үл харгалзан хуулийн байгууллагад мэдэгдэж холбогдох хамгаалалтын арга хэмжээнд хамруулдаг эсэх.	11/91.7%	---	---
8.	Хохирогчид хамааралтай аливаа шийдвэр гаргахдаа тэдний санал, оролцоог хангаж сонголтыг нь хүндэтгэж үздэг эсэх.	11/91.7%	---	---
9.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ болон бусад үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль, тогтоомжийг мөрддөг эсэх.	11/91.7%	---	---

Тайлбар: Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагын 4-р үзүүлэлтэд дөрвөн байгууллага хангаагүй (байхгүй, нөөц бололцоогоороо дутмаг, орчин бүрдээгүй), мөн адил дөрвөн байгууллага хэсэгчлэн хангасан (эрүүл мэндийн байдлаас нь шалтгаалдаг) хэмээн хариулжээ.

Тайлбар: Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, мөн нэг байгууллага хэсэгчлэн хангасан гэсэн хариулт өгчээ.

Найм. Түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлага
(Хохирогчийг хүлээн авах бүртгэх)

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Түр хамгаалах байранд хохирогчийг хүлээн авахдаа "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг баримталдаг эсэх.	11/91.7%	---	---
2.	Түр хамгаалах байранд хохирогчийг хүлээн авахдаа "Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг баримталдаг эсэх.	11/91.7%	---	---
3.	Түр хамгаалах байранд хүлээн авах боломж байхгүй, эсхүл нууцлал алдагдсанаас уг байранд байрлах боломжгүй тохиолдолд хохирогчид нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлэх өөр байгууллага руу холбон зуучилдаг эсэх.	10/83.3%	1/8.3%	---
4.	Анх удаа ирж буй хохирогчийг товч асуулгын дагуу бүртгэж, хувийн хэрэг нээдэг эсэх.	11/91.7%	---	---
5.	Давтан ирж буй хохирогчийг өмнөх бүртгэлийн дугаарт бүртгэн, шинэчилсэн бүртгэл, үйл явцын тэмдэглэл, нотлох баримт зэргийг нэмж хавсаргадаг эсэх.	11/91.7%	---	---
6.	Хохирогчийн гарын үсэгтэй өргөдөл, хүсэлт, түүний гэмтэл бэртлийг харуулсан зураг, бичлэг, тэмдэглэл болон эмнэлэг, цагдаагийн байгууллага, шүүх, бусад байгууллагаар үйлчлүүлсэн мэдээлэл, холбогдох баримтын эх хувь эсхүл хуулбарыг хувийн хэрэгт хавсаргадаг эсэх.	11/91.7%	---	---

Ес. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчийн бэртэл, гэмтэл, хүчирхийллийн үл мөрийг тэмдэглэн баримтжуулж, хувийн хэрэгт бүртгэж, анхны яаралтай тусламж үзүүлдэг эсэх.	12/100%		
2.	Нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандаж, хамтран ажилладаг эсэх.	11/91.7%	1/8.3%	
3.	Түр хамгаалах байранд ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээдэг эсэх.	7/58.3%	5/41.7%	
4.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4- т зааснаар хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллаж, мэргэжлийн дүгнэлт гаргадаг эсэх.	8/66.7%	1/8.3%	2/16.7%
5.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн, холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулахаар хүргүүлэн, нэгдсэн тайлан мэдээ гаргадаг эсэх.	9/75%	1/8.3%	2/16.7%

Тайлбар: Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд таван байгууллага хэсэгчлэн хангасан буюу эмч байхгүй хэмээн хариулсан байна.

Тайлбар: Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлагын 4-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй буюу эмчгүй, нэг байгууллага хэсэгчлэн хангасан буюу эмч магадлагаа бичнэ гэж хариулжээ.

Тайлбар: Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд тавих шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй (эмчгүй), нэг байгууллага хэсэгчлэн хангасан (хариуцсан хүн байдаггүй) хэмээн тус тус хариулсан байна.

Арав. Сэтгэлзүйн үйлчилгээ

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээг дуусгах бүхий л үе шатанд сэтгэлзүйн дэмжлэг, тусламж, үйлчилгээг үзүүлдэг эсэх.	11/91.7%	1/8.3%	---
2.	Асуудлыг тодорхойлох, бие даан шийдвэр гаргахад нь хохирогчид дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд сэтгэл заслын үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажилладаг эсэх.	10/83.3%	2/16.7%	---
3.	Цагдаа, хуулийн байгууллагын мэдүүлэг, байцаалт, эмчийн үзлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд хохирогчийн сэтгэлзүйг бэлддэг эсэх.	10/83.3%	2/16.7%	---
4.	Хохирогчид сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдлаа хамгаалах, өөрийн үнэлэмжээ дээшлүүлэх, нийгэм сэтгэл зүйн хувьд хүчирхийлэлд өртөхөөс өмнөх хэвийн байдалд эргэн ороход нь хамтарсан баг дэмжлэг үзүүлж ажилладаг эсэх.	10/83.3%	2/16.7%	---

Тайлбар: Сэтгэл зүйн үйлчилгээнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан (сэтгэл зүйч) хэмээн хариулжээ.

Тайлбар: Сэтгэл зүйн үйлчилгээнд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу ховор тохиолдолд хэмээжээ.

Тайлбар: Сэтгэл зүйн үйлчилгээнд тавих шаардлагын 4-р үзүүлэлтийн хувьд мөн адил хоёр байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулжээ.

Арван нэг. Хуулийн зөвлөгөө, туслалцаа

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээг дуусгах бүхий л үе шатанд хуулийн зөвлөгөө, эрхзүйн туслалцаа үзүүлж, шаардлагатай тохиолдолд өмгөөллийн үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажилладаг эсэх.	11/91.7%	---	1/8.3%
2.	Хохирогч өргөдөл, гомдол, хүсэлт, нэхэмжлэлээ биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан эрх бүхий байгууллагад гаргах, холбогдох баримт бичгийг бүрдүүлэхэд аргагүйн дэмжлэг, туслалцаа үзүүлдэг эсэх.	12/100%	---	---
3.	Шаардлагатай тохиолдолд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцдог эсэх.	9/75%	1/8.3%	2/16.7%

Тайлбар: Хуулийн зөвлөгөө туслалцаанд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй, нэг байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулжээ.

Арван хоёр. Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн нийгмийн ажилтантай хамтран нөхцөл байдлын үнэлгээ хийж, хохирогч тус бүрд үйл явцын тэмдэглэлийг гараар хөтлөн, генограмм болон эко зураглал хийдэг эсэх.	8/66.7%	3/33.3%	1/8.3%
2.	Хохирогчийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх. нийгмийн халамжийн шаардлагатай дэмжлэг, туслалцаанд хамруулах зэргээр чадавхжуулах үйлчилгээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг эсэх.	5/41.7%	5/41.7%	2/16.7%
3.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ дуусгавар болсны дараа хохирогчийг харьяа нутаг дэвсгэрийн хамтарсан багт хүлээлгэн өгдөг эсэх.	10/83.3%	1/8.3%	---
4.	Бие даан амьдрах чадвар нь түр болон урт хугацаагаар алдагдаж, бусдын асаргаа шаардлагатай болсон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг харгалзан хувийн ариун цэврийг хангах, хооллох зэрэг өдөр тутмын амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн асран халамжлах үйлчилгээ үзүүлдэг эсэх.	11/91.7%	1/8.3%	---

Тайлбар: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, гурван байгууллага хэсэгчлэн хангасан буюу мэргэжлийн зөвлөгөө өгөх үр чадварыг дээшлүүлэх шаардлагатай, Нөхцөл байдлын үнэлгээг цөөхөн хамтарсан баг хийдэг хэмээн тус тус хариулсан байна.

Тайлбар: Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хангаагүй, таван байгууллага хэсэгчлэн хангасан хэмээн хариулсан байна.

Арван гурав. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хүүхэдтэй холбоо харилцаа тогтоож, хүүхэд нэг бүрийн эрх хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээ үзүүлдэг эсэх.	10/83.3%	2/16.7%	---
2.	Эцэг эхээсээ тусдаа, бие даан ирсэн хүүхдийн хувьд түр хамгаалах байр нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хариуцлага хүлээдэг эсэх.	11/91.7%	---	1/8.3%
3.	Хүүхдийг сургууль, цэцэрлэг завсардалтаас урьдчилан сэргийлж, сургуулийн өмнөх боловсрол, албан болон албан бус сургалтад хамруулах, сургуулийг солих, шилжүүлэх, тасралтгүй боловсролоор хангах ажлыг зохион байгуулдаг эсэх.	9/75%	2/16.7%	1/8.3%

Тайлбар: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу цогц үйлчилгээ хүргэхэд анхаардаг ч үр чадвар дутуу гэж хариулсан байна.

Тайлбар: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу хүүхэд авдаггүй хэмээн хариулжээ.

Тайлбар: Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд тавих шаардлагын 3-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу хэрэглэгдэхүүн боломж дутмаг, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу шаардлагатай бол бичиг баримт бүрдүүлэхэд тусалдаг хэмээжээ.

Арван дөрөв. Холбон зуучлах үйлчилгээ

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, хүчирхийллийн улмаас учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд эргэн оруулах, нөхөн сэргээх зэргээр хүчирхийллийг даван туулж дуустал нь тасралтгүй дэмжих зорилгоор бусад байгууллага, үйлчилгээнд холбон зуучилдаг эсэх.	10/83.3%	2/16.7%	---
2.	Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тухай мэдээллээр хохирогчийг хангаж, түүний санал, сонголтыг харгалзан үздэг эсэх.	12/100%	---	---
3.	Үйлчилгээ үзүүлэхдээ «холбон зуучлах үйлчилгээний журам» ¹² -ыг баримталдаг эсэх.	12/100%	---	---

Тайлбар: Холбон зуучлах үйлчилгээнд тавих шаардлагын 1-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулсан байна.

Арван тав. Үйлчилгээг дуусгах

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Үйлчилгээг дуусгах явцад аюулын зэргийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн аюулгүйн төлөвлөгөөг хохирогчтой хамтран боловсруулдаг эсэх	10/83.3%	1/8.3%	
2.	Үйлчилгээг дуусгаж, кейс хаах, шилжүүлэх бүрд харьяа сум, хороо, багийн Хамтарсан багтай хамтран Нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулын зэргийг үнэлэх ажлыг дахин хийж, хүлээлгэн өгдөг эсэх.	9/75%	1/8.3%	1/8.3%

Тайлбар: Үйлчилгээг дуусгахад тавигдах шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, мөн адил нэг байгууллага хэсэгчлэн хангасан (ТХБ-аас гарахдаа хийдэггүй, гэрийн эргэлтээр очихдоо хийдэг) гэж хариулсан байна.

Арван зургаа. Нууцлалыг хангах

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хамгаалах байрны байршил нууц, нэр хаяггүй байх байдал хангагдсан эсэх.	12/100%	---	---
2.	Хохирогчийг хүлээн авах хэсэг нь хамгаалах байрнаас тусдаа байх шаардлага хангагдсан эсэх.	7/58.3%	2/16.7%	3/33.3%
3.	Хамгаалах байранд зөвшөөрөлгүй гаднын хүн нэвтрэхийг хориглох ба ажлын зайлшгүй шаардлагаар нэвтрэсэн тохиолдолд байгууллагын удирдлагаас зөвшөөрөл авч, нууцлалын гэрээ байгуулах шаардлагыг ханган ажилладаг эсэх.	12/100%	---	---

4.	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон хамгаалах байрны ажилтан, ажиллах хугацаандаа, ажлаас халагдсаны дараа хамгаалах байрны байршил. үйлчилгээ үзүүлэх явцдаа олж авсан хохирогчтой холбоотой мэдээллийг задруулах, мэдээлэл хийхийг хориглон ажиллаж чаддаг эсэх.	12/100%		
5.	Хохирогчийн бүртгэл, тэмдэглэл болон бусад бүхий л бичиг баримт хамгаалалттай орчинд, цоожтой шүүгээнд хадгалдаг эсэх.	8/66.7%	3/25%	1/8.3%
6.	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх байгууллага нь нууцын зэрэглэлтэй баримт бичиг хүлээн авах, хариу өгөх, хадгалах журамтай байгаа эсэх.	9/75%	2/16.7%	1/8.3%
7.	Цахилгаан, сантехник, шугам сүлжээний засвар үйлчилгээ үзүүлэх талаар тусгайлсан нууцлалын гэрээг уг үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байгуулан ажилладаг эсэх.	10/83.3%	2/16.7%	

Тайлбар: Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 2-р үзүүлэлтийн хувьд гурван байгууллага хангаагүй буюу тусдаа байргүй, цагдаа тухайн үйлчлүүлэгчийн авч ирдэг гэжээ. Харин хоёр байгууллага хэсэгчлэн хангасан гэж хариулжээ.

Тайлбар: Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 5-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй буюу цоожгүй, гурван байгууллага хэсэгчлэн хангасан буюу цоож нь эвдэрсэн, цоожгүй шилэн хаалгатай шүүгээнд бичиг баримтууд байдаг хэмээн тус тус хариулсан байна.

Тайлбар: Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 6-р үзүүлэлтийн хувьд нэг байгууллага хангаагүй, хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу журам байгаа ч хавтаснууд цоожгүй хэмээн харилжээ.

Тайлбар: Нууцлалыг хангахад тавигдах шаардлагын 7-р үзүүлэлтийн хувьд хоёр байгууллага хэсэгчлэн хангасан буюу байгууллага дотроо шийддэг гэж хариулт өгчээ.

Арван долоо. Хориглох зүйл

	Үнэлгээ	Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангаагүй
1.	Хохирогчид шашин болон улс төрийн үзэл номлолыг албадан тулгах, сурталчилсан нөхцөл байдал бүрдүүлэхийг хориглон ажилладаг эсэх.	11/91.7%	---	1/8.3%
2.	Хамгаалах байранд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглон ажилладаг эсэх.	12/100%	---	---
3.	Хяналтын камерыг хохирогчийн байрлах өрөөнд байршуулахыг хориглон ажилладаг эсэх.	9/75%	---	3/25%
4.	Хүчирхийлэл үйлдэгчийг нэвтрүүлэх, үйлчлүүлэгчтэй хувийн харилцаа тогтоох, мэргэжлийн ёс зүй, хил хязгаарыг зөрчихийг хамгаалах байрны ажилтнуудад хориглон ажилладаг эсэх.	12/100%	---	---

Тайлбар: Хориглох зүйлсийн 3-р үзүүлэлтийн хувьд гурван байгууллага хангаагүй буюу байршуулдаггүй, өрөө болгон камертай хэмээн тус тус хариулсан байна.

4. БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилтээр Хүүхдийг Ивээх сан “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх, стандартад үнэлгээ хийх зорилгоор Социологийн Боловсрол төвөөс энэхүү судалгааг явуулж байна. Тус судалгаагаар ЖСХ-ийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх ТХБ, НЦҮТ дээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт баримт бичгийн шинжилгээ хийх юм.

4.1. Бодлого, хууль эрх зүйн баримт бичгийн шинжилгээний агуулгын хүрээ

	Хууль	Журам	Стандарт
Түр хамгаалах байр	- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, 2013	- ТХБ үйлчилгээний журам, 2017 - ТХБ нэг хүнд ноогдох хувьсах зардал	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах
Нэг цэгийн үйлчилгээний төв	- Нийгмийн халамжийн тухай, 2012 - Хүн худалдаалахтай тэмцэх тухай, 2012 - Хүүхдийн эрхийн тухай, 2016 - Хүүхэд хамгааллын тухай, 2016	- НЦҮТ байгуулах тухай, 2009 - НЦҮ үзүүлэх, санхүүжүүлэх журам, 2017 - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ журам	стандарт. MNS 6040, 2019 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандарт, 2017

4.2. Судлаач дараах хүснэгтэд тусгасан агуулгын дагуу бодлого, хууль эрх зүйн мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.

№	Агуулга	Тайлбар
1.	ТХБ, НЦҮТ-ийн бодлого, хууль эрх зүйн баримт бичигт ЖСХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх талаар тусгасан байдал	
2.	ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээ, стандартад хийх хяналт, шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө(зорилго, зорилт, хамрагдах байгууллага, нэгж, хэрэгжүүлэх хугацаа, зардал, хамтран оролцох байгууллага)-г судлах	
3.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх, хэрэв боломжгүй тохиолдолд МУЗГ-ын тогтоол, №206-ийн 6.2.1-6.2.3-ийг баримтлах	
4.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ МУЗГ-ын тогтоол, №206-ийн 6.3.1-6.3.5-д заасныг баримтлах	
5.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхдээ дараах шалгуурыг баримтлах болно. Үүнд: Мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх • Зорилтын биелэлт, биелэлтийн түвшин, биелэлтийн үр нөлөө • Гадаад, дотоод хүчин зүйлийг нөлөөллийг үнэлэх • Төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх • Бодлого, хууль эрх зүйн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах санал боловсруулах	

5. ТХБ, НЦҮТ-ИЙН ЖАГСААЛТ

№	Орон нутаг		Статус		Хүүхдийн багтаамж	Холбогдох утасны дугаар	Тайлбар
			ТХБ	НЦҮТ			
1		Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, Түр хамгаалах байр	1		22	89040108	2017 оноос үйл ажиллагаа эхэлсэн.
2		ХУД-ийн ГБХЗХХ-ийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ		1	6	99082536, 88127821	2018 оноос үйл ажиллагаа эхэлсэн.
3		“Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ	1			70119949	
4		Лантуун дохио ТББ “Ид шидийн орон”	1			77076996, 86011066	
5	УБ	БЗД Цагдаагийн 3-р хэлтсийн Нэг цэгийн үйлчилгээ		1	4	99830183, 70150183	
6		СБД Нэг цэгийн үйлчилгээ		1		94016601	
7		ГССҮТ-ийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээ				70180136	
		ЧД-н нэг цэгийн үйлчилгээний төв		1		91040919	
8		Гэр бүлийн хүчирхийллийн хохилогчийг түр хамгаалах байр /Цагдаагийн 107/	1			107,	88074244 /ахмад Батсүрэн/
9	Архангай		1		10	94668379	Аймгийн ГБХЗХГ- ын дэргэд ТХБ ажилладаг.
10	Баянхонгор			1	8	70442122 88393908	ХЭҮТ-ийн харьяа Нэг цэгийн үйлчилгээний төв ТХБ ажилладаг.
11	Баян-өлгий			1	12	99423232 95329500	Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулагдаж, аймгийн Цагдаагийн газрын дэргэд ажиллаж байгаа.

№	Орон нутаг	Статус		Хүүхдийн багтаамж	Холбогдох утасны дугаар	Тайлбар
		ТХБ	НЦҮТ			
12	Булган	1		4	70343389 94115543	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
13	Говьсүмбэр	1		6	99941951	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
14	Говь-Алтай аймаг		1	2	90339339 Ихэр-Од ГБХЗХГ 99894487-Даваадорж Н/А	Эмнэлэг түшиглэсэн Нэг цэгийн үйлчилгээний төвтэй.
15	Дорнод	1		8	70584455 99074223	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
16	Дархан-Уул	1	1	24	99778844 88184751	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
17	Дундговь	1		6	96010665 80116322 90905616	ХЭҮТ-ийн харьяа Түр хамгаалах байр ажилладаг. Уг төвтэй тус аймгийн ЗДТГ, ГБХЗХГ гурвалсан гэрээ байгуулан ажилладаг.
18	Дорноговь	2		С-7 3-4	70522738-Сайншанд 88032134-Сайншанд 99064542-Сайншанд 99411406-Сайншанд 89112271-Саранцэцэг Замын-Үүд 91213313-Энхцэцэг Замын-Үүд	Замын-Үүд сумын Засаг дарга, Цагдаагийн газрын хамтарсан гэрээгээр түр хамгаалах байрыг байгуулан 5,0 төгрөгийн санхүүжилтээр тохижуулах ажлыг гүйцэтгэсэн. Сайншандад
19	Завхан		1	8	96469624 99955950	НҮБ, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр 2014 онд байгуулагдсан Цагдаа түшиглэсэн нэг цэгийн төв байгуулагдсан үйл ажиллагаагаа явуулж байгаа.

№	Орон нутаг	Статус		Хүүхдийн багтаамж	Холбогдох утасны дугаар	Тайлбар
		ТХБ	НЦҮТ			
20	Орхон	1		4	88352324 99653018	Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс хариуцдаг. /“Оюу” сэтгэц наркологийн эмнэлэг аймгийн Засаг даргатай хамтын ажиллагааны гэрээгээр “Түр байр хамгаалах”-ыг 2014 оноос үйл ажиллагаа ажиллуулж байна./ 2020 оны 03 сараас ГБХЗХГ-ын харьяанд ажиллаж байна.
21	Өвөрхангай		1	16	99212348 89323355	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд Нэг цэгийн үйлчилгээ ажилладаг.
22	Өмнөговь	1		4	70532005 88305270 86141515 88255224	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд Нэг цэгийн үйлчилгээ-түр хамгаалах байр ажилладаг. 2019 оны 10 сарын 23-нд үйл ажиллагаагаа эхэлсэн.
23	Сүхбаатар	1		4	70517989 99202008	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг. Зөвлөгөө өгөх төв болгосон. /Өрөө тохижуулсан./ 2019 оны 3 дугаар улирлаас хүн аваагүй.
24	Сэлэнгэ	2		Алтанбулаг-4 Мандал-6	Алтанбулаг-99684695 Мандал-99536561	Сэлэнгэ аймгийн ГБХЗХХ-ийн харьяа Алтанбулаг сумын “Түр хамгаалах байр” Тус “Түр хамгаалах байр” нь Алтанбулаг сумын ЗДТГ, ГБХЗХГ, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар гурвалсан гэрээ байгуулан ажилладаг.
25	Төв	1		4	88062838-Оюунчимэг 99011296-Нарантуяа	Төв аймгийн Цагдаагийн газрын дэргэдэх Түр хамгаалах байр.

№	Орон нутаг	Статус		Хүүхдийн багтаамж	Холбогдох утасны дугаар	Тайлбар
		ТХБ	НЦҮТ			
26	Увс	1		2	99042434-зохицуулагч 99679379-зохицуулагч	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
27	Ховд				99011185	ТХБ, Нэг цэгийн үйлчилгээний төв байхгүй.
28	Хэнтий	1		4	92070103 70563433	Аймгийн ГБХЗХГ-ын дэргэд ТХБ ажилладаг.
29	Хөвсгөл		1	8	70382121 98600137	Түр хамгаалах байр байхгүй. Харин НҮБХАС-ын дэмжлэгтэй Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв” байгуулагдсан. Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг 2018 оны 10 дугаар сарын 26 –нд нээж, үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан зохион байгуулах үүргийг хүлээсэн.
30	Багахангай дүүрэг			6	70491049 70491216 88661861	Албан ёсны түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв байхгүй. 2020 оны 01 сараас шаардлагатай тохиолдолд тусгаарлах өрөө тохижуулан үйлчилгээ үзүүлж байна.
Нийт		20	10			

6. ТХБ БА НЦҮТ-Д МӨРДӨГДӨЖ БУЙ ЖУРМУУД

	Журмын нэр	Баталсан огноо, тушаалын дугаар
1	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам	ХЗДХС, ЭМС, ХНХСайдын 2017-04-06-ны өдрийн А80, А/132, А/60/ тоот тушаал
2	Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам	ХЗДХСайдын 2017-02-14-ний өдрийн А/38 тоот тушаал
3	Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам	ХЗДХСайдын 2017-01-31-ний өдрийн А/25 тоот тушаал
4	Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам	ХЗДХСайдын 2017-01-31-ний өдрийн А/25 тоот тушаал
5	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам	ХЗДХСайдын 2017-2-14-ний өдрийн А/39 тоот тушаал
6	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам	УЕПрокурор, ХЗДХСайдын хамтарсан 2017-02-09-ны өдрийн А/22, А/31 тоот тушаал
7	Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам	ХЗДХС, ХНХСайдын 2017-3-13-ны өдрийн А/56, А/35 тоот тушаал
8	Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам	ЭМСайдын 2017-10-12-ны өдрийн А/394 тоот тушаал
9	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам	ЭМСайдын 2017-10-12-ны өдрийн А/394 тоот тушаал
10	Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам	ЭМСайдын 2017-10-12-ны өдрийн А/394 тоот тушаал
11	Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх журам	ХНХСайдын 2017-04-20-ны өдрийн А/74 тоот тушаал
12	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам	ХНХСайдын 2017-2-23-ны өдрийн А/33 тоот тушаал
13	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам	ХЗДХСайдын 2017-02-06-ны өдрийн А/29 тоот тушаал
14	Холбон зуучлах үйлчилгээний журам	ХНХСайдын 2017-04-20-ны өдрийн А/73 тоот тушаал
15	Хамтарсан багийн ажиллах журам	ХНХСайдын 2016-12-26-ны өдрийн А/328 тоот тушаал
16	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	ХНХС, ХЗДХСайдын хамтарсан 2017-07-04-ний өдрийн А/1201, А/178 тоот тушаал
17	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам	ХЗДХС, ХНХС, ЭМСайдын хамтарсан 2017-03-22-ны өдрийн А/63, А/48, А/106/ тоот тушаал
18	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам	ХНХСайдын 2017-06-23-ний өдрийн А/116 дугаар тушаал
19	Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019	2019 онд шинэчлэн батлагдсан стандарт
20	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/612 дугаар тушаал
21	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам	Монгол Улсын Засгийн газрын 2020-12-16-ны өдрийн 220 дугаар тогтоол.



Save the Children

🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар

☎ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

🐦 Save the Children MN

📺 [HairaarUlgerley](#)